



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

“Эрдэнэс монгол” ХХК, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүн, хувьцаа хуваарилалт, ногдол ашиг олголт”-д хийсэн гүйцэтгэлийн аудит

**“ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ” ХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүн,
хувьцаа хуваарилалт, ногдол ашиг олголт**

КОМПАНИЙН ЭЗЭМШЛИЙН ОРДЫГ АШИГЛАХ НИЙТ
ХУГАЦАА ТОДОРХОЙГҮЙ, НӨӨЦИЙГ ҮНЭЛЭХ БОЛОМЖ
БҮРДЭЭГҮЙ, ХУВЬЦААНЫ НЭРЛЭСЭН ҮНИЙГ ХЭРХЭН
ТОГТООСОН НЬ ТОДОРХОЙГҮЙГЭЭС ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДЭД ОЛГОХ НОГДОЛ АШГИЙГ ТООЦОХ
БОЛОМЖГҮЙ БАЙНА



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2019 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

┐ Аудитын тайланг баталгаажуулах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.39 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, "Эрдэнэс таван толгой" ХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүн, хувьцаа хуваарилалт, ногдол ашиг олголтод хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хоёрдугаар, аудитаар өгсөн албан шаардлагыг гуравдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг УИХ-ын Төсвийн байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, "Эрдэнэс Монгол" ХХК, "Эрдэнэс таван толгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, "Эрдэнэс таван толгой" ХК-д тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч, хэрэгжилт үр дүнг 2020 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга /Л.Оюун-Эрдэнэ/, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд /Д.Сумъяабазар/, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд /Н.Цэрэнбат/, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, "Эрдэнэс Монгол" ХХК, "Эрдэнэс таван толгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, "Эрдэнэс таван толгой" ХК-д тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /Б.Мөнх-Очир/-т даалгасугай.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивт хүлээлгэн өгөхийг аудитын баг /Б.Долгорсүрэн, Б.Хишигтогтох/-т үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Tushaal\2019\A Tushaal\1225GAG2.Docx

07145



А/104

**“Эрдэнэс таван толгой” ХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүн,
хувьцаа хуваарилалт, ногдол ашиг олголт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар
тогтоосон албан шаардлагын жагсаалт**

		/сая төгрөг/	
№	Зөрчлийн товч утга	Албан шаардлагын дугаар	Зөрчлийн дүн
1	2016-2017 онд компанийн бүтцийн өөрчлөлтөөр ажлаас чөлөөлөгдсөн нь эрх зүйн үндэслэлгүй гэсэн шүүхийн шийдвэрийн дагуу нийт 9 ажилтан эргэн томилогдож, ажилгүй байсан хугацааны цалин, ЭМД, НДШ зэрэгт 2017-2018 онд нийт 172.3 сая төгрөгийг байгууллагын цалингийн сангаас олгож үргүй зардал гаргасан.	02/348	172.3
2	Гадаадын бэлтгэн нийлүүлэгч, дотоодын байгууллагуудтай холбоотой нийт 18,459.7 сая төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, тооцоо нийлээгүй.	02/349	18,459.7
3	Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын эмзэг бүлгийн 10 өрхөд 25.0 сая төгрөгийн үнэ бүхий 5н ханатай гэр, 2.0 сая төгрөгийг замын зардалд тус тус зарцуулсан.	02/350	27.0
4	Засгийн газрын 2016 оны 80 дугаар, УИХ-ын 2016 оны 69 дүгээр тогтоолуудын дагуу төрийн өмчийн оролцоотой компанийн ТУЗ-ийн гишүүдийн цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байхаар шинэчлэн жишиг тогтоосон байхад “Эрдэнэс таван толгой” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин жишиг цалингийн хэмжээнээс 2.7 дахин өндөр, мөн ТУЗ-ийн зарим гишүүд компанийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх талаар идэвх санаачилга, үүрэг, оролцоо хангалтгүй, хурлын ирц бүрэн биш байтал цалинг тогтмол олгосон.	02/351	-
5	“Эрдэнэс таван толгой” ХК-ийн дараах зөрчил гаргасан холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах тухай. Үүнд: Цанхийн баруун/зүүн хэсгийн уурхайн уулын ажлын болон хөрсний овоолгын ажлын тоо хэмжээ, хөрсний сийрэгжилтийн коэффициентийн тооцоололд дүн шинжилгээ хийхэд шаардлагатай ажлын тайлан, хөндлөнгийн маркшейдерийн дүгнэлт тайлангуудыг аудитын багт шаардсан хугацаанд мэдээллийг бүрэн гүйцэт, үнэн зөв ирүүлээгүй, Нэмэлтээр ирүүлсэн баримтаар тус компанийн Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлсэн ажлын тайлан, тоо мэдээнд хөрсний овоолгыг дутуу, бүрэн бус тусгасан нь нотлогдож байхад тус компаниас ирүүлсэн албан бичигт аудитын багийг “... огт үндэслэлгүй бөгөөд мэргэжлийн бус, бодит тооцоо, судалгаагүй, нотолгоогүй дүгнэлт хийж, түүнийгээ тайлангийн төсөлд тусгасан”, “тайлангийн төсөлд тусгагдсан огт үндэслэлгүй, алдаатай дүгнэлтээ залруулж /хасч/ тус компанийн бизнесийн нэр хүндэд хор хохирол учруулахгүй байхад анхаарч ажиллахыг хүсье” гэж аудитад нөлөөлөхийг оролдсон; Геологи уул уурхайн газрын холбогдох албан тушаалтнууд нь “Эрдэнэдрийлинг” ХХК, “Монкаротаж” ХХК-тай байгуулсан гэрээнд заасан ажлын тоо хэмжээнээс 176.5 тууш метр өрөмдлөг, геофизикийн ажлыг гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй, эрх бүхий албан тушаалтанд танилцуулж шийдвэр гаргуулахгүйгээр 25.2 сая төгрөгийн ажил гүйцэтгэх зөвшөөрөл олгосон.	02/352	-
6	Уурхайн ашиглалтад өртсөн орон зай, хөрс, нүүрсний овоолгын хэмжээг 2017 онд хөндлөнгийн маркшейдерийн хэмжилтээр баталгаажуулаагүй, Цанхийн баруун, зүүн уурхайн хөрснөөс зам талбай засах, өөр газар шилжүүлсэн зэрэг нийт 8.31 сая м³ хөрсийг үйл ажиллагаандаа зарцуулж, АМГТГ-т хүргүүлсэн АҮАТ-д иж бүрэн, үнэн зөв тайлагнаагүй.	02/357	-
Нийт дүн			18,659.0

**Аудитыг гүйцэтгэсэн:**

Үндэсний аудитын газрын
Гүйцэтгэлийн аудитын газар

Гүйцэтгэлийн аудитын газрын
захирал бөгөөд тэргүүлэх
аудитор

Б.Мөнх-Очир

Аудитын менежер

Б.Саруул

Ахлах аудитор
Б.Хишигтогтох

Аудитор
М.Наранжаргал
Б.Даваабаатар
Ц.Цолмон

Гэрээт ажилтан
Б.Алтангэрэл

Аудитын дүн, дүгнэлт,
зөвлөмжтэй холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж лавлах,
холбогдох саналаа өгөхийг хүсвэл
261456 дугаарын утсаар
харилцана уу.

Аудитын тайланг УАГ-ын
www.audit.mn цахим хуудаснаас
үзнэ үү.

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр
Улаанбаатар хот 15160

2019 оны 12 дугаар сар

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	1
Хүснэгтийн товъёг.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл.....	5
Ерөнхий мэдээлэл.....	6

ТЭЗҮ-Г ОРДЫН ХЭМЖЭЭНД ИЖ БҮРЭН БОЛОВСРУУЛААГҮЙ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ТЭЗҮ-ИЙН ДАГУУ ЯВАГДААГҮЙ, ОЛБОРЛОЛТЫН ХӨЛС ХАРИЛЦАН АДИЛГҮЙ, ИХ ХЭМЖЭЭНИЙ ХАНШИЙН АЛДАГДАЛ ХҮЛЭЭЖ БАЙНА	7
1982-1993 оны хооронд ордын нөөцийг хэсэгчлэн тогтоож баталгаажуулсан байна	7
Таван толгой ордын хэмжээнд ТЭЗҮ-ийг боловсруулаагүй байна 11 ТЭЗҮ-д тусгагдсан хүчин чадал, тоо хэмжээний дагуу бүтээгдэхүүнийг олборлох, ашиглах үйл ажиллагаа явагдахгүй байна.....	13
Хууль тогтоомжийн дагуу нийгмийн хариуцлагын чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.....	22

КОМПАНИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, АЖИЛТНУУД ЧИГ ҮҮРГИЙН ДАВХАРДАЛТАЙ, ДОТООД ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА	24
Компанийн зохион байгуулалт бүтэц, орон тооны өөрчлөлтийг тооцоо судалгаагүйгээр хийж иржээ.....	24
Компанийн 2014-2017 оны дунд хугацааны бизнес төлөвлөгөөний биелэлт хангалтгүй, 34 хувьтай байна	29
Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал, засгийн газар, толгой компанийн уялдаа холбоо муутай шийдвэрүүдээс шалтгаалан дэд бүтэц, хөгжлийн төслүүд хэрэгжээгүй байна.....	31
Компанийн үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн дотоод хяналт үр нөлөөгүй байна	34

БОРЛУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ИХ ХЭМЖЭЭНИЙ ОРЛОГО ОЛОХ БОЛОМЖИЙГ АЛДСАН, ХУВЬЦААНЫ НЭРЛЭСЭН ҮНИЙН ТООЦООЛОЛ ҮНДЭСЛЭЛТЭЙ ЭСЭХИЙГ НОТЛОХ БОЛОМЖГҮЙ БАЙНА	37
Цанхийн баруун, зүүн хэсгийн үнэ харилцан адилгүй, худалдааны нөхцөлийг өөрчлөх замаар өртөг шингээх, борлуулалтын үнийг өсгөх шаардлагатай байна	37
Компанийн эдийн засгийн зарим үзүүлэлт өмнөх онуудаас сайжиржээ.....	44
Батлагдсан төсвийг зарим журмыг зөрчин зарцуулжээ.....	48
Зарим тендер шалгаруулалт холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн, зохион байгуулалт хангалтгүйгээс нэмэлт зардал гарч байна.....	51
Татвар, хураамжийг хууль тогтоомжийн дагуу төлжээ.....	54
Хувьцааны нэрлэсэн үнийн тооцоолол үндэслэлтэй эсэхийг нотлох боломжгүй байна.....	55
Ногдол ашиг хуваарилах шийдвэр гараагүй байна	58

ДҮГНЭЛТ:	59
ЗӨВЛӨМЖ:.....	63
ХАВСРАЛТУУД	66



Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
АМГТГ	Ашигт малтмал газрын тосны газар
АҮАТ	Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө
АМТХ	Ашигт малтмалын тухай хууль
АНУ	Америкийн нэгдсэн улс
ААНОАТТХ	Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗТХЯ	Зам тээвэр хөгжлийн яам
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДМ	Нүүрсний давхаргын метан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
МУ	Монгол Улс
МУХБ	Монгол улсын хөгжлийн банк
СЯ	Сангийн яам
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨӨЗ	Тендерт оролцогчдод өгөх зөвлөмж
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТӨХК	Төрийн өмчийн хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТШӨХ	Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
УИХ	Улсын Их хурал
УУХҮЯ	Уул уурхай хүнд үйлдвэрийн яам
УУХҮС	Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд
УАМНК	Улсын ашигт малтмалын нөөцийн комисс
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ӨМӨЗО	Өвөр Монголын өөртөө засах орон
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ХАБЭА	Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуй
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ШУА	Шинжлэх ухааны академи
ШУТЗ	Шинжлэх ухааны техникийн зөвлөл



ГАГ-2018-11-ГА

“Эрдэнэс монгол” ХХК, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүн, хувьцаа хуваарилалт, ногдол ашиг олголт

ШУТИС	Шинжлэх ухаан техникийн их сургууль
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭБМЗ	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, эрчим хүчний яам
ЭБЭХС	Эрдэс баялаг, эрчим хүчний сайд
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЭЗХЯ	Эдийн засаг хөгжлийн яам
ЭТТ	Эрдэнэс таван толгой



Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	“Эрдэнэс таван толгой” ХК-ийн эзэмшлийн талбайн ордын нөөцийн /давхардсан/ нэгтгэл судалгаа	6
Хүснэгт 2	Нүүрсний ангиллын дагуу давхарга тус бүрийн чанарын үзүүлэлтийг оруулах	9
Хүснэгт 3	“Эрдэнэс таван толгой” ХК-ийн эзэмшлийн ашиглалтын талбайд оногдох ТЭЗҮ-д тусгасан талбай болон үйлдвэрлэлийн нөөцийн судалгаа	11
Хүснэгт 4	ТЭЗҮ-д тусгасан баяжуулах үйлдвэр, цахилгаан станц, төсөл зам, усан хангамжийн хүчин чадлын нэгтгэл	11
Хүснэгт 5	Нүүрсний коксжих шинж чанар	11
Хүснэгт 6	ТЭЗҮ-ийн хөрөнгө оруулалт, төслийн үнэ цэнэ, өгөөжийн дотоод түвшний нэгтгэл	12
Хүснэгт 7	Цанхийн хэсгийн ордын 2011-2012 оны батлагдсан нөөц, ТЭЗҮ-д тусгасан нөөцийн харьцуулсан судалгаа	12
Хүснэгт 8	Цанхийн хэсгийн ТЭЗҮ, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан уулын ажлын харьцуулсан судалгааны нэгтгэл	13
Хүснэгт 9	Цанхийн хэсгийн ТЭЗҮ, уулын ажлын гүйцэтгэлд 1 тн нүүрсний өөрийн өртөг, 1 м³ уулын цулын өртгийг харьцуулсан нэгтгэл.	14
Хүснэгт 10	“Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2017 оны ашиглалтын үйл ажиллагааны анхны төлөвлөгөө, тодотгол хийсэн төлөвлөгөөний харьцуулалт судалгаа	18
Хүснэгт 11	Цанхийн зүүн, баруун хэсгийн 1 м³ уулын цулын үнийн харьцуулалтын нэгтгэл	19
Хүснэгт 12	Цанхийн зүүн хэсгийн гэрээт олборлогчийн гэрээний олборлолтын үнэд өөрчлөлт орсон судалгааны нэгтгэл /ам доллар, төгрөг/	20
Хүснэгт 13	Цанхийн зүүн хэсгийн гэрээт олборлогчтой байгуулсан гэрээг гадаад валютаар хийснээс “Эрдэнэс таван толгой” ХК-д үүссэн ханшийн алдагдлын судалгаа	20
Хүснэгт 14	Цанхийн зүүн хэсгийн үндсэн гэрээт олборлогч болон туслан гүйцгэгчдийн ажлын бүтээлийн нэгтгэл	20
Хүснэгт 15	Цанхийн баруун, зүүн хэсгийн төслийн хаалт, нөхөн сэргээлт, экологи-эдийн засгийн байгаль орчинд учруулах хохирлын нийт хэмжээ, үнэлгээний нэгтгэл	22
Хүснэгт 16	Компанийн нийгмийн хариуцлагыг Олон улсын стандарттай харьцуулсан харьцуулалтын нэгтгэл	23
Хүснэгт 17	Компанийн бүтэц орон тооны өөрчлөлтийн судалгаа /ерөнхий захиргаа/	26
Хүснэгт 18	Зөвлөх, албаны дарга нарын судалгаа	26
Хүснэгт 19	Ажилтнуудын шилжилт, хөдөлгөөн	27
Хүснэгт 20	2014-2017 оны бизнес төлөвлөгөөний стратеги зорилтууд	30
Хүснэгт 21	Экспортын хэмжээ, борлуулалтын орлого	43
Хүснэгт 22	“Эрдэнэс таван толгой” ХК-ийн нийт хөрөнгийн нэгтгэл	43
Хүснэгт 23	“Эрдэнэс таван толгой” ХК-ийн үйл ажиллагааны зардлын төлөвлөгөө гүйцэтгэлийн судалгаа	44
Хүснэгт 24	Компанийн 2016-2017 оны авлагын бүтэц	44
Хүснэгт 25	Авлагын үлдэгдэл баталгаажуулаагүй компаниуд	45
Хүснэгт 26	Зардлын гүйцэтгэл 2016-2017 он	47
Хүснэгт 27	Зээлийн карт эзэмшигчдийн судалгаа	48
Хүснэгт 28	Хувь нийлүүлсэн хөрөнгө	50
Хүснэгт 29	Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	54
Хүснэгт 30	“Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцаатай холбоотой шийдвэрүүд	54
Хүснэгт 31	Бүртгэсэн хувьцааны эзэмшигчдийн судалгаа	55
Хүснэгт 32	Зарласан хувьцааны эзэмшигчдийн судалгаа	56
Хүснэгт 33	Төрд хувьцаагаа худалдсан иргэд, мөнгөн дүн	57
Хүснэгт 34	Хишиг, хувь хүртсэн иргэд, мөнгөн дүн	57

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Метан хий боловсруулах туршилтын үйлдвэр	33
Зураг 2	Нүүрсний борлуулалтын доод үнийг тооцох аргачлал	39



Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	“Эрдэнэс таван толгой” ХК-ийн эзэмшлийн ордод 1981-2012 онд ордын нөөцийг тогтоож, баталж, бүртгэх нөөцийн судалгаа	7
Дүрслэл 2	Цанхийн зүүн хэсгийн 2011-2017 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл	17
Дүрслэл 3	Цанхийн баруун уурхайн 2013-2017 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл	17
Дүрслэл 4	Орон тооны өөрчлөлтийн судалгаа	24
Дүрслэл 5	Нүүрсний зах зээлийн үнэ 2012-2017 он, ам.доллар/тн	37
Дүрслэл 6	Коксжих нүүрс нийлүүлэх гэрээний тоо, дундаж үнэ	40
Дүрслэл 7	Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	46
Дүрслэл 8	Зардлын бүтэц	53



Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

Аудит хийх үндэслэл:

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/125 дугаар тушаалаар батлагдсан ҮАГ-ын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

“Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүн, хувьцаа хуваарилалт, ногдол ашиг олголтод аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах зорилгоор дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагаа үр дүнтэй байгаа эсэх,
- “Эрдэнэс таван толгой” ХК-ийн үйл ажиллагаа үр дүнтэй байгаа эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Аудитад “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн техник, эдийн засгийн үндэслэл, 2016, 2017 оны үйл ажиллагааны болон уулын ажлын төлөвлөгөө, тайлан болон түүврийн аргаар сонгогдсон санхүүгийн баримт материалууд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Засгийн Газрын Хэрэг эрхлэх газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Улсын бүртгэл, оюуны өмчийн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хөрөнгийн бирж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Орон нутгийн засаг, захиргааны нэгж зэрэг байгууллагуудыг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС-300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга, судалгаа авах, тоо баримтыг харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого /2014-2025 он/,
- Ашигт малтмалын тухай хууль,
- Татварын ерөнхий хууль,
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- Компанийн тухай хууль,
- Хөрөнгө оруулалтын тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Бусад

Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнх-Очир удирдаж, аудитын менежер Б.Саруул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Хишигтогтох, аудитор М.Наранжаргал, Ц.Цолмон, Б.Даваабаатар, гэрээт аудитор Б.Алтангэрэл нар мэргэжлийн зөвлөх шинжээчийн багийн хамт гүйцэтгэв.

Хүндрэл бэрхшээл:

“Эрдэнэс таван толгой” ХК-д 2018 онд бүтцийн өөрчлөлт 2 удаа ойр ойрхон хийгдсэнээс ажлын баримт материал, холбогдох мэдээллийг хугацаанд бүрэн гүйцэд гаргаж өгөхгүй удаашрах, холбогдох гэрээнүүд гадаад хэл дээр хийгдсэнээс орчуулга хийж өгөхөд хугацаа алдах, зарим тоо мэдээг цахимаар гаргах өгөхөөс татгалзах, шаардлагатай баримт материалыг аудитын талбарын үе шатанд ирүүлээгүй боловч тайлагналын үе шатанд хугацаа хоцроож ирүүлэх зэргээр хариуцлагагүй хандаж, аудитын үйл ажиллагаанд саад учруулж байлаа.



Ерөнхий мэдээлэл

Тавантолгойн ордод 1978-2012 оны хооронд эрэл үнэлгээ, урьдчилсан болон нарийвчилсан хайгуулын ажлыг гүйцэтгэж чулуун нүүрсний нөөцийг Монгол улсын нөөцийн нэгдсэн санд 4,302.0 сая тн коксжих, 2,978.4 сая тн эрчим хүчний, 247.2 сая тн исэлдсэн нүүрс нийт 7,527.6 сая.тн-оор /нөөц давхацсан/ бүртгэх шийдвэрийг гаргасан байна.

Засгийн газрын 2010 оны 272 дугаар тогтоолын дагуу “Эрдэнэс таван толгой” ХК нь “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани хэлбэрээр 2010 онд байгуулагдсан бөгөөд УИХ-ын 2018 оны 73 дугаар тогтоолоор бие даасан компани болгон Засгийн газрын 2018 оны 245 дугаар тогтоолоор төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг УУХҮЯ 70 хувь, ТӨБЗГ 30 хувь тус тус хэрэгжүүлэхээр тогтоожээ.

Тавантолгойн ордын Цанхийн Баруун, Зүүн хэсгүүд тус бүр 15-20 сая тн нүүрс олборлох ТЭЗҮ-д уулын ажлыг өөрсдийн тоног төхөөрөмж, ажиллах хүчээр гүйцэтгэхээр тусгасан боловч УИХ-ын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1 дүгээр заалтын дагуу Цанхийн баруун хэсэгт “Монгол уурхайчид” түншлэл, “Саусгоби сэндс” ХХК, зүүн хэсэгт “Макмахон монголиа” ХХК, “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК тус тус гэрээт олборлогчоор ажиллажээ.

Гэрээт олборлогчийн ажлын хөлс өндөр, дэлхийн зах зээлд нүүрсний үнийн уналт үргэлжилж байсан зэргээс шалтгаалан Цанхийн зүүн хэсэг 2014 оны 8 дугаар сараас 2014 оны 12 дугаар сар хүртэл 5 сарын хугацаагаар Цанхийн баруун хэсэг 2015 оны 10 дугаар сараас 2016 оны 11 дүгээр сар хүртэл 9 сарын хугацаагаар уурхайн үйл ажиллагаа түр зогссон байна.

Тус компани 2010 оноос хойш нийт 34.9 сая тонн нүүрс олборлож 2016 онд 7.5 сая тонн, 2017 онд 8.5 сая тн нүүрс тус тус экспортолсон нь Монгол Улсын нийт нүүрсний экспортын 30 орчим хувийг эзэлж бөгөөд борлуулалтын орлого 2017 онд 485.7 сая ам.доллар болсон байна.

“Эрдэнэс таван толгой” ХК 747 орон тоотой ажиллаж байгаа бөгөөд Цанхийн хэсэгт үйл ажиллагаа явуулж буй гэрээт олборлогч болон бусад туслан гүйцэтгэгч компаниудын ажилтнуудыг оруулан тооцвол нийт 2,947 ажилтан ажиллаж байгаа нь ТЭЗҮ-д заасан хүний нөөцөөс 65.6 хувиар илүү байна.

“Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцааны эзэмшил, хувь хэмжээг тогтоох асуудлаар 2008-2013 оны хооронд ЗГ-ын нийт 5 тогтоол гарсан бөгөөд өнөөдрийн байдлаар компанийн нийт зарласан хувьцааны 85.19 хувийг төр, 0.06 хувийг аж ахуйн нэгж, 14.75 хувийг иргэд эзэмшиж байна.

“Эрдэнэс таван толгой” ХК УИХ, Засгийн газрын тогтоолуудыг үндэслэн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 12.0 тэрбум хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тооцон 11,196,000.0 сая төгрөгөөр бүртгэсэн байна

Компанийн гүйцэтгэх удирдлагаар ажиллаж байсан албан тушаалтны нэр, хамрах хугацааг хүснэгтээр харуулав.

№	Гүйцэтгэх захирал	Ажилласан хугацаа
1	Б.Энэбиш	2010.01-2012.10 сар
2	Я.Батсуурь	2012.10-2015.03 сар
3	Б.Батбилэг	2015.05-2015.11 сар
4	Т.Билгээ	2015.11-2016.08 сар
5	Д.Ариунболд	2016.09-2018.04 сар
6	Б.Ганхуяг	2018.04-с өнөөдрийг хүртэл



КОМПАНИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙД ХАМААРАХ ОРДЫН НӨӨЦӨД ҮНДЭСЛЭН ТЭЗҮ-ИЙГ БОЛОВСРУУЛААГҮЙ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ТЭЗҮ-ИЙН ДАГУУ ЯВАГДААГҮЙ, ОЛБОРЛОЛТЫН ХӨЛС ХАРИЛЦАН АДИЛГҮЙ, ИХ ХЭМЖЭЭНИЙ ХАНШИЙН АЛДАГДАЛ ХҮЛЭЭЖ БАЙНА

1982-1993 оны хооронд ордын нөөцийг хэсэгчлэн тогтоож баталгаажуулсан байна

2.1.1. Монгол-Зөвлөлтийн ШУА-ийн хамтарсан экспедицүүд Улаан нуурын хөндийд орших Таван толгойн чулуун нүүрсний ордод 1940 оноос хойш эрэл-хайгуул, судалгаа шинжилгээний ажил хийж ирснээс 1978-1993 онд¹ нөөцийг хэсэгчлэн тогтоож, үр дүнг баталгаажуулж ирсэн ч зарим нөөцийг бүртгэх шийдвэр гараагүй байна. Үүнд:

- 1953-1956 онд² ордын ерөнхий эрэл үнэлгээний ажлаар 0.7-43.0м зузаантай нүүрсний 18 давхарга байгааг илрүүлж, коксжих болон баяжигдах шинж чанарыг судлан ордын нийт нөөцийг 2.8 тэрбум тн гэж тооцсон ч албан ёсоор бүртгэгдээгүй;
- 1990 онд ЗХУ-ын Гипершахт хүрээлэн Тавантолгойн сав газрын нүүрсний нийт нөөц, баялгийн хэмжээг 6.4³ тэрбум тн, 2007 онд Норвест компани Ухаа худаг, Баруун Нарангийн хэсгийг оруулан ЖОРК стандартын дагуу 0.6м-ээс дээш зузаантай 32 давхарга бүхий 7.5 тэрбум тн нөөцтэй гэж тогтоосон ч бүртгэгдээгүй байна.⁴

2.1.2. Тавантолгойн ордын Цанхи, Баруун өмнөд /Оорцог/, Бортээг, Ончхараат, Ухаа худгийн баруун хэсгийн хил хязгаарыг нарийвчлан тогтоох, коксжих нүүрсний нөөцийг нэмэгдүүлэх, нүүрсний чанарыг нарийвчлан судлах зорилгоор эрэл үнэлгээ, урьдчилсан болон нарийвчилсан хайгуулын ажлыг 1978-2012 оны хооронд гүйцэтгэж тухайн үеийн ШУТЗ, УАМНК, Зөвлөлт-Монголын нөөцийн комиссын хурлын тэмдэглэл, ЭБЭХС-ын тушаалаар нөөцийн хэмжээг тус тус баталгаажуулж Монгол улсын нөөцийн нэгдсэн санд 7,527.6 сая.тн-оор /нөөц давхацсан/ бүртгэх шийдвэрийг гаргасан байна. /дэлгэрэнгүйг хавсралт 01/

Хүснэгт 1. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн эзэмшлийн талбайн ордын нөөцийн /давхардсан/ нэгтгэл судалгаа

Хайгуул хийсэн он	нүүрсний төрөл	нөөцийн зэрэглэл,нөөц /сая.тн/					баялгийн зэрэглэл		
		A	B	C1	C2	A+B+C1+C2	P1	P2	P1+P2
1978-2012	ордын нийт нөөц	805.1	1,505.0	3,206.7	1,877.2	7,527.6	903.8	175.6	1,079.4
	коксжих нүүрс	627.1	893.0	1,117.1	867.6	4,302.0	831.3	103.3	934.6
	эрчим хүчний	178.1	449.4	961.9	562.6	2,978.4	72.5	72.3	144.8
	исэлдсэн	5.9	7.0	224.6	111.2	247.2	-	-	-

Эх сурвалж: Ордын нөөцийн 1984 оны 3726⁵, 1988 оны 4230⁶, 1989 оны 4288⁷, 1993 оны 4723⁸, 2011 оны 6390⁹, 2012 оны 6747¹⁰ дугаар тайлан.

¹ 1978-1993 он хүртэлх хугацаанд Улаан нуурын хөндийн болон Тавантолгойн ордод үе шаттай явуулсан геологи-хайгуулын ажлыг гүйцэтгэхдээ шугам хоорондын зайг 350-700 м, цооног хоорондын зайг 50-300 м-ээр сонгон нийтдээ 1354 цооног буюу 251806,2 т/м баганат өрөмдлөг, 22632 т/м шнек өрөмдлөг, 156481 м3 суваг, 21387,6 м3 транше, 836,2 т/м шурф, 139 т/м налуу болон босоо малталт гүйцэтгэсэн байна.

² 1953-1955 онд В.А.Бачилдин, В.В.Федосеев, П.Д.Шкляев нарын удирдлагаар Улаан нуурын хотгорт явуулсан хайгуулын ажлаар 108 цооног буюу 14010 т.м өрөмдлөг, 427 т.м шурф, 2339 м3 суваг малтаж

³ АНУ-ын Норвест компанийн 2007 оны 5 сард бичсэн тайлан

⁴ SurvCADD, MineSght3D програмыг ашиглан Тавантолгойн бүх талбайн 0,6 м-ээс дээш зузаантай 32 давхаргын хэмжээнд тооцоолон

⁵ Отчет о результатах предварительной разведки Цанхийского и Юго-западного участков Тавантолгойского месторождения каменных углей МНР/с подсчетом запасов по состоянию на 1 января 1984г. г.Улан-батор 1984г.(3726),

⁶ Отчет о результатах детальной разведки площади первоочередной отработки Цанхийского участка Тавантолгойского месторождения каменных углей МНР/с подсчетом запасов по состоянию 01.01.1988г/ Улан-батор 1988г.(4230)

⁷ Отчет о результатах предварительной разведки участка Ухаахудаг и поисково-оценочных работ на участках Восточном и Бортотгой Тавантолгойского месторождения каменных углей МНР.Улан-батор 1989г/с подсчетом запасов по состоянию 1989г/.(4288)


⁸ Отчет о результатах детальной разведки западной и восточной части Цанхийского, предварительной разведки Бортээгского участков Таван-толгойского и поисковых работ Эрдэнэбулагского месторождений каменных углей Юга Монголии. /подсчетом запасов по состоянию на 1.января 1993г.(4723)

⁹ Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн ордын Цанхи, Бортээг (Өмнөд) зүүн хэсгүүдийн сонгосон талбай буюу 11943А, 11954А, 11956А дугаар тусгай зөвшөөрлийн талбайнуудад 2011 онд нөөц тодотгосон ажлын үр дүнгийн тайлан (6390)

¹⁰ Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн ордын Цанхийн баруун, Бортээгийн хойд, Ухаахудагийн баруун хэсгүүдийн МҮ016881, МҮ016882 дугаар тусгай зөвшөөрлөтэй талбайнуудад 2011 онд нөөц тодотгосон ажлын үр дүнгийн тайлан. /Нөөцийн тооцоо 2011.12.01-ны байдлаар/ Улаанбаатар. 2012 он (6747).



Дүрслэл 1. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн эзэмшлийн ордод 1981-2012 онд ордын нөөцийн судалгаа



Эх сурвалж: Аудитын баг

2.1.3. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн захиалгаар¹¹ 2011 онд, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн захиалгаар 2012 онд ордын тодорхой сонгосон талбайд өмнөх нөөцийн тооцоог үндэслэсэн нөөцийн тодотголыг гаргасан ч нөөц шинээр нэмж тогтоогоогүй, тухайн нөөц тогтоосон актад ордын өмнөх нөөцийг хүчингүй болгоогүй, нөөц нь давхар бүртгэлтэй байна.

2.1.4. 1990 оноос өмнө ЗХУ-ын нөөцийн ангиллын заавар, хайгуулын стандартын дагуу эрэл, урьдчилсан болон нарийвчилсан хайгуулын ажлыг явуулж байсан бөгөөд одоогоор Австралийн ЖОРК стандартыг ашиглан нөөцийн нэгтгэл хийж байгаа ба хайгуулын үе шатанд мөрдөх Монгол улсын стандарт байхгүй байна.

Монгол улсын нөөцийн нэгдсэн санд ордын нөөц бүрэн бүртгэгдээгүй байна

2.1.5. Монгол улсын нөөцийн нэгдсэн санд¹² батлагдсан нөөцийг “Эрдэнэс таван толгой” ХК-ийн нэрээр Баруун өмнөд /Оорцог/, Зүүн /Онч хараат/, Ухаа худаг, Цанхи, Цанхийн баруун, Цанхийн зүүн, Ухаа худагийн баруун, Бортээгийн хойд, Бортээгийн зүүн хэсэгт 3,368.9 сая.тн гэж бүртгэсэн байна. /дэлгэрэнгүйг хавсралт 2/

2.1.6. Монгол улсын нөөцийн нэгдсэн санд нийт 7,527.6 сая.тн нөөц бүртгэхээс 3,368.8 сая тн буюу 44.7 хувийг бүртгэсэн нь ЭХГУУС-ын 1995 оны 258 тушаалаар баталсан “Ашигт малтмалын нөөцийн улсын баланс зохиох заавар”-т ...Улсын эрдэс баялгийн зөвлөлийн баталсан, ...Геологи уул уурхайн салбарын ШУТЗ-ийн хамтарсан хуралдаанаар хэлэлцэж баталсан төрөл бүрийн ашигт малтмалын нөөцийг улсын тоо бүртгэлд хамруулна... гэж заасныг АМГТГ бүрэн хэрэгжүүлээгүйгээс нөөцийн мэдээлэл үнэн зөв бүртгэгдээгүй, бодитой бус байна. Үүнд:

- ШУТЗ-ийн 1984 оны 09 дүгээр, 1993 оны 79 дүгээр протоколоор баталсан Цанхийн болон Бортээгийн хэсгийн нийт 3,576.7 сая тн нөөцийг бүртгээгүй,
- УАМНК-ийн 1989 оны 34 дүгээр тогтоолоор баталсан Ухаа худагийн хэсгийн 288.5 сая тн нөөцийг илүү бүртгэсэн байна.

2.1.7. Мөн Монгол улсын нөөцийн нэгдсэн сангийн бүртгэл¹³-д ордын нөөцийг балансын болон балансын бус нөөцөөр өнөөдрийг хүртэл бүртгэж байгаа нь УУС-ын 2015 оны 203 дугаар тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангидал, заавар”-

¹¹ ЭБЭХЯ, АМГ, “Эрдэнэс МГЛ” ХХК хамтран 2011 онд Цанхи, Бортээгийн зүүн хэсгийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд 2011 оны 3 дугаар сарын 30-ны, б.айдлаар нөөц тодотгосон ажлын үр дүнгийн тайланг гаргасан

¹² Ашигт малтмал, газрын тосны газрын 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 10/6938 дугаар албан бичгээр Ашигт малтмалын нөөцийн мэдээллийн санд бүртгэлтэй Тавантолгойн ордын бүртгэгдсэн нөөцийг ирүүлсэн.

¹³ АМГТГ-ын Эрдэс баялгийн мэдээллийн технологийн бүртгэлийн хэлтэс



т хатуу ашигт малтмалын ордын нөөцийг геологийн болон үйлдвэрлэлийн нөөцөөр ангилахаар заасантай нийцэхгүй байна.

2.1.8. АМГТГ-ын Нүүрс судалгааны хэлтсийн нүүрсний бүртгэл хөдөлгөөний мэдээлэлд тус компанийн ашиглалтын 68,471.43 га талбайн ордын нөөцийг 3,750.2 сая тн-оор бүртгэсэн байгаа нь хэлтсүүд хоорондын тоо мэдээ 381.3 сая тн-оор зөрүүтэй байгааг харуулж байна. */дэлгэрэнгүйг хавсралт 3-с харна уу/*

2018 онд ордын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах нөөцийн тооцоог нэгтгэсэн ч эцэслэн батлагдаагүй байна

2.1.9. “Эрдэнэс таван толгой” ХК нь 2018 онд “Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн чулуун нүүрсний ордын Цанхи, Бортээг /Өмнөд/, Оорцог /Баруун-Өмнөд/, Ончхараат /Зүүн/, Борттолгой, Ухаа худагийн баруун хэсгийн MV-016881, MV-016882, MV-016883, MV-011943, MV-011953, MV-011954, MV-011955, MV-011956 дугаар тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах нөөцийн тооцооны (2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар) нэгтгэл” тайланг гаргаж ЭБМЗ-ийн 2018 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн ХХ-2018-02 өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлсэн ч нөөцийн тайлан эцэслэн батлагдаагүй байна.

2.1.10. Уг тайланд нөөцийг шинээр 331.3 сая тн-оор нэмэгдүүлж, 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар компанийн тусгай зөвшөөрлийн талбайд оногдох нийт нөөц 6,340.2 сая тн, /үүнээс 6,008.8 сая тн өмнөх судалгааны ажлуудын нэгтгэл дүн/ гэж тайлагнасан боловч 60.6 сая тн нь Arc GIS Map Info програм ашиглаж нөөцийн блокын талбайг тооцоолоход үүссэн алдааны нарийвчлал байна. */дэлгэрэнгүйг хавсралт 4-д харуулав/*

- Онч хараат хэсгийн нөөц тооцоогүй орхигдсон 110.7 сая тн,
- Нөөц бодох давхаргын хэмжээ 2.0м байсныг 0.6м болгон нарийвчлан тооцооноос 160.0 сая тн,

2.1.11. 1982-2012 оны хугацаанд ШУТЗ, УАМНК, Зөвлөлт-Монголын нөөцийн комиссын хурлын тэмдэглэл, ЭБЭХС-ын тушаалын дагуу баталж, бүртгэхээр шийдвэрлэсэн 7,527.6 сая.тн нүүрсний дүнг нягтлан исэлдсэн нүүрсний 247.2 сая тн, давхардсан 940.2 сая тн хэмжээгээр бууруулан тайлагнажээ.

2.1.12. Ордын ашиглалтын явцад 2013 онд нийт 5,570.1 сая төгрөгийн дүн бүхий 5 хайгуулын ажил батлагдсан төсөлгүйгээр хийгдсэнээс 2,077.3 сая төгрөгийн дүн бүхий ашиглалтын хайгуулын 3 ажлын захиалагчаар Цанхийн зүүн хэсгийн гэрээт олборлогч “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.

2.1.13. Гэрээт олборлогч “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК, “Монкаротаж” ХХК, “Эрдэнэдрийлинг” ХХК хооронд 2013 онд байгуулсан 5,000 тууш метр геофизикийн ажилд “Эрдэнэс таван толгой” ХК-ийн геологи, хайгуул, судалгааны албаны дарга Б.Гантулга, уурхайн төлөвлөлт, техник, зохион байгуулалтын албаны дарга Л.Цагаан-өвгөн нар 176.5 тууш метр өрөмдлөгө, геофизикийн ажлыг илүү гүйцэтгүүлж¹⁴ гэрээний дүнгээс 25.2 сая төгрөгийг илүү олгосон байна.

Ордын нөөцөд нүүрсний чанарыг үе давхарга бүрээр тогтоож байна

2.1.14. Таван толгойн чулуун нүүрсний ордын чанар, давхарга зүй, нүүрсний чийг, дэгдэмхий бодисын гарц, барьцалдах чанар, үнслэг, хүхэр, илчлэг зэрэг нүүрсний чанарын үзүүлэлтийг 1953-75 онд судалж¹⁵ III^{абв}, IV^{аб} давхаргын нүүрс нь коксжих сайн чанарын, 0^{абв},

¹⁴ “Эрдэнэс таван толгой” ХК-ийн нягтлан бодох бүртгэлийн газарт 2013 оны 10 дугаар сарын 22-ны өдөр гаргасан гүйцэтгэлд тухайн үед Махмахон Монголиа” ХХК-ийн хариуцсан инженер Чандра Сумара, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн геологи, хайгуул, судалгааны албаны дарга Б.Гантулга, уурхайн төлөвлөлт, техник, зохион байгуулалтын албаны дарга Д.Цагаан-өвгөн нарын зөвшөөрлийн дагуу гэрээнд зааснаас илүү 176,5 тууш метр өрөмдлөгийн ажлыг гүйцэтгүүлсэн байна.

¹⁵ Болгар улсын “МИНПРОЕКТ” хүрээлэнд



V, VII давхарга сул коксжих, VIII^а^б, IX^а, IX^б, IX^г давхаргууд коксжихгүй болохыг судлан тогтоосон байна.

Хүснэгт 2. Нүүрсний ангиллын дагуу давхарга тус бүрийн чанарын үзүүлэлт

Давхраас	Нүүрсний төрөл	Ангилал	Чанарын үзүүлэлтүүд						
			Нийт чийг	Дэгдэмхий бодисын гарц	Барьцалдах чанар	Үнслэг	Хүхэр	Илчлэг	Витринитийн ойлтын зэрэг
0A	чулуун	сул коксжих	0,64	19,8	61,28	15-18,5			1,38
0B	чулуун		0,62	21,4	71,2	17			1,28
0B	чулуун		0,58	23,3	74,1	13-14			1,20
IIIAB	чулуун	коксжих	0,6	24,6	79,59	9,5	0,65	34,5	1,18
IVA	чулуун		0,5	27,3	77,23	9,4	0,64	34,6	1,07
IVB	чулуун		0,7	28,1	81,7	9,4	0,63		1,07
V	чулуун	сул коксжих	0,7	29,7	65,10	10,4	0,67	34,3	1,00
VII	чулуун		1,2	30,5		10,5	0,57	33,5	1,04
VIIIA	чулуун	коксжихгүй	0,85	29,7	51,74	11,1	0,70	34,2	0,98
VIIIB	чулуун		1,03	30,0	55,9	10,8	0,69	33,9	0,97
VIIIB	чулуун		0,99	31,8	52,89	10,8		33,6	0,95
IXA	чулуун				56,32	8-9			
IXB	чулуун		1,1	32,86	53,27				0,93
IXB	чулуун	хийн	1,23	30,5	59,76				0,91
IXГ	чулуун		1,0	32,9	52,51				0,88

Эх сурвалж: “Эрдэнэс таван толгой” ХК

Ордын нөөцөд бүртгэгдсэн дагалдах ашигт малтмалын эдийн засгийн ач холбогдлыг үнэлж тооцоогүй байна

2.1.15. Таван толгойн чулуун нүүрсний ордод гөлтгөнө, галд тэсвэртэй шавар, зам барилгын чулуу зэрэг дагалдах ашигт малтмал, нүүрсний давхаргын метан хийн судалгааг 1981-1993 онд хийж байжээ.

2.1.16. Ордын Цанхи, Бортээгийн зүүн хэсгүүдийн нөөц тодотгосон ажлын үр дүнгийн тайланд¹⁶ 11943A бүхэлдээ, 11954A зүүн доод булан, 11955A баруун дээд, баруун доод хэсгүүд, 11956A зүүн зах хэсгүүд дэх талбайд шаварлаг гөлтгөнө, галд тэсвэртэй шавар, зам барилгын чулуу гэсэн ашигт бүрдвэр байгаа талаар дурдсан байна. Үүнд:

- 1981-1982 оны нарийвчилсан хайгуулын ажлаар гөлтгөнийн боломжтой /C1/ нөөцийг 1.9 сая тн гэж тогтоосон;
- 2011 оны ордын нөөцийн нэмэлт тодотгосон тайланд галд тэсвэртэй шаврын боломжтой /C1, C2/ нөөц 1.6 сая тн, том ширхэгтэй элсэн чулуу, хөрзөн чулууг зам засварын ажилд хэрэглэх боломжтой гэж үзсэн ч нөөцийн үнэлгээ өгөөгүй байна.

2.1.17. ЭБЭХС-ын 2012 оны “Нөөц бүртгэх тухай” 129 дүгээр тушаалаар ордын хэмжээнд цаашид ашиглалтын буюу гүйцээх хайгуулын ажил хийж, үйлдвэрлэлийн зэргийн нөөцийг өсгөх, технологийн туршилт, нүүрсний шинж чанар, уурхайн усан хангамж, метан хийн болон дагалдах бусад ашигт малтмал гэх зэрэг иж бүрэн судалгааг хийж тухай бүрд нөөцийн тодруулга хийхийг “Эрдэнэс таван толгой” ХК-д даалгасан ч өнөөдрийг хүртэл тодорхой ажил хийгдээгүй байна.

2.1.18. Цанхийн зүүн уурхайн хөрсний 2 дугаар овоолгын урд байрших гөлтгөнө, галд тэсвэртэй шавар, зам барилгын чулуу зэрэг дайвар ашигт малтмалыг хэрхэн ашиглах тооцоо судалгаагүй, цаашид тухайн нөөц тооцсон хэсэгт олборлолтын ахилтад өртөх үед хэрхэн ашиглах талаар төлөвлөгөө хийгдээгүй байна.

2.1.19. Нүүрсний давхаргын метан хийн иж бүрэн судалгаа хийгдээгүй бөгөөд Цанхийн баруун, Бортээгийн хэсэгт 2014 онд нүүрсний давхаргын метан хий (НДМ) судлах зориулалтаар 2 цооног (M-01, M-02) өрөмдөн¹⁷ XII блокод хамаарах хамгийн их илэрц бүхий III^б, в давхарга, III^а давхаргын метан хийн нөөцийг 1.2 тэрбум м³ гэж багцаалан тооцоолжээ.

Метан хийн илэрц бүхий бусад давхаргууд:

- IV^а давхаргаас илэрсэн метан хийн агууламж 84.8 хувь,

¹⁶ 2011 онд хийгдсэн судалгаа

¹⁷ Бортээгийн хэсгийн 933м гүнтэй M-01 дугаар цооногийг хайгуулын 9-р шугам дээр, 783,5 м гүнтэй M-05 дугаар цооногийг хайгуулын 19-р шугам дээр тус тус өрөмдсөн ба нийт гүн нь 1216,5 м болж байна.



- IXа давхаргаас эхлэн метан хий илэрсэн бөгөөд метаны агууламж 88.8 хувь,
- VIII дугаар давхаргаас хамгийн өндөр агууламжтай байжээ.

Компанийн тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах ордын нөөцөд үндэслэн ТЭЗҮ-ийг боловсруулаагүй байна

2.1.20. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн эзэмшлийн Таван толгойн чулуун нүүрсний ордын нийт 68.5 мянган га талбай бүхий тусгай зөвшөөрлийн талбайн 8.4 хувь, нийт нөөцийн 17.9 хувь буюу 1,351.8 сая тн үйлдвэрлэлийн нөөцийг үндэслэн ТЭЗҮ-ийг боловсруулсан нь ордын нийт талбай, нөөцийг бүрэн хамруулаагүйгээс ордын нөөцийг ашиглах нийт хугацаа тодорхойгүй байна.

2.1.21. Харин ашиглалтын тусгай зөвшөөрлийн хилээр Цанхийн баруун, зүүн хэсгийн нөөцийг тогтоон, уг нөөцийг ашиглан ил уурхайгаар ашиглах ТЭЗҮ-г тус тусад нь боловсруулж батлуулсан байна.Үүнд:

- “Эрдэнэс Монгол” ХХК¹⁸-ийн захиалгаар “Абсолютмайнинг” ХХК, “Эрдэнэс Монгол” ХХК, Уурхайн баг хамтран 2011 онд Цанхийн зүүн хэсгийг ил уурхайгаар 15.0 сая тн нүүрс олборлох ТЭЗҮ-ийг 11943А, 11954А, 11955А, 11956А дугаар тусгай зөвшөөрлүүдийн 2781.0 га¹⁹ талбайг /Цанхи, Бортээгийн зүүн хэсэг/ хамруулан боловсруулж, батлуулсан;
- “Эрдэнэс таван толгой” ХК-ийн захиалгаар ШУТИС-ийн харьяа “Уул уурхайн хүрээлэн” 2012 онд Цанхийн баруун хэсгийг ил уурхайгаар ашиглах 20.0 сая тн нүүрс олборлох ТЭЗҮ-ийг MV-016881, MV-016882 дугаар тусгай зөвшөөрлүүдийн 3003.85 га талбайг /Цанхи, Бортээгийн хойд, Ухаа худагийн баруун/ хамруулан боловсруулж, батлуулсан байна.

Хүснэгт 3. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн эзэмшлийн ашиглалтын талбайд оногдох ТЭЗҮ-д тусгасан талбай болон үйлдвэрлэлийн нөөцийн судалгаа

Ордын хэсгийн нэр	Хэсгийн байршил, нэр	Талбайн дугаар	Тусгай зөвшөөрлийн талбай			Үйлдвэрлэлийн нөөц /А+В/
			Нийт талбай	ТЭЗҮ-д тусгагдсан талбай	Хамрагдсан хувь	
Цанхийн зүүн хэсэг	Цанх, Бортээгийн зүүн хэсэг бүхэлдээ	11943А	2,036.33	2,036.48	100.0	632.5
	Баруун хойд, баруун урд хэсэг	11954А	22,901.37	12.8	0.1	23.9
	Хойд,зүүн,урд хэсэг	11955А	23,813.10	671.2	2.8	1.4
	Баруун хэсгийн зүүн зах	11956А	3,151.92	60.6	1.9	34.1
		MV-016883	700.39		-	
Цанхийн баруун хэсэг	Хойд хэсэг,Ухаа худгийн баруун хэсэг	MV-016881	556.72	556.72	100.0	659.9
	Урд хэсэг,Бортээгийн хойд хэсэг	MV-016882	2447.13	2447.13	100.0	
Бор толгой		11953А	12864.47			
	Нийт талбай		68,471.43	5,784.93	8.4	1351.8

Эх сурвалж: Аудитын баг

2.1.22. ТЭЗҮ-д төслийн хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэр, цахилгаан станц, төмөр зам, усан хангамжийн байгууламж, 10,000 хүн ам оршин суух хотхон болон холбогдох нийгэм ахуйн байгууламжийн хамт барихаар төлөвлөсөн байна.

¹⁸ “Эрдэнэс МГЛ”ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Энэбиш

¹⁹ Эх сурвалж: ЭБМЗ-ийн 2011 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 01дүгээр дүгнэлт “Таван толгой ордын Цанхи, Бортээгийн зүүн хэсгүүдийн сонгосон талбайн 2011 оны нөөцийн тодотголын үр дүнгийн тайлан”, ЭБМЗ-ийн 2011 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 02 дугаар дүгнэлт “Цанхийн зүүн хэсгийн ил уурхайгаар ашиглах ТЭЗҮ-ийг хэлэлцсэн тухай”



Хүснэгт 4. ТЭЗҮ-д тусгасан баяжуулах үйлдвэр, цахилгаан станц, төмөр зам, усан хангамжийн хүчин чадлын нэгтгэл

Ордын хэсгийн нэр	ТЭЗҮ-ийн хүрээнд төлөвлөсөн хүчин чадал				
	Хүчин чадал /сая тн/	Нүүрс баяжуулах үйлдвэр сая тн/	Цахилгаан станц /Мвт/	Төмөр зам	Усан хангамж
Цанхийн зүүн хэсэг	15.0	15.0	600.0	Таван толгой-Цагаан суварга-Зүүн баян чиглэлийн 400 км урт	40.0 мянган м³ хүчин чадалтай шахуургын станц, 70 км урт ус дамжуулах хоолой
Цанхийн баруун хэсэг	20.0	20.0	300.0		

Эх сурвалж: Аудитын баг

2.1.23. Болгар улсын “МИНПРОЕКТ” хүрээлэнд 1953-1955 он, 1974-1975 онд, “АЛС Групп” ХХК-ийн лабораторид 2012 онд хийгдсэн баяжигдах чанарын судалгаануудын үр дүнгээр 0, VIII, IX давхаргын нүүрсийг III, IV давхаргын нүүрстэй хольж сайн чанарын кокс үйлдвэрлэх боломжтой гэж дүгнэжээ.

Хүснэгт 5 Нүүрсний коксжих шинж чанар /давхаргаар/

Давхаргын дугаар	Давхаргын коксжих шинж чанар
0	0 давхаргын нүүрс нь дангаар коксжих чанаргүй боловч 15-20%-ийг III, IV давхаргын нүүрстэй хольж, баяжуулснаар кокс үйлдвэрлэх боломжтой.
VIII	VIII давхаргын нүүрс нь дангаар коксжих чанаргүй боловч 30-40%-ийг III, IV давхаргын нүүрстэй хольж, баяжуулснаар кокс үйлдвэрлэх боломжтой.
IX	Баяжуулсан тохиолдолд илчлэг өндөртэй эрчим хүчний нүүрс болно. Тус давхаргын нүүрсний 30-40%-ийг III, IV давхаргын нүүрстэй хольж кокс үйлдвэрлэх боломжтой.

Эх сурвалж: Нөөцийн тооцооны үр дүнгийн тайлан

2.1.24. Төслийн хүрээнд нийт хөрөнгө оруулалт, анхны хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа, төслийн өнөөгийн үнэ цэнэ, өгөөжийн дотоод түвшнийг дараах байдлаар төлөвлөж тооцсон байна.

Хүснэгт 6. ТЭЗҮ-ийн хөрөнгө оруулалт, төслийн үнэ цэнэ, өгөөжийн дотоод түвшний нэгтгэл

Ордын хэсгийн нэр	Нийт хөрөнгө оруулалт /30 жил/	Анхны хөрөнгө оруулалт /эхний 4 жил/			Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа /сар/	Төслийн өнөөгийн үнэ цэнэ	Өгөөжийн дотоод түвшин /хувь/
		Өөрийн хөрөнгө	Зээл	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ			
Цанхийн зүүн хэсэг /сая ам.доллар/	1,357.7	185.8	433.5	116.0	84	1,031.4	47.8
Цанхийн баруун хэсэг /тэрбум төгрөг/	2,562.81	428.07	998.85	-	60	3,423.98	48

Эх сурвалж: Аудитын баг

ТЭЗҮ-д үйлдвэрлэлийн нөөцийг бүрэн тусгаж тооцоогүй байна

2.1.25. ЭБМЗ нь ТЭЗҮ-г хэлэлцэн, нөөцийн тооцоог нэмэгдүүлэх, төслийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх зэрэг асуудлыг дүгнэлтэд тусгаж, ТЭЗҮ-г хүлээн авах ЭБЭХС-ын 2011 оны 80 дугаар тушаалаар²⁰ “Эрдэнэс таван толгой” ХК-д даалгасан боловч уг ажлууд хийгдээгүй байна. Үүнд:

- Цанхийн зүүн хэсэг²¹:
 - Нөөцийг нэмэгдүүлэхийг үүрэг болгосон ч ТЭЗҮ-д үйлдвэрлэлийн нөөцийг нэмж тусгаагүй,
 - Төслийн усан хангамжийн асуудлыг судалж шийдвэрлэх ажил хийгдээгүй байна.

²⁰ ЭБЭХС-ын 2011 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 080 дугаар ТЭЗҮ-г хүлээн авах тушаал

²¹ ЭБМЗ-ийн 2011 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 02-03 дугаар Цанхийн зүүн хэсгийн ил уурхайгаар ашиглах ТЭЗҮ-ийг хэлэлцсэн тухай хурлын тэмдэглэл.



2.1.26. Цанхийн зүүн, баруун уурхайн ТЭЗҮ-д үйлдвэрлэлийн нөөцийг геологийн нөөцийн 56.9-67.8 хувиар тооцон дутуу тусгасан нь ЭБЭХС-ын 2011 оны 076 дугаар²², 2012 оны 129 дүгээр²³ тушаалд “баттай /А/, бодитой /В/ нөөцөд тулгуурлан ТЭЗҮ-г боловсруулах” гэж заасантай нийцээгүй, мөн хаягдлыг 4.2-7.4 хувь байхаар харилцан адилгүй тооцсон байна. Үүнд:

Хүснэгт 7 Цанхийн хэсгийн ордын 2011-2012 оны батлагдсан нөөц, ТЭЗҮ-д тусгасан нөөцийн харьцуулсан судалгаа

№	Ордын хэсэг		Ордын батлагдсан нөөц		ТЭЗҮ-д тусгасан нөөц			ТЭЗҮ-д тусгагдаагүй нөөц
			нийт нөөц	/А+В/	Үйлдвэрлэл	Олборлох	Нийт хаягдал	
1	Цанхийн зүүн хэсэг	сая тн	750.5	668.3	427.3	410.0	17.3	241.0
		хувь			56.9	95.9	4.2	36.1
2	Цанхийн баруун хэсэг	сая тн	814.1	660.0	551.9	543.1	40.3	108.1
		хувь			67.8	98.4	7.4	16.38
Цанхийн хэсгийн дүн			1564.6	1328.3	979.2	953.1	57.6	349.1

Эх сурвалж: Аудитын баг

2.1.27. Цанхийн баруун хэсгийн ашиглалтын явцад хаягдлын бодит хэмжээ 2.4 хувь буюу ТЭЗҮ-д тусгагдсан хэмжээнээс 3 дахин бага байгаа нь ТЭЗҮ-ийн тооцоолол бодит бус байгааг харуулж байна.

2.1.28. Цанхийн баруун хэсгийн ТЭЗҮ-д хөрсний 2 дугаар овоолгыг ашиглалтын 4 дэх жилээс эхлэн уурхайгаас хойш 3 км, Цагаан-Овоо тосгоны хойд хэсэгт байрлах талбайд үүсгэхээр тусгасан ч уг тосгоны газрыг хэрхэн чөлөөлөх талаар төлөвлөөгүй, шаардагдах хөрөнгийг тусгаагүй байна.

2.1.29. Цанхийн зүүн, баруун хэсгийн ТЭЗҮ батлагдсанаас хойш 7-8 жил өнгөрч байгаа хэдий ч “Эрдэнэс таван толгой” ХК ТЭЗҮ-д нэмэлт тодотгол хийгээгүй нь “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн ТЭЗҮ-д тавигдах үндсэн шаардлагууд ба ТЭЗҮ хүлээн авах журам”-ын 7.3²⁴-т “... тухайн ТЭЗҮ-г хүлээн авснаас хойш 5 жил тутамд төсөл хэрэгжүүлэгч байгууллага ТЭЗҮ-г тодотгох, шинэчлэх буюу шинээр боловсруулах үүргийг хүлээнэ” гэж заасныг зөрчсөн байна.

ТЭЗҮ-д тусгагдсан хүчин чадал, тоо хэмжээний дагуу бүтээгдэхүүнийг олборлох, ашиглах үйл ажиллагаа явагдахгүй байна

2.1.30. Тус ордод нийт 965 м зузаантай нүүрс агуулагч 16 /давхарга 0-оос давхарга XV хүртэл/ давхарга тогтоогдсоноос Цанхийн хэсэгт 0-ээс X хүртэлх давхарга²⁵ судлагдсан, 0²⁶, III²⁷, IV²⁸, VIII²⁹, IX³⁰ давхаргын нүүрсийг угааж баяжуулсны дараа металлургийн кокс үйлдвэрлэж болохыг тогтоосон, V, VI давхаргын нүүрсний коксжих чанар нь судлагдаагүй байна.

²² ЭБЭХС-ын 2011.04.20-ны өдрийн 76 дугаар тушаалаар Тавантолгойн чулуун нүүрсний ордын Цанхийн зүүн, Бортээгийн зүүн хэсгүүдийн сонгосон талбайн нүүрсний нөөцийг МУ-ын нөөцийн нэгдсэн санд бүртгэж, сонгосон талбайн баттай /А/, бодитой /В/ нөөцөд тулгуурлан түүнийг ашиглах ТЭЗҮ-г боловсруулах.

²³ ЭБЭХС-ийн 2012.06.14-ны өдрийн 129 дугаар тушаалаар Тавантолгойн ордын Цанхийн баруун, Бортээгийн хойд, Ухаахудагийн баруун хэсгүүдийн MV-016881, MV-016882 тоот ашиглалтын талбайнуудын баттай болон бодитой нөөцөд тулгуурлан үүнийг ашиглах ТЭЗҮ-г боловсруулах.

²⁴ ЭБЭХС-ын 2012 оны 74-р тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ын 7.3-т “Уул уурхайн төсөлд хүчин чадал, техник, технологийн өөрчлөлт орсон, уг техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсанаас хойш ашиглалт явуулалгүй 3-аас дээш жилийн хугацаа өнгөрсөн, ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрчлөгдсөн болон тухайн техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсанаас хойш 5 жил тутамд төсөл хэрэгжүүлэгч байгууллага техник, эдийн засгийн үндэслэлийг тодотгох, шинэчлэх буюу шинээр боловсруулах үүргийг хүлээнэ”

²⁵ 25 дэд салаа давхарга үүссэн

²⁶ Тавантолгойн ордын хамгийн доод нүүрсний давхарга

²⁷ Геологийн бүтэц болон зузааны хувьд нэлээд жигд тогтоцтой хамгийн их зузаан нь /11-12 м/.

²⁸ IVaб давхарга нь нийлмэл хэсэгтээ 10 м зузаантай ба унал болон суналынхаа дагуу нарийсаж 7,0 м болдог, бүтэц болон зузааны хувьд харьцангуй жигд тогтворжилттой.

²⁹ Давхарга нь нийлмэл тогтоцтой 80 гаруй метр зузаантай нэгдмэл нэг давхаргыг бүрдүүлдэг.

³⁰ Давхарга нь ерөнхийдөө нийлмэл нүүрсний нөөцийн бага хэсгийг бүрдүүлдэг.



2.1.31. Цанхийн хэсгээс 2011-2017 онд ашиглагдсан нийт 36.8 сая тн нөөцийн 34.8 сая тн нь олборлосон нүүрс, 2.0 сая тн нь хаягдал, бохирдол байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 6-д харуулав/ Үүнд:

- Цанхийн зүүн хэсгээс 2011-2017 оны хооронд 20.2 сая тн нүүрс,
- Цанхийн баруун хэсгээс 2013-2017 оны хооронд 14.6 сая тн нүүрс олборлосон байна.

2.1.32. Цанхийн хэсгийн АҮАТ-д хөрс хуулалт, нүүрс олборлолт, нийт уулын ажлын хэмжээг ТЭЗҮ-д заасан хэмжээнээс 60.7-114.7 сая м³ хэмжээгээр багаар тусгаж төлөвлөсөн нь “Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам”-ын 9.5³¹-т заасантай нийцэхгүй байна. Үүнд:

Хүснэгт 8. Цанхийн хэсгийн ТЭЗҮ, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан уулын ажлын харьцуулсан судалгааны нэгтгэл

Ордын хэсэг	ТЭЗҮ-д тусгагдсан			Төлөвлөгөөнд тусгагдсан				ТЭЗҮ, АҮАТ-ний зөрүү		
	Олборлолт /сая.тн/	хөрс хуулалт /сая м ³ /	уулын цулын хэмжээ /сая м ³ /	үе шатанд хамаарах жил	Олборлолт /сая тн/	хөрс хуулалт /сая м ³ /	уулын цулын хэмжээ /сая м ³ /	олборлолт /сая.тн/	хөрс хуулалт /сая.м3/	уулын цулын хэмжээ /сая м ³ /
Цанхийн баруун хэсэг	43.2	142.9	173.7	5	25.6	94.8	113.0	17.6	48.1	60.7
Цанхийн зүүн хэсэг	65.0	223.2	269.6	7	37.7	129.5	156.4	27.3	93.7	113.2

Эх сурвалж:Аудитын баг

2.1.33. “Эрдэнэс таван толгой” ХК нь гэрээт олборлогч компаниудтай уулын ажил гүйцэтгэх гэрээнд ажлын тоо хэмжээг АМГТГ-т хүргүүлэн батлуулсан АҮАТ-ний ажлын тоо хэмжээнээс зөрүүтэйгээр тусгасан байна. /дэлгэрэнгүйг хавсралт №07, 08/ Үүнд:

- Цанхийн баруун хэсгийн гэрээт олборлогч компаниудтай 2013-2017 онд байгуулсан гэрээнд АҮАТ-нд батлагдсан уулын ажлын тоо хэмжээнээс 27.3 сая м³-ээр бага тусгасан,
- Цанхийн зүүн хэсгийн гэрээт олборлогч компаниудтай байгуулсан гэрээнд АҮАТ-нд батлагдсан уулын ажлын тоо хэмжээнээс 61.3 сая м³-ээр их тусгасан байна,

2.1.34. Гэрээт олборлогчийн ажлын хөлс өндөр, дэлхийн зах зээлд нүүрсний үнийн уналт үргэлжилж байсан зэргээс шалтгаалан Цанхийн зүүн хэсэг 2014 оны 8 дугаар сараас 2014 оны 12 дугаар сар хүртэл 5 сарын хугацаагаар Цанхийн баруун хэсэг 2015 оны 10 дугаар сараас 2016 оны 11 дүгээр сар хүртэл 9 сарын хугацаагаар уурхайн үйл ажиллагаа түр зогссон байна.

2.1.35. ТЭЗҮ-д уулын ажлыг өөрсдийн тоног төхөөрөмж, ажиллах хүчээр гүйцэтгэхээр тусгасан боловч УИХ-ын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1 дүгээр заалтын³² дагуу Цанхийн баруун хэсэгт 2013-2015 он, 2017 онд “Монгол уурхайчид” түншлэл, 2016 онд “Саусгоби сэндс” ХХК, зүүн хэсэгт 2011-2017 онд “Макмахон монголиа” ХХК, “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК гэрээт олборлогчоор ажиллажээ.

2.1.36. Цанхийн хэсгийн ТЭЗҮ-д үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өөрсдийн тоног, төхөөрөмж, ажиллах хүчээр гүйцэтгэхээр төлөвлөж 1 м³ уулын цулыг 5.8-8.6 мянган төгрөгөөр, 1 тн нүүрсийг 23.2-48.4 мянган төгрөгөөр тооцсон боловч гэрээт олборлогч

³¹ 9.5. Ашигт малтмалын тухай хуулийн 10.1.12, 11.1, 48.6, 48.7, 48.11-д заасны дагуу ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон баяжуулах, боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч нь уурхай болон уулын баяжуулах, боловсруулах үйлдвэрийн дараа жилийн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтүүд, уулын ажлын төлөвлөгөө, түүний биелэлтийн тайланг тухайн ордыг ашиглах болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл дээр тулгуурлан хийж геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан “Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээ хүлээн авах заавар”-ын дагуу хуульд заасан хугацаанд хүргүүлнэ.

³² УИХ-ын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1.1 Тавантолгойн нүүрсний ордод төрийн өмчит компани үйл ажиллагаа явуулах, “Эрдэнэс таван толгой” охин компанийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж, ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг хуваахгүйгээр шилжүүлэх, түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, гэрээт олборлогч аж ахуйн нэгжээр олборлолтын үйл ажиллагааг тодорхой хугацаанд гүйцэтгүүлэх



компаниудыг ажиллуулж байгаагаас 1 м³ уулын цулын өртөг 63.6-114.2 хувиар, 1 тн нүүрсний өртөг 59.0-175.2 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 9 Цанхийн хэсгийн ТЭЗҮ,уулын ажлын гүйцэтгэлд 1 тн нүүрсний өөрийн өртөг, 1 м³ уулын цулын өртгийг харьцуулсан нэгтгэл

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Цанхийн зүүн хэсэг	Цанхийн баруун хэсэг
Олборлосон нүүрс	сая тн	5.8	4.3
Уулын цулын хэмжээ	сая м ³	31.8	22.3
Ашиглалтын зардал	сая төгрөг	354,842.2	153,663.9
Бусад нийт зардал	сая төгрөг	121,362.3	90,543.5
Нийт зардал	сая төгрөг	445,385.7	275,026.2
1 м ³ уулын цулын өртөг	ТЭЗҮ	8,567.8	5,758.0
	Гүйцэтгэл	14,016.9	12,330.8
1 тн нүүрсний өртөг	ТЭЗҮ	48,421.2	23,156.0
	Гүйцэтгэл	76,979.4	63,714.6
Зөрүү /төгрөг, хувь/	1 м ³ уулын цулын өртөг	5,449.1	6,572.8
		63.6%	114.2%
	1 тн нүүрсний өртөг	28,558.1	40,558.6
		59.0%	175.2%

Эх сурвалж:Аудитын баг

2.1.37. Цанхийн хэсгийн уурхайн нүүрс баяжуулах үйлдвэрийг олборлолтын эхний жилээс барьж эхлэн, ТЭЗҮ-ийн ашиглалтын 4 дэх жилээс коксжих болон үл коксжих нүүрсний давхаргуудыг зэрэг олборлож, баяжуулсан нүүрс экспортод гаргахаар төлөвлөсөн ч өнөөг хүртэл үйлдвэр барьж эхлээгүйгээс нүүрсний III, IV давхаргын сайн чанарын коксжих нүүрсийг сорчлон олборлож байгаа нь Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглах үүрэг хүлээх бөгөөд зөвхөн ашиг олох зорилгоор түүнийг сорчлон ашиглахыг хориглоно” гэж заасныг зөрчиж байна.

2.1.38. ТЭЗҮ-д ашиглалтын 4-5 дахь жилээс эхлэн уурхайн ашиглагдсан орон зайд дотоод овоолго байгуулж, цаашид ашиглалтын хугацаанд боломжтой бүх хэсгүүдэд дотоод овоолгод хөрсний чулуулгийг байрлуулна гэж заасан ч баяжуулах үйлдвэргүйгээс нүүрсний давхаргуудыг бүрэн ашиглаагүй, дотоод овоолгыг үүсгэж эхлээгүй байна.

2.1.39. Цанхийн баруун хэсгийн ТЭЗҮ-д ашиглалтын 4 дэх жилээс эхлэн хөрсний 2 дугаар овоолгыг уурхайгаас хойш 3 км зайд Улаантолгойн талбайд үүсгэхээр тусгасан боловч уг талбайд Цагаан-Овоо тосгон байрладгаас уурхайгаас урагш 7 км зайд Бортээгийн талбайд овоолго үүсгэсэн байна.

2.1.40. Хөрс тээвэрлэлтийн зай нэмэгдсэнээс хүнд даацын авто самосвалуудын дугуйн халалт ихсэх, хагарах нөхцөл бий болж, ТЭЗҮ-д тусгагдаагүй олон тооны бага даацын самосвалууд ажиллуулахад хүргэсэн нь хөдөлгөөний эрчим нэмэгдэж аюулгүй ажиллагаа алдагдах, тоосжилт нэмэгдэх, гэрээт олборлогчийн хувьд зардал өсөхөд хүргэж байна.

2.1.41. “Эрдэнэс таван толгой” ХК нь хөрсний овоолгын хэмжээг уурхайн ашиглалтад өртсөн орон зайг хэмжин авто жингээр жинлэгдсэн нүүрсний хэмжээг хасах замаар тооцдог байсан бөгөөд уурхайн ашиглалтад өртсөн орон зай, хөрс, нүүрсний овоолгын хэмжээг 2017 онд хөндлөнгийн маркшейдерийн хэмжилтээр баталгаажуулаагүй байна.

2.1.42. Цанхийн баруун хэсгийн хөрсний сийрэгжилтийн дундаж коэффициентийг тооцож үзэхэд 2016-2017 оны байдлаар ТЭЗҮ-д тусгагдсанаас 0,19 пунктээр, Цанхийн зүүн хэсгээс 0.17 пунктээр, “Энержи Ресурс” ХХК-ийн Ухаа худгийн нүүрсний уурхайгаас 0.22 пунктээр тус тус бага буюу 1.06 байв.



2.1.43. Иймд аудитын баг Цанхийн баруун, зүүн хэсгийн хөрсний сийрэгжилтийн коэффициентийг ижил 1.23 байх нөхцөлд Цанхийн баруун хэсгийн хөрсний овоолгын хэмжээг тооцож, “Эрдэнэс таван толгой” ХК 2013-2017 онд гүйцэтгэсэн нийт хөрс хуулалтын хэмжээг 7.7 сая м³-ээр зөрүүтэй тайлагнасан байх магадлалтай гэж үзсэн болно.

2.1.44. Тус компаниас 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдөр ирүүлсэн нэмэлт баримт материалыг судалж үзэхэд Цанхийн баруун уурхайн 4.03 сая м³ хөрсийг бусад зам талбай /Бортээгийн технологийн зам 5.7 км, нүүрс тээврийн зам 10.4 км, нүүрсний агуулахын технологийн зам, талбай/ засахад, 4.28 сая м³ хөрсийг Цанхийн зүүн уурхайн хөрсний 2 дугаар овоолгод 2015 оны 6-8 дугаар сард буулгасан ба нийт 8.31 сая м³ хөрсийг АМГТГ-т хүргүүлсэн АҮАТ-нд иж бүрэн, үнэн зөв тайлагнаагүй байв. /дэлгэрэнгүйг хавсралт 9,10-д харуулав/

Гэрээт олборлогч 2012 онд захиалагч “Эрдэнэс таван толгой” ХК-ийн зөвшөөрөлгүй үндсэн гэрээг бусдад шилжүүлсэн байна

2.1.45. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2010 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 08 дугаар тогтоолын дагуу байгуулагдсан Үнэлгээний хороо /үнэлгээний хорооны ахлагч Б.Энэбиш/ нь “...Цанхийн зүүн хэсэгт олборлолтын үйл ажиллагаа эрхлэх компанийн сонгон шалгаруулалтыг 2011 онд 2 удаа нээлттэй явуулсан, шаардлага хангасан оролцогч ирээгүй шалтгаанаар шууд гэрээ байгуулах аргад шилжсэн...” гэж тайлбарласан боловч шууд гэрээ байгуулах тухай үнэлгээний хорооны зөвлөмж байхгүй, баримтаар нотлогдохгүй байна.

2.1.46. “Эрдэнэс таван толгой” ХК нь Цанхийн зүүн хэсгийн “Уул уурхайн хамтын ажиллагааны” гэрээг Сингапур улсын 100 хувийн хөрөнгө оруулалттай, Монгол улсад байгуулагдсан “Macmahon Mongolia” ХХК³³, Герман улсын “Оперта” ХХК нартай 2011 оны 10 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан байна.

2.1.47. “Уул уурхайн хамтын ажиллагааны гэрээ”-ний 14.2 дахь “...гэрээнд оролцогч аль ч тал гэрээнд оролцогч нөгөө талаас бичгээр урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр энэхүү гэрээ, эсвэл түүний аль нэг хэсгийг бусдад шилжүүлж болохгүй...” гэсэн заалтын дагуу “Эрдэнэс таван толгой” ХК гэрээ шилжүүлэх талаар зөвшөөрөл олгоогүй байхад “Macmahon Mongolia” ХХК, Герман улсын “Оперта” ХХК нь гэрээний эрхийг “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК³⁴-д “Уурхайн хамтын ажиллагааны гэрээний эрх шилжүүлэх гэрээ”-ээр 2012 оны 3 дугаар сарын 25-ны өдөр шилжүүлсэн байна.

2.1.48. Уг эрх шилжүүлэх гэрээнд “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК³⁵ нь эрх шилжүүлж буй “Macmahon Mongolia” ХХК, “Оперта” ХХК-ийг орлох, “Уул уурхайн хамтын ажиллагааны гэрээ”-ний бүхий л заалтуудыг дагаж мөрдөнө...” гэж заасан бөгөөд “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК нь уул уурхайн туслан гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлийг 2014 оны 02 дугаар сарын 14-ний өдөр авсан байна.

³³ Macmahon contracting international PTE.LTD төлөөлж захирал Ross Anthony Carroll захирлын олгосон эрхийн дагуу Neil Wilson 2011 оны 6 дугаар сарын 15-ны өдөр “Macmahon Mongolia” ХХК-ийг байгуулах шийдвэрийг гаргасны дагуу Монгол улсад байгуулагдаж, 2011 оны 06 дугаар сарын 20-ны өдөр улсын бүртгэлийн 5490774 регистрийн дугаар гэрчилгээг авч бүртгүүлсэн. Гэвч 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр оноосон нэрээ “Реакшионари сервис” ХХК болгон өөрчилсөн байна

³⁴ “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК нь Монгол улсад гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар /улсын бүртгэлийн дугаар 9019062115, регистрийн дугаар 5564964/ улсын бүртгэлийн гэрчилгээг 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдөр авсан. Компанийн гүйцэтгэх захирлаар Австрали улсын иргэн Эндрю Грабб 2012 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл, Австрали улсын иргэн Жадд Гринвэй 2012 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл, Австрали улсын иргэн Нэйл Вилсон 2015 оны 05 дугаар сарын 29-ний өдөр хүртэл, Австрали улсын иргэн Грегори Поол Геттингбай 2015 оны 08 дугаар сарын 01-ний өдөр хүртэл, Хонг Конг улсын иргэн Юнфэй Чен 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдөр хүртэл ажиллаж, мөн өдрөөс БНХАУ-ын иргэн Жао Чанг томилогдсон байна.

“Ти Ти Жи Ви Си Өү” ХХК-ийг үүсгэн байгуулагч нь Сингапур улсын “Five hills holding” PTE limited компани /Сингапур улсад бүртгэлтэй регистрийн дугаар 201135306М, захирал Ross Antoni Carroll, 2014 оны 5 сарын 07-ны өдрөөс захирал Субрандт ван Дайк, захирал Юнфэй Чен 2015 оны 06 дугаар сарын 23-ны өдрөөс/

“Ти Ти Жи Ви Си Өү” ХХК-ийн 2015 оны 06 дугаар сарын 23-ны өдөр гаргасан захирлын тогтоолд “...Макмахон Монгол Холдингс ПиТиИ Лимитэд” “Five hills holding” PTE limited -ийн гаргасан худалдах хувьцааг 100% эзэмшдэг, “Five hills holding” PTE limited нь компанийн гаргасан хувьцааг 100% эзэмшдэг болно... гэж бичсэн байна.

³⁵ “Five hills holding” PTE limited компанийн ТУЗ-ийн 2015 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн бичгээр гаргасан шийдвэрт “Макмахон Монгол Холдингс”, Macmahon contracting international PTE.LTD нь “компанийн өөрийн эзэмшлийн хувьцааг 65 сая ам.доллараар Хинюан групп Ко Лимитэд худалдсан” тухай дурдсан байна.



2.1.49. “Эрдэнэс таван толгой” ХК нь “ТиТи Жи Ви Си Өү” ХХК-тай 2012 оны 06 дугаар сарын 12-ны өдөр “Ажлын гэрээ” байгуулсан бөгөөд 2015 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр “Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон уурхайн хамтын ажиллагааны гэрээ”-г байгуулж, түүнд 2016, 2018 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. /дэлгэрэнгүйг хавсралт 11-д харуулав/

2.1.50. Цанхийн зүүн хэсгийн гэрээт олборлогч “Махмахон Монгол” ХХК-тай байгуулсан 2011 оны гэрээний 5.2-т “... гэрээг сунгах эрхтэй болохын тулд гүйцэтгэгч гэрээ хэрэгжиж эхлэх өдрөөс эхэлж 4 жилийн хугацаанд авах шаардлагатай ГГҮ /гүйцэтгэлийн гол үзүүлэлт/-ийн дундаж оноо 85 хувьтай...” гэж заасан ч гэрээ байгуулснаас хойш 2014 оны 7 сарыг дуусталх хугацаанд гэрээний хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй байна.


2.1.51. Мөн 2011 оны гэрээний хугацаа “5 жил” гэж байсныг 2015 оны гэрээнд “гэрээ хэрэгжиж эхлэх өдрөөс хойш хуанлийн 33 сар”, 2016 оны гэрээнд гэрээний хугацааг “38 сар” болгон өөрчилсөн боловч гэрээний хугацааг сунгах шалтгаан, үндэслэлийг тодорхой заагаагүй байна. /дэлгэрэнгүйг хавсралт 12-д харуулав/

Гэрээт олборлогч “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг бүрэн хангаагүй байна


2.1.52. Захиалагч “Эрдэнэс таван толгой” ХК олборлолтын үйл ажиллагаа явуулах эрхийг түр түдгэлзүүлсэн, төлөвлөгөөнд үндэслэлгүй тодотгол хийсэн зэргээс АҮАТ-ний хэрэгжилт хангалтгүй байна.

- Цанхийн зүүн хэсгийн уурхайн 2011-2017 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулж үзэхэд 2013-2017 онд “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК-ийн уулын цулын ажил 3.7-83.2 хувийн биелэлттэй;
- Цанхийн баруун хэсгийн уурхайн 2013-2017 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө гүйцэтгэлийг харьцуулж үзэхэд уулын цулын ажил 4.5-91.1 хувийн биелэлттэй байна,

Дүрслэл 2 Цанхийн зүүн хэсгийн 2011-2017 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл



Дүрслэл 3 Цанхийн баруун уурхайн 2013-2017 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл



Эх сурвалж: Аудитын баг

2.1.53. “Эрдэнэс таван толгой” ХК гэрээт олборлогч компаниудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлж дүгнэх, өдөр тутмын хяналт тавих үүрэг бүхий “Төслийн хяналтын баг” ажиллаж гүйцэтгэгч компанийн ажлыг сар бүр үйлдвэрлэл /уулын цулын хэмжээ/, нүүрсний чанар, ХАБЭА, байгаль орчин гэсэн 4 үндсэн чиглэлээр гарган үнэлж байсан ч нэгдсэн үнэлгээг хийгээгүй байна.



2.1.54. Төслийн хяналтын баг Цанхийн зүүн хэсгийн уулын цулын ажлыг хувиар, ХАБЭА, байгаль орчны үнэлгээг онооны системээр харилцан адилгүй үнэлж, нүүрсний чанарыг бүрэн үнэлээгүй, гэрээнд заасан нэгдсэн үнэлгээ өгөөгүй байна.

2.1.55. Цанхийн зүүн хэсгийн гэрээт олборлогч “Макмахон Монголиа” ХХК, “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК захиалагчтай 2011 он, 2015 онд байгуулсан гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байна. Тухайлбал:

- 2011 онд байгуулсан гэрээний 5.2-т “... гэрээг сунгах эрхтэй болохын тулд гүйцэтгэгч гэрээ хэрэгжиж эхлэх өдрөөс эхэлж 4 жилийн хугацаанд авах шаардлагатай ГГҮ /гүйцэтгэлийн гол үзүүлэлт/-ийн дундаж оноо 85 хувьтай... гэж заасан бөгөөд 2011-2014 оны дундаж оноо 64.5 хувьтай байгаа нь гэрээний шаардлагыг хангаагүй;
- 2015 оны гэрээнд заасан гүйцэтгэлийн гол үзүүлэлтийн оноо “...гэрээний аль ч хугацааны хувьд гэрээний хугацааны үе тус бүрийн нийт үйлдвэрлэл сар бүр 95%-с дээш ... байх” гэж заасан ч 2015 онд 3.7 хувьтай³⁶ байна.

2.1.56. Мөн 2017 оны анх батлагдсан АҮАТ-нд тусгагдсан уулын ажлын хэмжээг 2017 оны 8 дугаар сард 14.8 хувиар бууруулж үндэслэлгүйгээр тодотгосон нь олборлогчийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг өсгөх үндэслэл болсон гэж үзэхээр байна.

- Уурхайн хэлтсийн дарга Д.Цагаан-өвгөн “...уулын ажлын хэмжээнд олборлолт өсөж байгаа үед тодотгол төлөвлөгөө хийж байгаа, гүйцэтгэх захирал Б.Ариунболд үүрэг өгч Цанхийн зүүн хэмжээний олборлолт дээр гэрээний хэлцэлтэй холбоотой бууруулсан...” гэсэн тайлбарыг өгсөн болно.

Хүснэгт 10 “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 2017 оны ашиглалтын үйл ажиллагааны анхны төлөвлөгөө, тодотгол хийсэн төлөвлөгөөний харьцуулалт судалгаа

№	Үзүүлэлт	Анх баталсан	Тодотголын дүн	Зөрүү /өсөлт/бууралт/	
1	Хөрс хуулалт, мян.м3	32,000.0	27,386.0	4,614.0	-14.4%
2	Нүүрс олборлолт, мян.тн	7,920.0	7,200.0	720.0	-9.1%
3	Уулын цул, мян.м3	38,200.0	32,528.9	5,671.1	-14.8%

Эх сурвалж: Эрдэнэс Таван толгой” ХК

2.1.57. “Эрдэнэс таван толгой” ХК нь Цанхийн баруун хэсгийн гэрээт олборлогчийн гэрээний биелэлтийг үнэлэхдээ зөрүүтэй үнэлсэн байна. Үүнд:

- 2017 оны 3 дугаар сард ХАБЭА-н нэгдсэн үзүүлэлт 6.5 оноотой байхад 20 оноо гэж өсгөсөн,
- 2017 оны 5 дугаар сараас хойш ХАБЭА-н үзүүлэлтүүдийг үнэлээгүй байхад үнэлгээ өгсөн байна.

2.1.58. Хөдөлмөр, аюулгүй байдлын нийт 257 зөрчил бүртгэгдсэнээс 15.6 хувийн зөрчлийг арилгаагүй, ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авагдаагүй, уурхайн бүсэд хурд хэтрүүлсэн, техникийн үзлэг, оношилгоо хийгдээгүй зэрэг зөрчил гарч байсан байна.

2.1.59. Уурхайн талбайн хяналт сул байгаагаас 2017 онд нүүрсний овоолгод бохирдолтой болон хаягдал нүүрс буулгах, хөрсний овоолгод нүүрс болон бохирдолтой нүүрс буулгах, коксжих нүүрсний овоолгод исэлдсэн нүүрс буулгах, олборлолтын явцад таазны хөрс болон завсрын чулуугаар нүүрс бохирдуулах зэрэг технологийн горим зөрчигдсөн 247 тэвш буюу 5,297 м³ тохиолдол бүртгэгдсэн байна.

2.1.60. Байгаль орчныг хамгаалах, эрүүл аюулгүй байдалтай холбоотой түлш асгарснаас хөрс бохирдох, худгийн эрүүл ахуйн бүсийн дэглэм алдагдах, агаар, хөрсний үнэлгээний ажил хийгдээгүй байх, тоос дарагч бодис, мониторингийн багаж хэрэгсэл, тоос хэмжигч багажгүйгээс уурхайн тоосжилт бууруулах, шинэ техник технологи турших ажил хийгдээгүй зэрэг зөрчлүүд 3-16 удаа давтагдан гарчээ.

³⁶ Захиалагч “Эрдэнэс таван толгой” ХК 2014 оны 8 дугаар сарын 14-ний өдрөөс 12 дугаар сар хүртэл Цанхийн зүүн хэсгийн уурхайн үйл ажиллагааг түр зогсоосон



Гэрээт олборлогч “Макмахон Монголиа” ХХК-д 2012-2014 онуудад гэрээг дүгнээгүй байхад хөрөнгө оруулалтын ашиг, ашиг орлогын хувийг олгосон байна.

2.1.61. “Эрдэнэс таван толгой” ХК нь Цанхийн зүүн хэсгийн гэрээт олборлогчтой 2011 онд байгуулсан гэрээнд олборлолтын хөлсийг үйл ажиллагааны бодит зардлын³⁷ дүнгээр /зардлын дээд хязгаар байхгүй/ ам.доллараар төлнө гэж заасны дагуу “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК-д 2012 оноос 2014 оны 8 дугаар сарын хооронд нийт 116.4 сая ам.долларыг төлснөөс 5.2 сая ам.доллар буюу 8,279.4 сая төгрөгийг үндэслэлгүйгээр олгосон нь гэмт хэргийн шинжтэй байх тул хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах нь зүйтэй гэж үзлээ. Тухайлбал:

- Тус гэрээний 53-т “...ашиг орлогын эрсдэлийн хувь хэмжээг сар тутмын хөрөнгө оруулалтын 0.361 хувийг гүйцэтгэлийн гол үзүүлэлтийн оноогоор үржүүлсэн дүнгээр тооцож олгоно...”³⁸ гэж заасан боловч сар тутам гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг тооцож дүгнээгүй³⁹ байхад 3.1 сая ам.доллар,
- Гэрээний 39-т “... тоног төхөөрөмжийн ашгийн түвшнийг 0.811% тооцож...” гэж заасан хэдий ч “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК тоног төхөөрөмжийг өөрсдөө бэлтгээгүй, захиалагч “Эрдэнэс таван толгой” ХК-аас шилжүүлсэн байхад 2012 оноос 2013 оны хооронд 2.1 сая ам.долларыг олгосон байна.

2.1.62. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн ТУЗ-ийн 2012 оны 9 дүгээр сарын 23 дугаар тогтоол, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2013 оны 37 дугаар тогтоолоор “Эрдэнэс таван толгой” ХК-ийн эзэмшлийн тоног төхөөрөмж, машин механизмыг түүний гэрээт олборлогч “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК-д худалдах, шилжүүлэхээр шийдвэрлэж, гүйцэтгэх захирал Б.Энэбишийн 2013 оны А/318 дугаар тушаалаар 47 нэр төрлийн 78,808.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК-д шилжүүлж, өөрийн хөрөнгийн бүртгэлээс хассан байна.

2.1.63. Гэтэл дээрх шийдвэрүүд гарахаас өмнө “Эрдэнэс таван толгой” ХК 2012 оны 4 дүгээр сард “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК-тай 38 нэр төрлийн тоног төхөөрөмж, машин механизмыг 24 сая ам.доллар⁴⁰ буюу 31,988.0 сая төгрөгөөр худалдах, худалдан авах гэрээг байгуулж, 9 төрлийн 46,840.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг шилжүүлсэн байна.

2.1.64. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1⁴¹, ТӨХ-ийн /хуучин нэрээр/ 2012 оны 44 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 6.1-д “... төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг, ...гагцхүү дуудлага худалдаагаар худалдаж болно...” гэж заасныг тус тус зөрчсөн байх тул хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах нь зүйтэй байна.

Гэрээт олборлогчид олборлолтын хөлсийг бодит зардлаар, гадаад валютаар төлснөөс их хэмжээний ханшийн алдагдал хүлээсэн байна.

2.1.65. “Эрдэнэс таван толгой” ХК Цанхийн зүүн хэсгийн гэрээт олборлолтын хөлсийг 1м³ уулын цулын үнээр, ам.доллараар, 2015 оноос тооцож эхэлсэн бөгөөд уг үнийг бууруулах зорилгоор 4 удаа өөрчлөлт оруулсан хэдий ч үнэ буураагүй, 2017 оны байдлаар 4.39 ам.доллар буюу 10,515.8 төгрөг байгаа нь Цанхийн баруун уурхайн олборлолтын үнээс 62.4

³⁷ Бодит зардал: Гүйцэтгэгчийн боловсон хүчний бодит зардал, даатгалын бодит зардал, сар тутмын төлбөрийг ам.долларт хөрвүүлсэн зардал, тоног төхөөрөмж өмчлөх бодит зардал зэрэг үйл ажиллагаатай холбогдуулан гүйцэтгэгчийн зарцуулсан бодит зардал, эсвэл захиалагчийн заавал эсвэл төслийн хяналтын багийн шийдвэрийг биелүүлэхэд гаргасан бодит зардлын дүн.

³⁸ Гэрээний 53-т ашиг орлогын хувь хэмжээ гэж сар тутмын хөрөнгө оруулалтын 0,361 хувийг ГГҮ/гүйцэтгэлийн гол үзүүлэлт/-ийн оноогоор үржүүлсэн дүнг хэлнэ.

³⁹ Гэрээний 30-т ГГҮ-ийн хүснэгт гэж гүйцэтгэгчийн гүйцэтгэлийг сар тутамд тооцож гаргадаг гүйцэтгэлийн гол үзүүлэлтийн хүснэгтийг хэлнэ.

⁴⁰ “ТиТиЖиВиСиӨү” ХХК 2012 оны 05 дугаар сарын 11-ны өдөр төлбөрийг төлсөн

⁴¹ “...Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдахад Засгийн газрын, төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын, бусад эд хөрөнгийг тухайн хуулийн этгээдийн шийдвэрээр гагцхүү дуудлага худалдаагаар худалдаж болно...”



хувиар өндөр байгаагаас олборлолтын хөлсийг 407.3 сая төгрөгөөр хэмнэх боломжийг алдаж байна.

Хүснэгт 11 Цанхийн зүүн, баруун хэсгийн 1 м³ уулын цулын үнийн харьцуулалтын нэгтгэл

№	Хугацаа	Цанхийн зүүн хэсгийн уулын цулын хэмжээ, м³	1м³ уулын цулын хэмжээ /төгрөг/		зөрүү		Олборлолтын хөлс		
			Цанхийн зүүн	Цанхийн баруун	төгрөг	хувь	Цанхийн зүүн	Цанхийн баруун	зөрүү
1	2015 он	35,381.8	8,727	6,800	1,927	28.3	308.8	240.6	68.2
2	2016 он	31,774.8	8,033	5,900	2,133	36.2	255.2	187.5	67.8
3	2017 он	67,156.7	10,516	6,475	4,041	62.4	706.2	434.8	271.4
Нийт							1,270.2	862.9	407.3

Эх сурвалж: Аудитын баг

2.1.66. 2015 онд 1м³ уулын цулын үнэ 4.37 ам.доллар, 2016 онд 4.36 ам.доллар, 2018 онд 3.99 ам.доллар /НӨАТ-гүй/ болгосон боловч НӨАТ-тэй дүнгээр 4.39 ам.доллар болж өмнөх үнээс 0.03 ам.доллараар өссөн байна.

Хүснэгт 12 Цанхийн зүүн хэсгийн гэрээт олборлогчийн гэрээний олборлолтын үнэд өөрчлөлт орсон судалгааны нэгтгэл /ам доллар, төгрөг/

№	Гэрээний огноо	Үйлчлэх хугацаа	1 м3 уулын цулын үнэ /ам.доллар/	Үнийн өөрчлөлт өмнөхөөс /буурсан-, өссөн+/-	Гэрээ байгуулсан өдрийн 1 ам.долларт хөрвөх ханш	Олборлолтын хөлс 1м3 уулын цулын хэмжээ /төгрөг/	Үнийн өөрчлөлт /буурсан-, өссөн+/-
1	2015 оны 09 дүгээр сарын 29 ны өдөр	2015.12.24 /НӨАТ-тэй/	4.37		1996.99	8726.85	
2	2016 оны 02 дугаар сарын 02-ны өдөр	2017.01.01 хүртэл	3.99	-0.38	2013.39	8033.43	-693.42
3		2017.01.01-ээс эхлэн	4.36	0.37		8778.38	+744.95
4	2018 оны 03 дугаар сарын 14-ны өдөр	2017.01.02-ноос 2017.12.31-ний өдөр хүртэл 3.99 /НӨАТ-гүй/	4.39	0.03	2395.40	10515.81	+1737.43

Эх сурвалж: Цанхийн зүүн хэсгийн

2.1.67. Цанхийн зүүн хэсгийн гэрээт олборлогчтой байгуулсан гэрээнд аливаа төлбөрийг ам.доллараар төлөхөөр зааснаас нийт 28,098.2 сая төгрөгийн ханшийн алдагдал хүлээсэн нь Монгол улсын Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1⁴² дэх заалттай нийцэхгүй байна.

Хүснэгт 13 Цанхийн зүүн хэсгийн гэрээт олборлогчтой байгуулсан гэрээг гадаад валютаар хийснээс “Эрдэнэс таван толгой” ХК-д үүссэн ханшийн алдагдлын судалгаа /сая төгрөг/

№	Хамрагдах огноо	Хэрэгжсэн ашиг (алдагдал)
1	2013 он	(3,426.7)
2	2014 он	(738.7)
3	2015 он	11.3
4	2016 он	(24,874.8)
5	2017 он	939.7
	Нийт	(28,089.2)

Эх сурвалж: “Эрдэнэс таван толгой” ХК-ийн санхүүгийн тайлан

2.1.68. Уг ханшийн алдагдал нь “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2015-2017 оны байдлаарх нийт ашиг /алдагдал/-д 22.9 хувь, 2016 онд 46.6 хувийг эзэлж байна.

2.1.69. Цанхийн зүүн хэсэгт “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК нь туслан гүйцэтгэгчээр “Моннис” ХХК, “Хишиг арвин индустриал” ХХК-ийг ажиллуулдаг бөгөөд аудитын баг 2016-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаар уулын ажлын хэмжээг экскаваторын болон авто самосвалын бүтээлээр нь тооцож үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

⁴² Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно



Хүснэгт 14 Цанхийн зүүн хэсгийн үндсэн гэрээт олборлогч болон туслан гүйцээгчдийн ажлын бүтээлийн нэгтгэл

Жил	“Моннис” ХХК		“Ти Ти Жи Ви Си Өү” ХХК		“Хишиг арвин индустриал” ХХК		Нийт
	мян.м³	Хувь, %	мян.м³	Хувь, %	мян.м³	Хувь, %	
2016	6,229.85	17.30	19,731.03	54.79	10,054.14	27.92	36,015.01
2017	8,337.26	26.26	18,011.61	56.73	5,400.19	17.01	31,749.06
2018	2,981.24	17.16	8,641.32	49.74	5,749.98	33.10	17,372.54
Нийт	17,548.35	20.61	46,383.95	54.48	21,204.31	24.91	85,136.61
Жил	Автосамосвалын бүтээл		Экскаваторын бүтээл				Нийт
	мян.м³	Хувь, %	мян.м³	Хувь, %	мян.м³	Хувь, %	
2016	6,909.01	19.18	10,724.71	29.78	18,381.30	51.04	36,015.01
2017	9,143.87	28.80	11,209.68	35.31	11,395.52	35.89	31,749.06
2018	2,708.24	15.59	9,655.98	55.58	5,008.33	28.83	17,372.54
Нийт	18,761.11	22.04	31,590.36	37.11	34,785.14	40.86	85,136.61

Эх сурвалж: “Эрдэнэс таван толгой” ХК

2.1.70. Энэ нь “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК-ийн туслан гүйцэтгэгч “Моннис” ХХК, “Хишиг арвин индустриал ХХК нь автосамосвалын 62.9 хувь, экскаваторын 45.5 хувийг гүйцэтгэсэн нь туслан гүйцэтгэгч компаниуд нүүрс олборлолтын ихэнх ажлыг гүйцэтгэж байгааг харуулж байна.

2.1.71. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн ТУЗ-ийн хурлаар Цанхийн зүүн уурхайн гэрээт олборлогч “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК-тай байгуулсан гэрээний асуудлаар хэлэлцэхдээ үнэд өөрчлөлт оруулах, цаашлаад гэрээг цуцлах тухай асуудлыг 2014 онд 2 удаа, 2015 онд 1 удаа тус тус хэлэлцэж, гүйцэтгэх захирал Я.Батсуурийн 2014 оны А/64 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулагдан тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байжээ. /дэлгэрэнгүйг хавсралт 14-д харуулав/

2.1.72. Мөн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайханы 2015 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар “Эрдэнэс таван толгой” ХК, “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК-ийн хооронд байгуулсан “Уул уурхайн хамтын ажиллагааны гэрээ”-ний асуудлаар хэлэлцээ хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан боловч ажлын хэсгийн тайлан, холбогдох баримт байхгүй байгаа тул үр дүнг нягтлах боломжгүй байлаа.

2.1.73. “Эрдэнэс таван толгой” ХК гэрээт олборлогчтой 2011 онд байгуулсан гэрээ нь захиалагч бодит зардлыг хянах боломж хязгаарлагдмал, аливаа маргааныг шийдвэрлэхдээ үнийн дүнгээс хамааруулан Монгол улсын болон Сингапур улсын арбитрын шүүхээр шийдвэрлүүлэх, 2015 онд байгуулсан гэрээ нь “...Сингапур дахь Олон улсын арбитрын шүүхэд маргааныг шийдүүлэх...” гэж заасан, гадаад хэл дээр гэрээ байгуулагдсан нь Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “...Монгол Улсын нутаг дэвсгэрт дараах үйл ажиллагаа, албан хэргийг монгол хэлээр хөтлөн явуулна...”, 6.1.1-т “...төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, албан хэрэг хөтлөлт...”, 6.7.Монгол Улсад аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаадын хуулийн этгээд, төрийн бус байгууллага Монгол Улсын төрийн байгууллага, иргэнтэй монгол хэлээр харилцаж, санхүү, татвар, хөдөлмөр, ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдолтой баримт бичиг, мэдээллийг монгол хэлээр үйлдэнэ...” гэж заасныг зөрчсөн байна.

2.1.74. Талуудын 2011 онд байгуулсан үндсэн гэрээг “Эрдэнэс таван толгой” ХК-ийн зөвшөөрөлгүй бусдад шилжүүлсэн, 5.2 сая ам.доллар буюу 8,279.4 сая төгрөгийг үндэслэлгүйгээр олгосон, 2015 онд байгуулсан гэрээ нь олборлолтын хөлсийг 407.3 сая төгрөгөөр хэмнэх боломжийг алдахад хүргэсэн, төлбөрийг ам.доллараар төлөхөөр зааснаас нийт 28,098.2 сая төгрөгийн ханшийн алдагдал хүлээсэн, гэрээний хугацааг сунгасан шалтгаан тодорхойгүй зэргээс харахад гэрээт олборлогчид хэт давуу байдал олгосон байж болзошгүй, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн тул хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах нь зүйтэй байна. /дэлгэрэнгүйг хавсралт 15-д харуулав/



Хууль тогтоомжийн дагуу нийгмийн хариуцлагын чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна

Уурхайн хаалтын төсөл, төлөвлөгөөг боловсруулаагүй байна

2.1.75. Цанхийн зүүн хэсгийн байгаль орчны ерөнхий үнэлгээг “Их айлчин” ХХК 2011 онд, баруун хэсгийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг “Натур френдли” ХХК 2012 онд гүйцэтгэсэн байна.

2.1.76. “Цанхийн баруун хэсгийг ашиглах төсөл”-ийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд⁴³ уурхайн хаалт, нөхөн сэргээлт, экологи-эдийн засгийн үнэлгээг гаргасан бөгөөд “уурхайн хаалтын төсөл, түүнд шаардагдах зардлыг олборлолт эхлэхээс өмнө буюу олборлолтын эхний үе шатанд багтааж гаргах, хаалтын төлөвлөгөө нь бизнес төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг болох ба хаалтын зардлыг тогтмол хянаж, өөрчлөлттэй уялдуулна...” гэж заасан ч “Эрдэнэс таван толгой” ХК өнөөдрийг хүртэл уурхайн хаалтын төсөл, төлөвлөгөөг боловсруулаагүй байна.

2.1.77. Энэ нь Цанхийн хэсгийн ордын ашиглалтын 30 жилийн хугацаанд нийт 2,748,9 га талбай эвдрэлд орж байгалийн унаган төрх алдагдах, ус, хөрс, ургамал, геологи, геоморфологийн олон элементүүд эвдрэл доройтолд орохоор байгаа тул уурхайн олборлолт явуулсан талбайд нөхөн сэргээлтийн ажлын хэмжээг олборлолтын ажилтай уялдуулан зохистой харьцааг тогтоож төсөл, төлөвлөгөөг боловсруулах зайлшгүй шаардлагатай байна.

Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн санд бодитоор хөрөнгө төвлөрүүлээгүй, байгаль орчныг нөхөн сэргээхэд хүрэлцэхээргүй байна

2.1.78. Цанхийн баруун, зүүн хэсгийн уурхайн олборлолт, ашиглалтын үед газрын хэвлий, газрын нөөц, хөрсний бүрхэвч, ургамлын нөмрөг, гадаргын ус, агаарын бохирдол учирч болох хохирлыг нарийвчлан судалж, ТЭЗҮ-ийн 30 жилийн хугацаанд экологи эдийн засгийн хохирлын хэмжээг нийт 611,838.9 сая төгрөг гэж тооцоолжээ.

Хүснэгт 15 Цанхийн баруун, зүүн хэсгийн төслийн хаалт, нөхөн сэргээлт, экологи-эдийн засгийн байгаль орчинд учруулах хохирлын нийт хэмжээ, үнэлгээний нэгтгэл

№	хохирлын төрөл	Цанхийн баруун хэсгийн хохирлын нийт хэмжээ /сая төгрөг/	Цанхийн зүүн хэсгийн хохирлын нийт хэмжээ /сая төгрөг/	Уурхайн нийт хохирлын хэмжээ /сая.төг/
1	Нийт хохирлын дүн	10,085.0	601,754.0	611,838.9
2	ТЭЗҮ-ийн дагуу ашиглах жил	30	30	30
3	Ашиглалтын 1 жилд учрах хохирлын дүн	336.2	20,058.5	20,394.6

Эх сурвалж: Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан /“Их айлчин” ХХК, “Натур френдли” ХХК/

2.1.79. “Цанхийн зүүн хэсгийн ил уурхайгаар ашиглах ТЭЗҮ” болон уг ТЭЗҮ-г хүлээн авах тухай ЭБМЗ-ийн 2011 оны 02-03 дугаар хурлын тэмдэглэлд “...байгаль орчинд жилд борлуулалтын орлогын 1 хувиар тооцож 30 жилд 280 сая ам доллар... уурхайн хаалтын санг бий болгох...” гэж заасан нь “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ”-нд заасан дүнгээс 36.3 хувиар бага төдийгүй ТЭЗҮ-д уг үнэлгээг хэрхэн тооцсон нь тодорхойгүй байна.

2.1.80. Хэрэв Цанхийн хэсгийн ашиглалтын 30 жилд учрах хохирлын хэмжээг тухайн ашиглалтын 1 жилд оногдуулан 20,394.6 сая төгрөгөөр тооцвол уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн санг 2012-2017 оны хооронд нийт 142,762.4 сая төгрөгөөр бүрдүүлэхээр байжээ.

⁴³ Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, зөвлөх үйлчилгээний “Натур Френдли” ХХК.



2.1.81. “Эрдэнэс таван толгой” ХК 2012-2017 онд ТЭЗҮ-д заасны дагуу уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн санд төвлөрөх хөрөнгийг борлуулалтын 1 хувиар тооцож нийт 31,808.5 сая төгрөгийг ирээдүйд төлөх өр төлбөрөөр санхүүгийн тайланд тусгасан нь НББОУС-ын 37⁴⁴ заалттай нийцээгүй байна.

2.1.82. Тухайн газрын экологи, эдийн засгийн хохирлын үнэлгээний тодорхой хувиар тооцож уурхайн нөхөн сэргээлт, хаалтын санг бүрдүүлээгүй, мөнгөн хөрөнгө төвлөрүүлээгүй нь Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.14-т “...уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах...” гэж заасны дагуу БОАЖЯ, УУХҮЯ уг журмыг батлаагүйтэй холбоотой байна.

2.1.83. Компанийн нийгмийн хариуцлагыг Олон улсын стандартын байгууллагаас 2010 онд гаргасан ISO26000-д үндсэн 6 чиглэлийг тусгасан байдаг бол “Эрдэнэс таван Толгой” ХК Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг даргатай 2013 онд байгуулсан “Хамтран ажиллах санамж бичиг”-т үндсэн 3 чиглэлийг тусгасан байна. Үүнд:

Хүснэгт 16 Компанийн нийгмийн хариуцлагыг Олон улсын стандарттай харьцуулсан харьцуулалтын нэгтгэл

ISO26000	“Эрдэнэс таван толгой” ХК
Хүний эрх, эрх чөлөө /Human rights/	
Хөдөлмөрийн харилцаа /Labor practices/	
Байгаль орчин /The environment/	Байгаль орчин
Бизнесийн шударга харилцаа /Fair operating practices/	
Орон нутгийн оролцоо ба хөгжил /Community involvement and development/	Орон нутгийн оролцоо ба хөгжил
Талуудын асуудал /Consumer issue/	Талуудын асуудал

Эх сурвалж:

2.1.84. Дээрх “Хамтран ажиллах санамж бичиг”-т тусгасан компанийн зүгээс нийгмийн хариуцлагын чиглэлээр бодлого боловсруулаагүй, 3 чиглэлийн 27 арга хэмжээний 4 нь бүрэн хэрэгжээгүй, 23 нь хэрэгжээгүй, мөн санамж бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээг жилээр төлөвлөн, үр дүнг дүгнэж байх гэж заасан ч үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулаагүй байна.

2.1.85. АМТХ-ийн 42 дугаар зүйлийн 42.1⁴⁵, “Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам”-ын 8.5⁴⁶, Цанхийн баруун хэсгийн ТЭЗҮ-д “орон нутгийн өөрөө удирдах байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллах” гэж заасан ч уурхайн үйл ажиллагаа эхэлснээс хойш 5 жилийн дараа буюу 2018 оны 5 сард “Хамтын ажиллагааны гэрээ”-г байгуулжээ.

⁴⁴ Нөөцөөр хүлээн зөвшөөрөгдсөн дүн нь тайлант үеийн эцэст өнөөгийн үүрэг хариуцлагыг биелүүлэхэд шаардагдах зарлагын хамгийн сайн тооцоолол байх ёстой”

⁴⁵ Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.

⁴⁶ Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.



КОМПАНИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, АЖИЛТНУУД ЧИГ ҮҮРГИЙН ДАВХАРДАЛТАЙ, ДОТООД ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА

Компанийн зохион байгуулалт бүтэц, орон тооны өөрчлөлтийг тооцоо судалгаагүйгээр хийж иржээ

Зарим газар нэгжийн зарим чиг үүргүүд давхцаж байна

2.2.1. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн үндсэн зорилго нь стратегийн ач холбогдол бүхий Таван толгойн ордод ашигт малтмалын тухай хуулийн дагуу ашиглалтын үйл ажиллагаа явуулж сайн чанарын нүүрсний “ТТ” брэндийг бий болгож, байгаль орчинд аюулгүй, тогтвортой, хариуцлагатай уул уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлэн улс орны болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд бодит хувь нэмэр оруулах, хувьцаа эзэмшигчдэд ашиг хүртээхэд оршиж байна.

2.2.2. Компанийн үндсэн зорилгыг хэрэгжүүлэх зорилгоор 2011 онд байгуулагдсанаас хойш зохион байгуулалтын бүтцийг ТУЗ-ийн 2012 оны 05 дугаар тогтоол, 2013 оны 45, 63 дугаар тогтоол, 2015 оны 29 дүгээр тогтоол, 2016 оны 07, 20 дугаар тогтоол, 2018 оны 26, 33 дугаар тогтоолуудаар ерөнхий захиргааны хэсэг, уурхайн хэсэг гэсэн ерөнхий бүтэц зохион байгуулалттайгаар нийт 8 удаа шинэчлэн баталж иржээ. Үүнд:

- Төв оффис буюу ерөнхий захиргааны хэсгийн бүтэц 2012, 2013, 2016, 2018 онуудад 6 удаа,
- Уурхайн хэсгийн бүтэц 2012, 2013, 2015, 2016, 2018 онуудад 6 удаа,

2.2.3. “Эрдэнэс таван толгой” ХК 2016 оны 2 дугаар сараас хойш компанийн стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөөнд тусгагдсан ус хангамж, зам, баяжуулах үйлдвэр, эрчим хүч зэрэг дэд бүтцийн төслүүдийг хариуцсан нэгжгүй, 2016 оны 11 дүгээр сарыг хүртэл нийт ажилтнууд албан тушаалын ажлын байрны тодорхойлолтгүй ажиллаж иржээ.

2.2.4. Компанийн зохион байгуулалтын бүтцийг 2018 оны 8, 10 дугаар саруудад дахин шинэчилсэн боловч газар, нэгжүүдийн чиг үүргийн хуваарь шинэчлэн батлагдаагүй байна. Мөн зарим газар, нэгжүүдийн чиг үүргийн давхардалтай байгаагаас орон тоо, санхүүгийн нөөцийг хэмнэх боломжийг алдаж байна. Тухайлбал:

- Компанийн хөгжлийн бодлого, стратеги, урт болон богино хугацааны төлөвлөгөө, төсвийн төсөл боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг Бизнес төлөвлөлт, инновацын хэлтэс, Эдийн засаг хөрөнгө оруулалтын хэлтсүүд,
- Шинэ болон хэрэгжиж буй төслүүдийн эдийн засгийн үр ашгийг тооцох, төслийн хэрэгжилттэй холбоотой чиг үүргийг Дэд бүтцийн хэлтэс, Төслийн удирдлагын хэлтэс, Эдийн засаг, хөрөнгө оруулалтын хэлтэс, Бизнес төлөвлөлт, инновацын хэлтсүүд болон Санхүүгийн шинжилгээний алба,
- Мөнгөн хөрөнгө, гадаад валютын урсгалыг оновчтой хуваарилах, валютын арилжааг компанид ашигтай хувилбараар гүйцэтгэх санал боловсруулах, эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой тооцоо, судалгааг хийх чиг үүргийг Санхүүгийн хэлтэс, Эдийн засаг, хөрөнгө оруулалтын хэлтэс, Нягтлан бодох бүртгэлийн хэлтсүүд,
- Татвар, татварын тооцоолол хийж тайланг гаргах, зохих байгууллагуудад тушаах чиг үүргийг Санхүүгийн хэлтэс, Нягтлан бодох бүртгэлийн хэлтсүүд тус тус хэрэгжүүлэхээр давхардуулан заажээ.




2.2.5. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан зохион байгуулалтын бүтцэд шинээр бий болсон Ерөнхий аудиторын алба, Гүйцэтгэх захирлын ажлын албадын чиг үүргийг бусад газар нэгжээр гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нягтруулах замаар дээрх албадыг татан буулгах нь зүйтэй байна. Үүнд:

- Компанийн ажилтнуудыг ажиллах орчин нөхцөлөөр хангах, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх, бусад хэлтэс нэгжийн хэвийн үйл ажиллагааг дэмжих нийтлэг үйлчилгээг үзүүлэх чиг үүрэгтэй 57 орон тоотой Ерөнхий удирдлагын газар, тухайлсан бодлогын асуудлыг хариуцсан газрууд бодлогоо тодорхойлон үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхээр байхад гүйцэтгэх захирлын үйл ажиллагааг удирдлагаар ханган зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий 5 зөвлөх, тэдгээрийн ажлыг удирдан уялдуулах албаны дарга, менежер, 2 туслах нийт 9 орон тоотой Гүйцэтгэх захирлын ажлын алба,
- ТУЗ-ийн ажлын албаны ажилтнууд ТУЗ-ийн хурлын бэлтгэл хангах, хурлын тэмдэглэлээс өөр ажлын үр дүнгүй ажлын гүйцэтгэл хангалтгүй, байхад орон тоог 5 болгон нэмэгдүүлж, 3 орон тоо бүхий Ерөнхий аудиторын албыг тус тус шинээр байгуулахаар байна.

2.2.6. Аудитын явцад авсан санал асуулгад оролцогчдын 66 хувь нь “байгууллагын бүтэц зохион байгуулалт оновчгүй, Стратеги, бодлого төлөвлөлтийн хэлтэс, Төлөвлөлт эдийн засгийн хэлтэс, Борлуулалтын газар, Маркетингийн газар, Санхүүгийн бүртгэлийн хэлтэс, IPO хариуцсан газар, Хууль зүйн баримт боловсруулах, хянах хэлтэс, захиргааны хэлтсүүд /хуучин нэрээр/ үр ашиггүй, давхардал ихтэйгээс шат дамжлага, хүнд суртал ихэссэн” гэж хариулсан нь дээрх дүгнэлтийг бататгаж байна.

2.2.7. Компанийн нийт орон тоо 2016 онд 617 байсан бол 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар 747 болж уурхай 10.5 хувиар нэмэгдсэн байхад Ерөнхий захиргаа 62.9 хувиар нэмэгдсэн нь ажлын байрны хэрэгцээ шаардлагад бүрэн үндэслээгүйг харуулж байна.



Эх сурвалж: “Эрдэнэс таван толгой” ХХК

2.2.8. Уурхайн Цанхийн хэсэгт үйл ажиллагаа явуулж буй гэрээт олборлогч болон бусад туслан гүйцэтгэгч компаниудын ажилтнуудыг ⁴⁷ оруулан тооцвол нийт 2947 ажилтан ажиллаж байгаа бөгөөд Цанхийн баруун, зүүн хэсгүүдийн ТЭЗҮ-д батлагдсан нийт орон тооноос ⁴⁸ 65.6 хувиар илүү байна.

Хүснэгт 17 Компанийн бүтэц орон тооны өөрчлөлтийн судалгаа /ерөнхий захиргаа/

⁴⁷ Уурхайд ажиллаж гэрээт олборлогч компани, туслан гүйцэтгэгч, катерингийн үйлчилгээ үзүүлэх компани, харуул хамгаалалт зэрэг нийт 2200 орчим ажилтан ажиллаж байгаа гэсэн тооцоо ЭТТ ХК-д байдаг

⁴⁸ Цанхийн баруун уурхайн ТЭЗҮ-д нийт 965, зүүн уурхайн ТЭЗҮ-д нийт 815 хүн, нийт 1780 хүн ажиллахаар тооцсон.



ТУЗ-ийн шийдвэрийн огноо	2016.02.05-ны 07 дугаар тогтоол	2016.09.09-ны 20 дугаар тогтоол	2018.08.23-ны 26 дугаар тогтоол	2018.10.26-ны 33 дугаар тогтоол
Удирдах албан тушаалтан	23	23	26	31
Гүйцэтгэх албан тушаалтан	101	101	160	171
Бүгд	124	124	186	202

2.2.9. Компани хүний нөөцийн бодлогодоо “эрхэм зорилго, алсын хараа, стратеги төлөвлөгөөнд тулгуурлан хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлно” гэж заасан ч албан тушаалын зорилго чиг үүрэг, үйл ажиллагаа, үүрэг хариуцлага, эрх мэдэл, тавигдах шаардлагыг тодорхойлсон дүн шинжилгээ хийгээгүй, батлагдсан ажлын байрны тодорхойлолтгүй, сонгон шалгаруулалтгүйгээр хүний нөөцийг бүрдүүлж байгаагаас ажил үүргийн давхардал бий болж ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх боломжгүйд хүрч байна.

2.2.10. Компанийн хэмжээнд удирдах албан тушаалтны тоо 2016 онтой харьцуулахад 35 хувиар өссөн бөгөөд ажлын байрны хэрэгцээ шаардлагыг тодорхойлоогүй, батлагдсан ажлын байрны тодорхойлолтгүй, чиг үүргийн давхардал бүхий 16 ажилтан 1.9-5.3 сая төгрөгийн цалинтайгаар ажиллаж байгаагаас сар бүр 65.5 сая төгрөг хэмнэх боломжийг алдаж байна. Үүнд:

- 2018 оны 8, 10 дугаар сарын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр газрын захирлаар ажиллаж байсан 5 ажилтнуудыг “зөвлөх”, “албаны дарга” гэсэн албан тушаалыг шинээр бий болгон цалингийн шатлалыг бууруулахгүйгээр сард 5.3 сая төгрөгийн цалинтайгаар,

Хүснэгт 18 Зөвлөх, албаны дарга нарын судалгаа

№	Өмнөх албан тушаал	Одоогийн албан тушаал	Овог, нэр
1	Худалдан авалт, дэд бүтэц эрхэлсэн дэд захирал	Зөвлөх	Ц.Хангай
2	Захиргаа удирдлагын газрын захирлын	Засаглал хариуцсан ахлах зөвлөх,	Ө.Сумъяабаатар
3	Борлуулалтын газрын захирал	Борлуулалт хариуцсан маркетингийн зөвлөх	О.Хатанбаатар
4	Хууль зүйн газрын захирал	Хуулийн ерөнхий зөвлөх	Э.Онон
5	Геологи уул уурхай хариуцсан газрын захирал	Ерөнхий инженер бөгөөд Гүйцэтгэх захирлын ажлын албаны дарга	Б.Мөнхбаатар

- Газар, хэлтсийн нэгжийн даргын чиг үүрэгтэй давхардал бүхий менежерийн орон тоог шинээр бий болгож нийт 9 ажилтныг сард 3.9 сая төгрөгийн цалинтайгаар,
- Уурхайн ачилт, экспортын албанд дарга, ахлах мэргэжилтэн хариуцан ажиллах боломжтой чиг үүргийг гаалийн хяналтын бүсийн эрхлэгчид хариуцуулан ажиллуулснаас 2 ажилтан 1.9 сая төгрөгийн цалинтайгаар тус тус ажиллаж байна

2.2.11. Мөн компанийн захиргааны хэсгийн захиргааны шийтгэл хариуцсан мэргэжилтэн, тушаал хариуцсан мэргэжилтэн, дотоод дүрэм журам хариуцсан мэргэжилтэн, захиалгын хуудас хариуцсан мэргэжилтэн, хүний нөөцийн мэргэжилтэн зэрэг ажлын ачаалал багатай албан тушаалуудыг нэгтгэх боломжтой байна.

2.2.12. Аудитын явцад санал асуулгаар “ажил үүргийн давхардалтай, шаардлагагүй орон тоо байна уу” гэсэн асуултад оролцогчдын 68.4 хувь менежер, 42.1 хувь зөвлөх, 21.0 хувь компанийн болон нэгжийн удирдлага, 13.6 хувь нь гэрээт болон туслах ажилтан гэж хариулсан байна.

2.2.13. Гүйцэтгэх захирлын 2011 оны 32 дугаар тушаалаар батлагдсан “Ажилтан сонгон шалгаруулах журам”-ын дагуу ажил горилогчдын сан үүсгэж байгаа ч 2016-2018 онд 54-146 ажилтныг сонгон шалгаруулалтгүйгээр шууд ажилд авсан байна.



Хүснэгт 19 Ажилтнуудын шилжилт, хөдөлгөөн

Үзүүлэлт	2016 он			2017 он			2018.10 дугаар сар		
	уурхай	оффис	нийт	уурхай	оффис	Нийт	уурхай	оффис	нийт
Гүйцэтгэх захирал	Т.Билгээ 2015.01.13-2016.09.01			Д.Ариунболд 2016.09.01.-2018.04.04			Б.Ганхуяг 2018.04.04-ний өдрөөс		
шинээр орсон	51	51	102	31	23	54	70	76	146
шилжсэн	24	35	59	32	15	47	40	20	60
Үүнээс албан тушаал дэвшсэн	8	8	16	3	15	18	40	20	60

Эх сурвалж: Аудитын баг

2.2.14. Зарим албан тушаалд тавигдах шалгуур үзүүлэлтийг албан тушаалын шатлалтай уялдуулаагүй, үндэслэл муутай, ерөнхий боловсруулсан байгаа нь тухайн ажилтанд зориулан ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж байгааг харуулж байна. Тухайлбал:

- Төрийн захиргааны байгууллагуудын мэргэшсэн зэрэг олгох журамд мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх шаардлагыг тавьдаг хэдий ч хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч, стратеги төлөвлөлтийн мэргэжилтэн зэрэг албан тушаалын шалгуур үзүүлэлтэд мэргэшсэн, 3 жилээс доошгүй ажилласан байх гэж заасан,
- Мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, газрын захирал боловсролын зэргийн хувьд бакалавр буюу түүнээс дээш гэж ижил түвшинд байхаар заасан байна.

2.2.15. Зарим албан тушаалд ажлын байрны шалгуур үзүүлэлтийг хангаагүй мэргэжлийн бус хүмүүс ажиллаж байгаа бөгөөд батлагдсан ажлын байрны тодорхойлолтгүй, ажилтнуудын хувийн хэрэг иж бүрэн бус, хувийн хэргийн баяжилт тогтмол хийгдээгүй байгаагаас нийт ажилтнуудын хэмжээнд ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан эсэхийг бүрэн нягтлах боломжгүй байна. Тухайлбал:

- Худалдан авалт, ханган нийлүүлэлтийн газрын захирлаар багш-орчуулагч,
- Маркетингийн газрын ахлах мэргэжилтэн – аялал жуулчлалын мэргэжилтэн,
- Дэд бүтэц, тээврийн ахлах мэргэжилтэн – багш, түүх философич,
- Хүний нөөцийн албаны менежер – улс төр судлаач,
- Захиргааны хэлтсийн дарга – олон улсын сэтгүүлч мэргэжил эзэмшсэн байна,

2.2.16. Мөн ажилтнуудын ажлын ачаалал, уялдаа холбоо, ажлын байрны орчинд судалгаа, шинжилгээ хийж байгаагүй, ажлын гүйцэтгэлийг үнэлэх үзүүлэлт тодорхойгүй, хүний нөөцийн программын ашиглалт хангалтгүй байгаа нь хүний нөөцийн албаны үйл ажиллагаа хангалтгүй, ажлын хариуцлагыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

2.2.17. Шилжилт хөдөлгөөн ихтэйгээс ажилтнууд мэргэших боломж хомсоос гадна тухайн асуудал хариуцсан ажилтны мэргэжил, боловсролын зэрэг, ажлын туршлага хангалтгүйгээс мэргэжлийн, дадлага туршлага бүхий 18 орон тооны бус зөвлөхийг 5-12 сарын хугацаагаар 1.5-2.0 сая төгрөгийн цалинтайгаар ажиллуулж, нийт 113.6 сая төгрөгийн нэмэлт зардал гаргасан байна. Тухайлбал:

- олон улсын зах зээлд хувьцаа гаргах - 1 зөвлөх,
- ордын нөөцийг олон улсын стандартад шилжүүлэх - 1 зөвлөх,
- нийгмийн баталгааны хөтөлбөр – 1 зөвлөх,
- томоохон үнийн дүн бүхий гэрээ, хэлцлийн маргаанд компанийг хууль эрх зүйн үүднээс төлөөлөх - 1 зөвлөх,
- Гүйцэтгэх захирлын ярилцлага, илтгэл, үг шторкийг хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээнд байршуулах түгээх - 1 зөвлөх,
- усан хангамжийн төслийн ажлын даалгавар боловсруулах - 1 зөвлөх,
- эрчим хүчний нүүрсийг ашиглах чиглэлийг тодорхойлох - 1 зөвлөх,
- конвейрийн системийн тооцоолол хийж санал зөвлөмж боловсруулах - 4 зөвлөх,
- нүүрсний ил уурхайн болон гадаад овоолгын геотехник хажуугийн тогтворжилтын судалгаанд дүгнэлт гаргах зөвлөгөө өгөх - 4 зөвлөх,
- уурхайн гадаргуугийн ерөнхий төлөвлөгөөг өөрчлөх - 1 зөвлөх,
- ТЭЗҮ-ийн тодотголын үр ашигт тооцоолол хийх - 1 зөвлөх,
- хөдөлмөр хамгаалал, ажлын байрны нөхцөл сайжруулах - 1 зөвлөх,



2.2.18. Эрх зүйн үндэслэлгүй тушаалаар 2017-2018 онд ажлаас чөлөөлсөн нийт 8 ажилтан шүүхийн шийдвэрийн дагуу эргэн томилогдсон бөгөөд дээрх ажилтнуудад ажилгүй байсан хугацааны цалин, ЭМД, НДШ зэрэгт нийт 97.7 сая төгрөг байгууллагын цалингийн сангийн ажилгүйдлийн тэтгэмжийн сангаас олгож үргүй зардал гаргасныг буруутай албан тушаалтнаар төлүүлж компанийг хохиролгүй болгох нь зүйтэй байна.

ТУЗ-ийн гишүүдийн сонгон шалгаруулалт, цалин урамшууллын эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.

2.2.19. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.2⁴⁹, Компанийн тухай хуулийн 75.4⁵⁰-д заасны дагуу “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн ТУЗ-д ЗГХЭГ, СЯ, БОАЖЯ, УУХҮЯ, ЗТХЯ, “Эрдэнэс Монгол” ХХК-аас төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 6 гишүүн, хараат бус 3, нийт 9 гишүүн ажиллаж байсан бөгөөд Засгийн газрын 2018 оны 245 дугаар тогтоолоор эзэмшигч өөрчлөгдсөнтэй⁵¹ холбоотойгоор 10 дугаар сараас нийт 11 гишүүнтэй болж, гишүүдийн төлөөлөлд дараах өөрчлөлт орсон байна.

- БОАЖЯ, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн төлөөлөл хасагдаж, УУХҮЯ-ны төлөөлөл 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр, ТӨБЗГ-ын төлөөлөл, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн Гүйцэтгэх захирал ТУЗ-ийн гишүүнээр тус тус нэмэгдсэн,
- Хараат бус гишүүний тоо 4 болж нэмэгдсэн.

2.2.20. Гэхдээ төрийг төлөөлж ТУЗ-ийн гишүүн болох этгээдийг төрийн байгууллага хэрхэн дэвшүүлж гишүүн болгох ажиллагаа эрх зүйн хувьд тодорхой биш байна. Харин хараат бус гишүүдийг Компанийн тухай хуулийн 81.5.3 -т заасны дагуу нэр дэвшүүлэх хорооноос сонгон шалгаруулалтаар сонгох ёстой ч 2018 оны 9 дүгээр сарыг хүртэл ТУЗ-ийн хараат бус гишүүдийг хэрхэн томилсон нь тодорхойгүй хувьцаа эзэмшигч буюу толгой компани “Эрдэнэс монгол” ХХК-аас шууд томилж ирсэн байна. Тухайлбал

- “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас тус компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдээр Р.Батболд, Г.Даваажаргал, Б.Очбадрах нарыг томилсон боловч 11 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит бус хурлаас тэдгээр гишүүдийг өөрчлөн Э.Ганбаатар, П.Өлзийнаран, Х.Болор-Эрдэнэ нарыг томилсон.
- УИХ-ын 2018 оны “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 73 дугаар тогтоолоор тус компанийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн харьяанаас гарган бие даасан компани болгож, компанийн үйл ажиллагааны стратеги, дүрэм болон бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн боловсруулж, зохих журмын дагуу баталж мөрдүүлэхийг УУХҮС, ТӨБЗГ-ын дарга, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн ТУЗ-д даалгасны дагуу 2018 оны 10 дугаар сарын 19-ний хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн дүрэмд өөрчлөлт оруулж, ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуралд ТУЗ-ийн гишүүн, төрийн төлөөлөл байсан УУХҮЯ-ны хуулийн хэлтсийн дарга Н.Баярчимэг өөрийн хүсэлтээр гишүүнээс татгалзаж 52, хувьцаа эзэмшигч УУХҮС-ын тушаалаар баталсан удирдамжийн дагуу УУХҮЯ-ны ТЗУГ-ын дарга М.Баяраг ТУЗ-ийн даргад нэр дэвшүүлэн томилсон байна.

2.2.21. ТУЗ-ийн гишүүд нь ихэвчлэн улс төрийн томилгоогоор томилогдсон төрийн байгууллагуудын удирдах албан тушаалтнууд болон толгой компани, хувьцаа эзэмшигчийн саналаар томилогдсон гишүүд байх бөгөөд ямар шалгуураар хэрхэн томилогдсон нь тодорхойгүй, тогтвор суурьшилгүй байгаа нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компаний засаглалын кодекс”-д заасан “ТУЗ-ийн гишүүд нь боловсрол, мэргэжил, дадлага туршлагын тухайд компанийг зохистой удирдах шаардлагыг хангасан, салбарын өндөр

⁴⁹ 2/төрийн өмчийн оролцооны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн тухайн этгээдийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд төрийг төлөөлөх гишүүний нэрийг төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд тухайн компанийн нэр дэвшүүлэх хороонд санал болгох бөгөөд нэр дэвшүүлэх хороо тэрхүү нэр дэвшигдэж байгаа этгээд нь хуульд заасны дагуу төрийг төлөөлөх этгээд мөн бол ТУЗ-ийн гишүүнээр томилуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд оруулах үүрэгтэй.

⁵⁰ 75.4.Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн ТУЗ нь нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.

⁵¹ хувьцаа эзэмшигчийн эрхийг УУХҮЯ-нд 70 хувь, ТӨБЗГ-т 30 хувиар хэрэгжүүлэхийг даалгасан

⁵² 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн шинэ бүтцээр “Эрдэнэс таван толгой” ХК-ийн хэлтсийн дарга болсон байна



мэргэшсэн байх гэсэн компанийн засаглалын зарчимтай нийцэхгүй байхын зэрэгцээ улс төрийн нөлөөнөөс ангид байж чадахгүй байна

2.2.22. Компанийн тухай хуулийн 62.1.13⁵³, компанийн дүрмийн 8.4.7⁵⁴-д заасны дагуу толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн цалин урамшууллын хорооны 2015 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаас гаргасан зөвлөмжийн дагуу “Эрдэнэс таван толгой” ХК-ийн ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүдийн цалинг компанийн ахлах мэргэжилтний цалингийн жишгээр буюу 1,800.0 мянган төгрөг, бусад гишүүдийг мэргэжилтний цалингийн жишгээр буюу 1,300.0 мянган төгрөгөөр тогтоожээ.

2.2.23. Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7⁵⁵ дахь заалт, УИХ-ын 2016 оны 69 дүгээр тогтоолын дагуу⁵⁶ ТӨБЗГ *“төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын ТУЗ-ийн гишүүдийн цалингийн дээд хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэн буюу 480.0 мянган төгрөгөөс ихгүй байх”*-аар, мөн энэ нь хараат бус гишүүдэд адил үйлчлэхээр шинэчлэн тогтоосон байна.

2.2.24. Гэвч “Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцаа эзэмшигч, төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч толгой компани дээрх тогтоолыг хэрэгжүүлээгүй бөгөөд дээрх жишиг цалинтай харьцуулан үзвэл тус компанийн ТУЗ-ийн гишүүдийн цалин 2.7 дахин өндөр байгаагаас 2017-2018 онуудад 97.3-116.7 сая төгрөгийг хэмнэх боломжийг алдсан байна.

2.2.25. ТУЗ-ийн гишүүд хурлын ирцийг судалж үзэхэд дунджаар 78 хувьтай хурлын ирц бүрэн биш, компанийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх талаар зарим гишүүдийн идэвх санаачилга, үүрэг, оролцоо хангалтгүй байхад тогтмол цалин олгож, 2016-2018 онуудад 108 сая төгрөгийн үргүй зардал гаргасан тул дээрх зөрчлүүдийг арилгах албан шаардлага өгөхөөр тогтов.

Компанийн 2014-2017 оны дунд хугацааны бизнес төлөвлөгөөний биелэлт хангалтгүй, 34 хувьтай байна

2.2.26. ТУЗ-ийн 2014 оны 14 дүгээр тогтоолоор “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2014-2017 оны дунд хугацааны бизнес төлөвлөгөө батлагдсан байна.

2.2.27. Уг төлөвлөгөөнд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор салбарын тэргүүлэх чиглэлүүдээ тодорхойлон дараах голлох зорилтуудыг дэвшүүлсэн байна. */дэлгэрэнгүй хавсралт 16-д харуулав/*

⁵³ 62.1.13. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

⁵⁴ ТӨХ-ны 2010 оны 425 дугаар тогтоолоор баталсан компанийн дүрмийн 8. Хувь нийлүүлэгчдийн хурлын эрх: 8.4.7 ТУЗ-ийн гишүүдийг томилох, чөлөөлөх, цалин урамшууллын хэмжээг тогтоох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох

⁵⁵ 3.7. Энэ журмын 3.6-д заасан цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна.

⁵⁶ УИХ-ын 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр баталсан “Монгол улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 69 дүгээр тогтоолд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын менежментийг сайжруулах чиглэлээр ТУЗ-ийн гишүүд, удирдлагын цалин урамшууллыг оновчтой тогтоох” арга хэмжээ авч хэрэгжүүлэн 2017 оны 1 дүгээр сарын 01-нээс эхлэн мөрдөж ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.



Хүснэгт 20 “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2014-2017 оны бизнес төлөвлөгөөний тэргүүлэх чиглэл, голлох зорилтууд

Тэргүүлэх чиглэл	Голох зорилт
Олборлолтыг тасралтгүй байдлыг хангах	2014 оны олборлолтыг 7,8 сая тн хүргэх 2015-2017 оны олборлолтыг 16,5 сая тн хүргэх
Уурхайн ордын хөгжил	2014 оны II улиралд Цанхийн зүүн, баруун уурхайг нэгтгэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх 2016 оноос 0 давхаргыг олборлож эхэлнэ - Цанхийн ордод олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу судалгаа, ашиглалтын хайгуулын ажлыг хийж нөөцийг нэмэгдүүлнэ
Дэд бүтцийн хөгжил	2015 онд ус хангамжийг шийдэх 2016 онд 20 сая тн/жил хүчин чадалтай баяжуулах үйлдвэр байгуулах 2017 онд Таван толгой Гашуунсухайт чиглэлийн төмөр замтай болох - Өндөр хүчин чадлын дамжуулах байгууламжийг барьж төвийн эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбох - Нүүрсний тээвэр ложистикийн оновчтой дэд бүтцийг бий болгож тээврийн зардлыг 2 дахин бууруулна
Борлуулалт маркетинг	2014-2017 онд БНХАУ-ын нүүрсний импортын 30 хувийг нийлүүлэх “ТТ” брэндийн нүүрсийг олон улсын зах зээлд таниулна - Нүүрсний шинжилгээний итгэмжлэгдсэн лабораторийг өөрийн уурхайд байгуулах - Бусад ашигт малтмалын нөөцийг ашиглах
Санхүү хөрөнгө оруулалт	2014 онд багтаан БНХАУ-ын “Chalco trading Hongkong Co.ltd” компанийн урьдчилгаа төлбөр болон зээлийг нүүрсээр бүрэн барагдуулна 2015-2016 онд олон улсын болон дотоодын хөрөнгийн зах зээлд хувьцаагаа гаргаж санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлж, үр ашигтай төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх - Компанийн ашигт ажиллагааг 2017 он гэхэд 37 хувьд хүргэх 2015 онд стратегийн хөрөнгө оруулагч сонгох
Компанийн засаглал, хүний нөөцийн удирдлага	- Олон Улсын сайн засаглалын тэргүүн туршлагыг нэвтрүүлнэ - Компанийн нийгмийн хариуцлагыг төсөл хөтөлбөрүүдийг боловсруулна - Хүний нөөцийн оновчтой бодлогыг боловсруулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, Ажилтнуудыг мэргэжлийн байнгын давтан сургалтад хамруулна

Эх сурвалж: “Эрдэнэс таван толгой” ХК

2.2.28. Ийнхүү дээрх зорилтуудыг хэрэгжүүлснээр 2017 он хүртэлх хугацаанд улсын төсөвт төвлөрүүлэх татварын хэмжээ 216.0 сая ам.доллар, нүүрсний экспортын хэмжээг 14.3 сая тонн, цэвэр ашгийн хэмжээг 510.0 сая ам.долларт хүргэнэ гэж Монгол улсын эдийн засагт үзүүлэх хувь хэмжээ хүрэх үр дүнгээ тодорхойлсон байна.

2.2.29. Бизнес төлөвлөгөөний зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд зорилтот түвшин, хүрэх үр дүнгээ тодорхойлон ТУЗ-ийн хурлаар төлөвлөгөөгөө батлуулсан ч төлөвлөлтийн үндэслэл, тооцоо судалгаа хангалтгүй, нүүрсний зах зээлийн үнийн уналт, улс төрийн шийдвэр зэргээс хэрэгжилт нь хангалтгүй байсан нь Эрдэнэс таван толгой ХК-ийн гүйцэтгэх захирлын 2016 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А193 тоот тушаалаар байгуулагдсан “Бизнес төлөвлөгөө дүгнэх, дараагийн бизнес төлөвлөгөөг боловсруулах” ажлын хэсгийн 34 хувьтай гэж дүгнэсэн дүгнэлтээр давхар нотлогдож байна.

2.2.30. Мөн дээрх ажлын хэсэг 2017-2020 он хүртэлх дунд хугацааны бизнес төлөвлөгөөг боловсруулан ТУЗ-ийн 2017 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 13 дугаар тогтоолоор батлуулсан бөгөөд өмнөх бизнес төлөвлөгөөний гол зорилго, зорилтуудын ач холбогдол буураагүйгээс олборлолтын хэмжээ, экспортын хэмжээ зэргийг нэмэгдүүлэн үйлдвэрлэлээ хөгжүүлэх бодлого барьж байгаа ч зарим зорилтын хүчин чадлыг нь бууруулан хэрэгжүүлэх хэлбэрийг өөрчлөн төлөвлөсөн байна. Тухайлбал,

- Баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг 5 сая болгон бууруулж, үйлдвэрийн барилгыг бэлтгэл ажлыг 2018 оноос эхлэн барилга угсралтын ажлыг 2019 оноос эхэлж 2022 оноос нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн экспортлох,
- 2018 онд IPO гаргах ажлын бэлтгэл ажлыг эхлүүлж, 2020 оноос гаргах,
- Зорилтот зах зээлийн эзлэх хувийг 15 хувь болгон бууруулж, экспортолж буй ижил төрлийн бүтээгдэхүүнийг нийлүүлэх,
- Орон нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих хөтөлбөрийг боловсруулан тэдгээрээс зөвшөөрөл авч шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлэх,
- Тавантолгойн бүлэг орд дээр үйл ажиллагаа явуулж буй бусад компаниудтай эд бүтэц, борлуулалт, аюулгүй ажиллагаа орон нутгийн хөгжил зэрэг үндсэн болон бусад үйл ажиллагаанд хамтран ажиллах,



- Хилийн нэвтрэх чадварыг нэмэгдүүлэх,
- Оффисын болон ажилчдын шинэ орон сууц барьж хүний нөөцийн хариуцлагын хөтөлбөрт хүүгүй зээлийн сан үүсгэн нийгмийн хариуцлагаа сайжруулах гэх мэт арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд эдгээрийн хэрэгжилт хараахан гарах болоогүй байна.

Тухайн үеийн засгийн газар, “Эрдэнэс монгол” ХХК-ийн бодлого, чиглэл, мэргэжил арга зүйн удирдлага хангалтгүйгээс хөгжлийн төслүүд хэрэгжээгүй байна

Шаардлагатай усны эх үүсвэр бүрэн шийдвэрлэгдээгүй байна

2.2.31. Цанхийн хэсгийн ТЭЗҮ-д 40.0 мянган м³ хүчин чадалтай шахуургын станц, 70 км урт ус дамжуулах хоолой бүхий усан хангамжийн системтэй байхаар тусгасан байна.

2.2.32. УАБЗ-ийн 2010 оны 34/28 дугаар зөвлөмж⁵⁷-ийн дагуу Өмнөговь аймгийн ИТХ-ын 2010 оны 7/8 дугаар тогтоолоор Балгасын улаан нуурын цэнгэг усны ордыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан ч Засгийн газрын 2011 оны 257 дугаар тогтоолд Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нут аг дахь Балгасын улаан нуурын хотгорын газрын доорх усны ордоос 151 л/с усны нөөцийг “Эрдэнэс таван толгой” ХК-д ашиглуулах арга хэмжээ авахыг БОАЖЯ, Усны газар, Өмнөговь аймгийн Засаг дарга нарт даалгасан байна.

2.2.33. “Эрдэнэс таван толгой” ХК Усны тухай хуулийн /2004 он/ 16 дугаар зүйлийн 16.1.8⁵⁸ дугаар заалт, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2011 оны 4/907 дугаар дүгнэлт⁵⁹-ийг үндэслэн Өмнөговь аймгийн Ханхонгор сумын засаг даргатай ус ашиглах эрхийг баталгаажуулж, гэрээ байгуулах хүсэлтийг 2012 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 01/190 дугаар албан бичгээр, Балгасын улаан нуур орчмын газрыг орон нутгийн тусгай хамгаалалтаас гаргах тухай хүсэлтийг Өмнөговь аймгийн ИТХ-д 2012 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 02/207 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн байна.

2.2.34. Гэвч Өмнөговь аймгийн ИТХ орон нутгийн иргэдийн хүсэлт шаардлага, орон нутгийн бодлогын хүрээнд⁶⁰ орон нутгийн тусгай хамгаалалтаас чөлөөлөх хүсэлтийг хүлээн авах боломжгүй талаар мэдэгдсэн тул “Эрдэнэс таван толгой” ХК ТЭЗҮ-д тусгагдсан усны эх үүсвэрийг ашиглах боломжгүй болж, усан хангамжийн системийн ТЭЗҮ-д зарцуулсан 175.7 сая төгрөг⁶¹ үргүй зардал болжээ.

2.2.35. Засгийн газрын захиалга, Дэлхийн банкны санхүүжилтээр “Эко ватер” ХХК Таван толгой нүүрсний орд газрын технологийн усан хангамжийн зориулалтаар явуулах газрын доорх усны эрэл, хайгуул судалгааны ажлыг 2015-2016 онд гүйцэтгэн, тайланг БОАЖЯ-ны Усны нөөцийн зөвлөлөөр хэлэлцүүлж, усны ашиглалтын нөөцийг үйлдвэрлэлийн “С” зэргээр нийт 63.6 л/с буюу 5,499.3м³ хоногоор батлуулсан байна.

2.2.36. Үүний дагуу Усны тухай хуулийн /2012 он/ 29 дүгээр зүйлийн 29.1⁶² дэх заалт, “Монгол ус” ТӨҮГ-ын 2017 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 144 дүгээр дүгнэлтийг

⁵⁷ УАБЗ-ийн 2010 оны 34/28 дугаар зөвлөмж “Балгасын улаан нуур, Бор хөөвөрийн говь, Баян тоорой, Эхийн гол, Шавдал овоо, Зайрмагтай зэрэг газрын доорх цэнгэг усны томоохон ордуудыг тусгай хамгаалалтад авах талаар саналыг ойрын үед боловсруулж УИХ-д өргөн мэдүүлж шийдвэрлүүлэх”

⁵⁸ Усны тухай хууль /2014 он/-ийн 16.1.8 16.1.8.усны асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллага, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, байгаль хамгаалагчийн дүгнэлтийг үндэслэн ус ашиглуулах шийдвэр гаргах.

⁵⁹ Усны газрын 2011 оны 4/907 дугаар дүгнэлт “Тавантолгойн нүүрсний уурхайд хоногт 150,8 л/с ус ашиглуулах боломжтой”

⁶⁰ Өмнөговь аймгийг 2013-2016 он хүртэл хөгжүүлэх аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт “усны зохистой удирдлагыг бий болгон Зөвлөл байгуулж гүний ус түүний ай савыг хамгаалах, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж буй усны хяналтын тогтолцоог сайжруулах, цаашид уул уурхайн үйлдвэрлэлд гүний ус ашиглах технологиос татгалзах” бодлогын арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгагдсан

⁶¹ “Эрдэнэс таван толгой” ХК нь 2012 онд “Энержи ресурс” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу “Монхидро” ХХК-ийн боловсруулсан усан хангамжийн системийн ТЭЗҮ-г 174.2 сая төгрөгөөр худалдан авч, “Евро хан” ХХК, “Престиж инжиниринг” ХХК-иудаар ТЭЗҮ-ийн шинэчлэлтийг 1.5 сая төгрөгөөр гүйцэтгүүлэн, Барилгын хөгжлийн төвийн 2013 оны 1259/2013 дугаар дүгнэлтээр батлуулжээ.

⁶² Усны тухай хууль /2012 он/ 29.1.Энэ хуулийн 28.6, 28.7-д заасан зөвшөөрлийг үндэслэн хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай тухайн ус хангагч байгууллага, төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс



үндэслэн БОАЖЯ-ны Галба-өөш Долоодын говийн сав газрын захиргааны даргын 2018 оны А/05 дугаар тушаалаар “Эрдэнэс таван толгой” ХК-д Загийн усны хоолойн газрын доорх усны ашиглаж болох боломжит нөөцийг 63.65 л/с хэтрэхгүйгээр ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар 1 жилийн хугацаатайгаар ашиглахыг зөвшөөрчээ.

2.2.37. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2018 оны төсөвт ус хангамжийн системийн ТЭЗҮ боловсруулахад 387.0 сая төгрөг батлагдсаны дагуу Загийн усны хоолойн газрын доорх усны ордоос ус нийлүүлэх, ус хангамжийн системийн ТЭЗҮ боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендер зарласан байна.

Нүүрс угаах, баяжуулах үйлдвэрийн төсөл хэрэгжээгүй, ТЭЗҮ-г шинэчлэх тендер зарлагдаад байна

2.2.38. “Эрдэнэс таван толгой” ХК нь 2012 онд зохион байгуулсан тендер шалгаруулалтаар шалгарсан “Аусэнко таггарт монголиа” ХХК-тай нүүрс баяжуулах /угаах/ үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах 1,088.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий гэрээ, АНУ-ын Норвест корпорацийтай ТЭЗҮ-ийн цахилгаан, барилга, механик ба баяжуулалтын загвар, тоног төхөөрөмжийн шийдэл, үнийн тооцоо үндэслэлүүдийг шалган дүгнэлт гаргах 36.0 мянган ам.долларын гэрээг байгуулжээ.

2.2.39. Гэрээний дагуу “Аусэнко таггарт монголиа” ХХК-ийн боловсруулсан жилд 20.0 сая тонн нүүрс угаах хүчин чадал бүхий баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2013 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн СТР-02/13 дугаар дүгнэлтээр хүлээн авсан боловч баяжуулах үйлдвэр баригдаж эхлээгүй байна.

2.2.40. Нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-д тусгагдсан усны эх үүсвэрийг ашиглах боломжгүй болсон, нүүрсний зах зээл уналтад орсон зэргээс шалтгаалан баяжуулах үйлдвэрийн төсөл зогсонги байдалтай байсан бөгөөд 2018 онд Загийн усны хоолойн газрын доорх усны ордыг ашиглах нөөцийн хэмжээтэй уялдуулан баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-д тодотгол, шинэчлэл хийхээр “ТЭЗҮ-нд тодотгол, шинэчлэл хийх, урьдчилсан зураг төсөл болон ЕРС гэрээний нөхцөлтэй гүйцэтгэгч сонгох” ажилд 382.0 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээний тендер зарлаад байна.

Хуурай аргаар нүүрс баяжуулах туршилтын үйлдвэрийн төсөл хэрэгжээгүй байна

2.2.41. “Эрдэнэс таван толгой” ХК хуурай аргаар нүүрс баяжуулах технологи нэвтрүүлэх, нутагшуулах зорилгоор Япон улсын “Японы нүүрс, эрчим хүчний төв” /JCOAL,NEDO/, “Нагата инженеринг” компанитай хамтран ажиллахаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Үүнд:

- “Хуурай аргаар нүүрс баяжуулах технологийн салбарт хамтран ажиллах тухай” санамж бичгийг Япон улсын “Японы нүүрс, эрчим хүчний төв” /JCOAL,NEDO/, “Нагата инженеринг” компанитай 2013 оны 8 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан;
- Цанхийн хэсгийн ордын IV, 0 давхаргын нүүрсний дээжид усны оронд элс ашиглан баяжуулах туршилт хийсний үндсэн дээр 0, III, IV давхаргуудын нүүрсний 0.5 мм-с том ширхэглэлтэй хэсгийг уг технологиор баяжуулах боломжтой гэсэн дүгнэлт гаргасан;
- Япон улсын тал туршилтын үйлдвэрийн хөрөнгө оруулалтын 70 хувь буюу 1.3 тэрбум иенийг санхүүжүүлэх, Монголын тал үлдэх санхүүжилт болон үйлдвэрийн үйл ажиллагаанд шаардлагатай 300.0 мянган тонн нүүрс нийлүүлэх, туршилтын үйлдвэр 1 жилийн дараа Монголын талд шилжих нөхцөлтэй гүйцэтгэлийн гэрээний төслийг боловсруулсан байна.

2.2.42. Гэвч “Эрдэнэс таван толгой” ХК-ийн удирдлага уг төслийг толгой компани хариуцан хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэн шилжүүлсэн тул “Эрдэнэс Монгол” ХХК ба “Нагата инженеринг” компани 2016 оны 2 дугаар сарын 16-ны өдөр төслийг хэрэгжүүлэх



гүйцэтгэлийн гэрээ байгуулсан ч төслийг үргэлжлүүлэх боломжгүй болсон тухайгаа УУХҮЯ-нд 2017 оны 4 дүгээр сард мэдэгджээ. Үүнд:

- “Эрдэнэс Монгол” ХХК Монголын талын хөрөнгө оруулалтыг гаргах боломжгүй тул хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллахаар сонгон шалгаруулалт явуулсан хэдий ч шалгарсан компаниуд баяжуулах нүүрсийг “Эрдэнэс таван толгой” ХК-аас худалдан авч баяжуулах нь эдийн засгийн үр ашиггүй тул хөрөнгө оруулахаас татгалзсан гэжээ.

2.2.43. УУХҮЯ Япон улсын “Шинэ эрчим хүчний хөгжлийн төв” /NEDO/-тэй 2017 оны 6 дугаар сарын 20-нд “Хуурай аргаар нүүрс баяжуулах технологийн салбарт хамтран ажиллах тухай” санамж бичгийг шинэчлэн байгуулж, монголын талын аж ахуйн нэгжээр “Энержи ресурс” ХХК-ийг сонгосон боловч туршилтын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн өмчлөлийн асуудлаар Япон улсын талтай шийдэлд хүрээгүйгээс⁶³ УУХҮЯ, “Эрдэнэс таван толгой” ХК-тай хамтран хэрэгжүүлэхээр болоод байна.

“Эрдэнэс таван толгой” ХК нүүрсний давхаргын метан хийн төслийг хариуцан хэрэгжүүлэх нь үр ашигтай байхаар байна

2.2.44. “Эрдэнэс таван толгой” ХК БНСУ-ын “КОГАЗ” компанитай хамтран 2013 оны 8 сараас хайгуулын өрөмдлөг, ашиглалтын хайгуулын явцад метан хийн судалгааг хийн “Метан хийн нөөц тогтоох, хийг савлах, цэвэрлэх, боловсруулах технологи нэвтрүүлэх, метан хийн хадгалалт болон тээвэрлэлтийн судалгаа хийх, метан хийн туршилтын үйлдвэр барих” санамж бичгийн хүрээнд ордын Бортээгийн хэсэгт туршилтын үйлдвэрийг байгуулж, Газрын тосны газартай 2014 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр “Хийн эрлийн ажлын гэрээ”-г байгуулжээ⁶⁴.

Зураг 1 Метан хий боловсруулах туршилтын үйлдвэр



2.2.45. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Т.Билгээ-н 2015 оны 01/1641 дүгээр албан бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2015 оны А/129 дүгээр тушаалаар уг төслийг шилжүүлэх ажлын хэсэг байгуулж, 2016 оны 2 дугаар сарын 25-ны өдөр байгуулагдсан охин компани болох “Эрдэнэс метан” ХХК хариуцан хэрэгжүүлэхээр болжээ.

2.2.46. “Эрдэнэс метан” ХХК нь Ашигт малтмал, газрын тосны газартай “Хийн эрэл, хайгуулын гэрээ”-г шинэчлэн байгуулсан боловч эрэл, хайгуулын ажил гүйцэтгэхэд урьдчилсан тооцоогоор нийт 37.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай тул төсөл зогсонги байдалд ороод байна.

⁶³ Туршилтын хугацаа дуусахад төслийн тоног төхөөрөмжийг Монгол улсын төрийн өмчид шилжүүлэх нөхцөлтэй, Япон улсын талаас Монгол улсын төрийн бус компанид шилжүүлэх боломжгүй тул “Энержи ресурс” ХХК-тай гүйцэтгэлийн гэрээ байгуулаагүй.

⁶⁴ Газрын тосны тухай хууль /2014 он/-д нүүрсний давхаргын метан нь уламжлалт бус газрын тосны ангилалд хамрагддаг бөгөөд эрлийн ажлыг төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгэх, бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах замаар ашиглах зохицуулалттай байна.



2.2.47. “Эрдэнэс таван толгой” ХК нь нүүрсний ашиглалт, нарийвчилсан хайгуулын хүрээнд зөвхөн 2017 онд нийт 63.0 мянган уртааш метр өрөмдлөг, геофизикийн ажилд 8.0 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд холбогдох зөвшөөрөл, эрэл хайгуулын гэрээг шинэчлэн байгуулах замаар нүүрсний давхаргын метаны төслийг хариуцан хэрэгжүүлэх нь эдийн засгийн хувьд үр ашигтай⁶⁵ байхаар байна.

Эрчим хүчний төсөлд зарцуулсан 1.4 тэрбум төгрөг үргүй зардал болжээ

2.2.48. Засгийн газрын 2011 оны “Өмнийн говийн бүтээн байгуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 257 дугаар тогтоолын 1.1-д *“Таван толгойн орд газрыг түшиглэн барих цахилгаан станцын ТЭЗҮ, холбогдох судалгааг 2011 онд дуусгаж, тодорхой хугацааны дараа төрийн өмчид шилжүүлэх нөхцөлтэйгээр барих ажлыг 2012 оны II улиралд багтаан эхлүүлэх”*-ийг “Эрдэнэс таван толгой” ХК-д хариуцуулан зохион байгуулахыг ТӨХ /хуучин нэрээр/-нд даалгасаны дагуу “Энержи ресурс” ХХК-аас 300 Мвт хүчин чадал бүхий цахилгаан станцын ТЭЗҮ⁶⁶-г 2012 онд 615.7 сая төгрөгөөр тендер шалгаруулалтгүйгээр шууд худалдан авсан байна.

2.2.49. Гэвч дээрх ТЭЗҮ-г шинэчлэн боловсруулахтай холбогдуулан 2012 онд “Эрдэнэс таван толгой” ХК “Parsons Brinckerhoff Asia Ltd” компанитай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан нийт 352.0 мянган ам.доллар, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, инженерийн геологийн судалгаа, цахилгаан станцын тогтворжилтын тооцоо, техникийн нөхцөл, орчуулга, томилолт, цалингийн зардал зэрэгт 195.7 сая төгрөг, нийт 1,452.9 сая төгрөгийн зардал гаргажээ.

2.2.50. “Эрдэнэс таван толгой” ХК Цанхи хотхоны /уурхайн кэмп/ орчимд цахилгаан станц барихаар төлөвлөн ТЭЗҮ-д шаардлагатай өөрчлөлтийг тусган шинэчлэн боловсруулж, ЭБЭХЯ-ны /хуучин нэрээр/ Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр 2012 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр хэлэлцүүлэн дэмжүүлсэн байна.

2.2.51. Гэвч Засгийн газрын 2013 оны 80 дугаар тогтоолоор Засгийн газрын 2011 оны 257 дугаар тогтоолын 1.1 дэх хэсгийг хүчингүй болгон, *“Монгол Улсын төвийн бүсийн болон өмнийн говийн стратегийн орд газруудын эрчим хүчний хэрэгцээг хангах зорилгоор Таван толгойн нүүрсний орд газрыг түшиглэн 450 МВт хүчин чадалтай цахилгаан станц барих ..”*-ийг ЭЗХЯ, ЭХЯ, МУХБ-нд үүрэг болгосон байна.

2.2.52. Цахилгаан станцын хүчин чадал, санхүүжилтийн хэлбэр өөрчлөгдсөн тул ЭХЯ-ны дэргэд байгуулагдсан “Таван толгойн цахилгаан станц төслийн нэгж” Таван толгойн ордын Ухаа худаг хэсэгт цахилгаан станцыг байгуулахаар шийдвэрлэснээс “Эрдэнэс таван толгой” ХК-ийн ТЭЗҮ ашиглагдах боломжгүй болж, уг төсөлд зарцуулсан 1,452.9 сая төгрөг үргүй зардал болсон байна.

Компанийн үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн дотоод хяналт үр нөлөөгүй байна

2.2.53. Компанийн тухай хуулийн 81.4⁶⁷, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.2⁶⁸ -т заасны дагуу “Эрдэнэс таван толгой” ХК-ийн гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд дотоод хяналтыг ТУЗ-ийн Аудитын хорооны дотоод аудитор

⁶⁵ Нүүрсний давхаргын метаны илрэл бүхий хэсэгт хайгуулын цооногийг өрөмдлөх үед метаныг битүүмжлэн авах боломжтой технологиор метаны дээжийг шинжилсэний дараа нүүрсий дээжийг шинжлэх замаар хайгуулын ажлыг гүйцэтгэх боломжтой.

⁶⁶ Parsons Brinckerhoff Asia Ltd компанийн боловсруулсан Ухаа худагийн уурхайг түшиглэсэн 300МВт хүчин чадал бүхий цахилгаан станцын ТЭЗҮ

⁶⁷ ТУЗ-ийн Аудитын хороо нь компанийн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох, аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах үүрэгтэй

⁶⁸ Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад шууд захирагдах бөгөөд зохион байгуулалтын хувьд бусад бүтэц, нэгжээс хараат бус байна



болон байгууллагын дотоод хяналтын нэгж хэрэгжүүлж байгаа ч бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт, боловсон хүчний тогтворгүй байдал зэргээс хэрэгжүүлсэн ажил хангалтгүй, хяналт шалгалт нь үр нөлөөгүй байна.

2.2.54. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн ТУЗ-ийн ажлын албанд 2018 оны 7 дугаар сараас дотоод аудиторын 1 орон тоог бий болгосон ч ажлын байрны тодорхойлолт, аудит хяналт шалгалт хийх чиг үүрэг тодорхойгүйгээс тухайн мэргэжилтэн нь тухайн оны 10 дугаар сарын бүтцийн өөрчлөлт хүртэл 3 сарын хугацаанд тодорхой хийх ажлын төлөвлөгөө батлуулаагүй, хяналт, шалгалт хийгээгүй сар бүр 2.3 сая төгрөгөөр сул цалинжсан байна.

2.2.55. Тус компанийн Дотоод хяналтын нэгж нь 2016 оны 3 дугаар сар хүртэл 4 хүнтэй байсан бол бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн дагуу 2 орон тоотой ажиллах болсон ч мөн оны 6 дугаар сараас 11 дүгээр сар хүртэл туршилтын хугацаагаар 4 ажилтныг шинээр ажиллуулсан бүрэлдэхүүн, бүтцийн хувьд тогтвортой бус, дотоод хяналтын чиглэлээр тодорхой зорилт, стратеги дэвшүүлж ажиллаагүй, үндсэн чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй явж ирсэн байна⁶⁹.

2.2.56. 2016 оны 11 сараас 3 мэргэжилтний орон тоотойгоор ажиллаж, тэдгээр мэргэжилтнүүд нь 2017-2018 онд хийх хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг гүйцэтгэх захирлаар батлуулан, 11 нэгжийн чиг үүрэг, хууль журмын биелэлт, цаг ашиглалт, илүү цагийн үндэслэл тооцоо болон цалингийн тооцоолол, худалдан авах ажиллагаа зэрэгт хяналт шалгалт хийж нэгжийн бүтэц зохион байгуулалт оновчгүй, ижил төстэй компанитай харьцуулахад төв оффис хэт төвлөрсөн, зарим албан тушаалтнуудын ажил үүргүүд давхацсан, ажлын ачаалал нь тэнцвэргүй, ажилтнуудын мэргэжил мэдлэг дутмаг, худалдан авах ажиллагаанд хууль дүрмийн мөрдөлт хангалтгүй, ажилтнуудын ажлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй, компанийн хөрөнгийн ашиглалт хадгалалт хамгаалалт хангалтгүй, цалингийн тооцооллыг илүү дутуу боддог зэрэг зөрчил дутагдлыг илрүүлсэн.

2.2.57. Дээрх зөрчлүүдийг гүйцэтгэх удирдлага, холбогдох нэгжийн удирдлагад танилцуулан хөрөнгө ашиглалт, худалдан авах ажиллагаатай холбоотой зарим асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, цаашид компанийн хувьд гарч болох эрсдэлийг тодорхойлон түүнийг бууруулах талаар зөвлөмжийг өгсөн боловч компанийн удирдлага дотоод хяналтын нэгжийн зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй, дотоод хяналтын нэгж хэрэгжилтийг эргэж хянаагүй байна.

2.2.58. Компанийн 2018 оны 10 сарын 26-ны шинэчилсэн бүтцээр дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, компанийн эрсдэлийн удирдлагыг сайжруулах үүднээс ТУЗ-ийн дэргэд Ерөнхий аудитор, аудитын албыг 3 орон тоотойгоор, дотоод хяналт эрсдэлийн удирдлагын гарыг менежер, 2 ахлах, 2 мэргэжилтэн гэсэн 5 орон тоотойгоор шинээр бий болгосон байна.

2.2.59. Мөн “Эрдэнэс Монгол” ХХК-аас 2016 онд компанийн үйл ажиллагаа, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж тодорхой зөрчлүүдийг гаргаж, тушаал шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг сайжруулах талаар зөвлөмжүүд хүргүүлсэн боловч зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна. Илэрсэн зөрчлөөс дурдвал:

⁶⁹ Тухайлбал, Компанийн дотоод хянан шалгагч Ц.Саруул нь 2016 оны 6-9 сарын хугацаанд /сарын 4.1 сая төгрөгийн цалинтай/, мэргэжилтэн Л.Мөнхтүвшин 6-7 сарын хугацаанд /сарын 1.5 сая төгрөгийн цалинтай/ ажилласан ч хяналт шалгалтын чиглэлээр хийсэн тодорхой ажилгүй байсан атлаа бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр Захиргаа, удирдлагын газрын дарга ахлах мэргэжилтнээр томилогдсон, Дотоод хянан шалгагч Г.Дэлгэрбаяр нь 2016 оны 9-11 сарын хооронд ажилласан ч /сарын 3.8 сая төгрөгийн цалинтай/ мөн л ажлын үр дүн тодорхойгүй байхад уурхайд ерөнхий геологичоор томилон ажиллуулсан ч сахилгын шийтгэлийн улмаас халагдсан ч 2018 оны 10 дугаар сард шинэ бүтцээр үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирлаар томилогдон ажиллаж байна. Б.Цэрэндолгор 2016 оны 9-11 дүгээр сар хүртэл /сарын 1.1 сая төгрөгийн цалинтай/ дотоод хяналт шалгалтын мэргэжилтнээр ажилласан бөгөөд хяналт шалгалтын ажлын тавигдах шаардлага хангаагүйн улмаас ажлаас халагдсан атлаа уурхайд Захиргаа, хүний нөөцийн мэргэжилтнээр, 2018 оноос архивын мэргэжилтнээр ажиллаж байна



- шинээр орсон ажилтнуудын хөдөлмөрийн гэрээг үндэслэн гүйцэтгэх захирал тушаал гаргаж байгаа,
- худалдан авах ажиллагааны төлөвлөлт үндэслэл муутай, хэрэгжилт хангалтгүй,
- хэрэгцээгүй бараа материал авдаг, бараа материалын үлдэгдэл ихтэй,
- үндсэн хөрөнгийн бүртгэлд ашиглалтгүй удаан хадгалагдсан үхмэл хөрөнгийн үлдэгдэл ихтэй, хадгалалт хамгаалалт хангалтгүй, өглөг өссөн,
- гүйцэтгэх захирал Д.Ариунболд нь ТУЗ-ийн шийдвэргүйгээр 5 удаа гадаад албан томилолтоор явахдаа томилолтын тайлан хавсаргаагүй, баримтын бүрдэл дутуу, “Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын 3.5⁷⁰ дах заалтыг зөрчин бизнес ангиллаар явсан, томилолтын хугацаа хэтэрсэн, томилолтын чиглэл үндсэн зорилгод хамааралгүй газар буудалласан зэрэг үр ашиггүй зарцуулалт хийсэн гэжээ

⁷⁰ гадаад албан томилолтын зардлыг бууруулах, зайлшгүй тохиолдолд зорчих төлөөлөгчийн тоог цөөлөх, төсвийн хөрөнгөөр бизнес ангиллын нислэгээр зорчихгүй байх



БОРЛУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ИХ ХЭМЖЭЭНИЙ ОРЛОГО ОЛОХ БОЛОМЖИЙГ АЛДСАН, ХУВЬЦААНЫ НЭРЛЭСЭН ҮНИЙН ТООЦООЛОЛ ҮНДЭСЛЭЛТЭЙ ЭСЭХИЙГ НОТЛОХ БОЛОМЖГҮЙ БАЙНА

Цанхийн баруун, зүүн хэсгийн үнэ харилцан адилгүй, худалдааны нөхцөлийг өөрчлөх замаар өртөг шингээх, борлуулалтын үнийг өсгөх боломжтой байна

2.3.1. БНХАУ-д жилд 1 сая тн-с дээш ган үйлдвэрлэдэг 84 үйлдвэр байдгаас 30 гаруй нь тус улсын хойд хэсэгт Шаньси, Хэбэй, Шаньдун муж, ӨМӨЗО-нд байдаг бөгөөд Монгол Улсаас экспортолж буй нүүрсний худалдан авагч нь нүүрс угаах, баяжуулах үйлдвэр болон дундын зуучлагч компаниуд, нүүрсний эцсийн хэрэглэгчид нь дээрх мужуудын металлурги гангийн болон нүүрс, химийн үйлдвэрүүд байдаг байна.

2.3.2. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн Таван толгойн нүүрсний ордын Цанхийн хэсгийн III, IV давхаргаас олборлон экспортолж буй нүүрс MNS6457:2014 ⁷¹ стандартын боловсруулаагүй коксжих чулуун нүүрс, исэлдсэн нүүрсийг эрчим хүчний нүүрс гэсэн ангилалд хамруулан экспортолж байна.

2.3.3. “Эрдэнэс таван толгой” ХК экспортлох коксжих нүүрсний хувьд барьцалдах чанар /G index/, дэгдэмхий бодисын гарц, үнслэг, хүхэр, нийт чийг, илчлэг гэсэн чанарын үндсэн үзүүлэлт, исэлдсэн нүүрсний хувьд илчлэг, дэгдэмхий бодисын гарц, үнслэг, хүхэр, нийт чийг гэсэн чанарын үндсэн үзүүлэлтийг харгалзан борлуулалтын үнийг тооцоолж байна.


2.3.4. “Эрдэнэс таван толгой” ХК-д экспортолж буй нүүрсний худалдан авагч, эцсийн хэрэглэгчдийн талаар иж бүрэн, дэлгэрэнгүй судалгаа өнөөдрийг хүртэл хийгдээгүй, маркетинг хариуцсан нэгж нь олон улсын нүүрсний зах зээлийн хандлага, нүүрсний үнэ, агуулахын үлдэгдлийн талаарх мэдээллийг <http://en.sxcoal.com>, <http://platts.com>, <http://metalbulletin.com> зэрэг сайтуудаас авдаг бөгөөд аудитаар БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ганцмод боомтын нүүрсний үнийг <http://en.sxcoal.com> сайтын мэдээллийг зах зээлийн жишиг үнэ болгон тооцлоо.

2.3.5. БНХАУ-ын нүүрсний зах зээлийн үнэ 2012 оны III улиралд 122.4 ам.доллар/тн байсан бол үнийн уналт 2016 оны II улирлын дунд үе хүртэл үргэлжилж 50.0 ам.доллар/тн хүрсэн, 2016 оны II улирлаас огцом сэргэж 2017 оны IV улирлын байдлаар 141.8-156.7 ам.доллар/тн болсон байна.

⁷¹ MNS 6457: 2014 Нүүрсний ордуудыг ашиглах, нүүрсийг худалдах, борлуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд баримтлах стандарт /антрацит, чулуун нүүрс, хүрэн нүүрс гэсэн үндсэн 3 төрөл, 11 ангилалд хуваадаг/



Дүрслэл 5 Нүүрсний зах зээлийн үнэ 2012-2017 он, ам.доллар/тн



Эх сурвалж: <http://en.sxcoal.com>, “Эрдэнэс таван толгой” ХК

Chalco trading Hongkong Co.ltd компанитай 2011 онд байгуулсан гэрээг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах нь зүйтэй байна

2.3.6. “Эрдэнэс таван толгой” ХК нь Хүний хөгжлийн сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.4⁷², Засгийн газрын 2010 оны 296 дугаар тогтоол⁷³-ыг үндэслэн БНХАУ-ын “Chalco trading Hongkong Co.ltd”-тай 2011 онд байгуулсан “Нүүрс нийлүүлэх, худалдан авах тухай гэрээ, 2016 оны 2 дугаар сарын 3-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу Цанхийн зүүн хэсгээс олборлосон нүүрсний 65 хувийг “Chalco trading Hongkong Co.ltd”-ийн нэрлэсэн худалдан авагчид, 35 хувийг Цанхийн зүүн хэсгийн гэрээт олборлогч “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК-ийн нэрлэсэн худалдан авагчид худалдаж байжээ.

2.3.7. БНХАУ-ын “Chalco trading Hongkong Co.ltd”-аас 2011 онд байгуулсан гэрээ, гэрээний 2012 оны нэмэлт өөрчлөлтийн 2.2⁷⁴, 2014 оны нэмэлт өөрчлөлтийн 3.3⁷⁵-д заасны дагуу урьдчилгаа төлбөр 350.0 сая ам.доллар авахаас 348.0 сая ам.доллар хүлээн авч, 2.0 сая ам.долларыг ашиглаагүй боловч урьдчилж гарсан зардалд 2012 онд бүртгэж, зээл болон урьдчилгаа төлбөрийн хүүг 350.0 сая ам.доллараар тооцон төлсөн байна.

2.3.8. Уг 2.0 сая ам.долларыг ашиглаагүй зардлын зарцуулалт тодорхойгүй, ажлын гүйцэтгэл, тайлан, холбогдох баримтуудыг “Эрдэнэс таван толгой” ХК-д ирүүлээгүй, тооцоо

⁷² Хүний хөгжлийн сангийн тухай хуулийн 3.2.Сангийн орлого нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

3.2.4.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглахтай холбогдуулан авсан урьдчилгаа мөнгө, зээлийн тодорхой хэсэг.

⁷³ Засгийн газрын 2010 оны 296 дугаар тогтоолын 1. Хүний хөгжил сангийн 2011 оны орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор 310.6 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг урьдчилгаа төлбөр болон зээл хэлбэрээр бүрдүүлэх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн хороо, “Эрдэнэс Монгол” ХХК-д даалгасугай

⁷⁴ Талуудын 2012 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн нэмэлт өөрчлөлтийн 2.2 Гэрээний 4.4.7 дүгээр зүйлд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна. Үүнд: “Худалдан авагч тал Нэрлэсэн худалдан авагчид нүүрс нийлүүлэхэд шаардлагатай дэд бүтэц, ложистикийг БНХАУ-ын нутаг дэвсгэрт бий болгох үүрэг, амлалт авсныг харгалзан 2 сая ам.доллартай тэнцэх хэмжээний бэлэн мөнгийг Худалдан авагч тал хүлээн авах эрхтэй. Худалдагч талын үйл ажиллагааг дэмжих зорилгоор түүнд олгох нэмэлт санхүүжилт буюу 2012 оны урьдчилгаа төлбөрийн хэсгийг Худалдагч тал хүлээн авсан даруйд 2 сая ам.долларыг (Худалдагч талаас худалдан авагчид төлөх) 2012 оны урьдчилгаа төлбөрийн (в) хэсгээс шууд суутган шилжүүлнэ.”

⁷⁵ Талуудын 2014 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн “Гэрээний нэмэлт өөрчлөлт ба баталгаажуулалт” гэрээний 3.3 “Худалдагч тал 2012 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн нэмэлт гэрээнд заасан тухайн өдөр төлөгдөх хугацаатай БНХАУ-аас нүүрс экспортлохтой холбоотой 2 сая ам.долларын төлбөрийг худалдагч талаас худалдан авагч талд төлснийг хүлээн зөвшөөрнө. Нягтлан бодох бүртгэл болон аудитын зорилгоор худалдан авагч тал орлогоор, худалдагч тал борлуулалтын зардлаар тайландаа бүртгэнэ”



нийлээгүй байхад ТУЗ-ийн 2017 оны 06 дугаар тогтоол⁷⁶ үндэслэн борлуулалтын зардалд бүртгэсэн нь НББТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.7⁷⁷ дахь заалтыг зөрчсөн байна.

2.3.9. ААНОАТТХ-ийн 4.1.6⁷⁸, 17.2.9⁷⁹ заалтын дагуу “Chalco trading Hongkong Co.ltd”-ийн урьдчилгаа төлбөрийн хүүгийн орлогод ногдуулах суутган татварыг Нүүрс нийлүүлэх, худалдан авах гэрээний 9.1⁸⁰ дугаар заалт, 2014 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн нэмэлт өөрчлөлт, баталгаажуулалтын 3.2⁸¹ заалтуудыг үндэслэн “Эрдэнэс таван толгой” ХК нийт 12.1 сая ам.доллар буюу 21,647.7 сая төгрөгийг хариуцаж төлсөн байна.

2.3.10. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Д.Ариунболд БНХАУ-ын “Chalco trading Hongkong Co.ltd”-тай *“гэрээ байгуулсан асуудал, суутган татвар, 2.0 сая ам.доллартай холбоотой асуудал нь “Эрдэнэс таван толгой” ХК-ийг санхүүгийн эрсдэлд оруулахуйц гэрээ эсэх, мөн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжид заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн эсэх”*-ийг шалгуулах хүсэлтийг Авлигатай тэмцэх газарт 2017 оны 3 дугаар сарын 07-ны өдөрт 01/04 дугаар албан бичгээр гаргасан боловч Нийслэлийн прокурорын 2017 оны 122 дугаар тогтоол⁸²-оор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзжээ.

2.3.11. Дээрх гэрээнд заасны дагуу урьдчилгаа төлбөрийн хугацаа */урьдчилгаа төлбөрийг 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдөр бүрэн барагдуулсан/ дууссан өдрөөс гэрээний үндсэн хугацаа 5 жил үргэлжлэх /2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болох/ бөгөөд Цанхийн зүүн хэсгээс олборлосон нүүрсний 80 хувийг “Chalco trading Hongkong Co.ltd”-ийн нэрлэсэн худалдан авагчид, 20 хувийг “Эрдэнэс таван толгой” ХК сонгон шалгаруулалтаар худалдан борлуулах боломжтой болжээ.*

2.3.12. Талууд гэрээний хугацаанд БНХАУ-ын нүүрсний зах зээлийн үнийн индексийг харгалзан улирал тутам үнийг шинэчилж байхаар гэрээнд заахдаа Цанхийн зүүн хэсгийн эхний 1 сая тн нүүрсний үнийг 69.9-70.0 ам.доллар⁸³ байхаар тогтоосноос Цанхийн баруун хэсгийн нүүрсний борлуулалтын үнээс 2017 оны жилийн эцсийн байдлаар 8.8 ам.доллароор хямд үнээр борлуулж, 40.1 сая ам.доллар буюу 97,327.9 сая төгрөгийн орлого олох боломжийг алдсан гэсэн тооцоолол гарч байна.

2.3.13. Мөн талуудын 2014 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн гэрээний нэмэлт өөрчлөлтөөр худалдааны “DAP-Цагаанхад”⁸⁴ нөхцөлийг “FCA-уурхайн ам”⁸⁵ болгон өөрчилсөн нь “Эрдэнэс таван толгой” ХК нүүрс тээвэрлэлтэд өөрсдийн менежментийг хэрэгжүүлэх замаар өртөг шингээх, борлуулалтын ашгийг нэмэгдүүлэх боломжийг алдахад хүргэсэн байна.

⁷⁶ “Эрдэнэс таван толгой” ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 06 дугаар тогтоол “компанийн 2016 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газрын захиалгаар, хөндлөнгийн аудитын байгууллага болох “БДО аудит” ХХК-ийн аудитын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй”

⁷⁷ НББТХ 7.7. Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно.

⁷⁸ ААНОАТТХ 4.1.6. “суутгагч” гэж албан татвар төлөгчид олгосон орлогод энэ хуулийн дагуу албан татвар ногдуулан суутгаж, улсын болон орон нутгийн төсөвт шилжүүлэх үүрэг бүхий этгээдийг;

⁷⁹ ААНОАТТХ 17.2.9. Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Монгол Улсын нутаг дэвсгэрт болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон дараахь орлогод 20 хувиар:

⁸⁰ ННХАГ-ний 9.1 Худалдагч нь д) энэхүү нүүрс нийлүүлэх, худалдан авах гэрээний дагуу Худалдагчийн олсон орлогод МУЗГ-ийн эсхүл түүний харьяа байгууллагаас Худалдагч болон Худалдан авагчид ногдуулах бүх төрлийн татварыг хариуцна. Худалдан авагч тал дээрх татвар, хураамжийг төлснөөс үүсэх хохирлыг Худалдагч тал хариуцах бөгөөд Худалдан авагчийг хохиролгүй болгоно. /Худалдагч “Эрдэнэс таван толгой” ХК, Худалдан авагч “Chalco trading Hongkong Co.ltd”

⁸¹ Талуудын 2014 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн “Гэрээний нэмэлт өөрчлөлт ба баталгаажуулалт” гэрээний 3.2 “... урьдчилгаа төлбөрийн хүүгээс олсон болон олох орлогод ногдуулах суутган татварыг худалдан авагч тал хариуцахгүй”

⁸² Нийслэлийн прокурорын газрын 2017 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 122 дугаар тогтоол “Эрдэнэс таван толгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Д.Ариунболдын гаргасан гомдолд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсугай. Хяналтын прокурор хууль цаазын зөвлөх Ш.Баярбилэг, Нийслэлийн прокурорын орлогч хууль цаазын итгэмжит зөвлөх Ж.Ариунаа

⁸³ Уг 69.9-70.0 ам долларын үнэ нь DAP –Цагаанхад нөхцөлтэй буюу тухай үеийн Цагаанхад хүртэлх тээврийн зардал 18.6 ам.долларыг хасаж тооцвол 51.4 ам.доллар орчим байсан байна.

⁸⁴ ИНКОТЕРМС -2010: DAP – Цагаанхад нөхцөл нь худалдагч бүтээгдэхүүнийг худалдан авагчийн заасан байршилд хүргэж өгөх бүх зардлыг хариуцах,

⁸⁵ ИНКОТЕРМС -2010: FCA – уурхайн ам нөхцөл нь худалдан авагч бүтээгдэхүүн уурхайд ачигдсанаас хойш гарах бүх зардлыг хариуцах



2.3.14. Нүүрс нийлүүлэх, худалдах гэрээний 15.1, 15.2, 22.9 дүгээр зүйлд “...Нью-Йорк муж улсын дотоодын хуулийн дагуу тайлбарлаж, ойлгоно”, “...аливаа маргаан, маргаантай асуудал, ... гэрээний хүчин төгөлдөр байдалтай холбоотой асуудлыг заавал дагаж мөрдөгдөх шийдвэр бүхий арбитраар шийдвэрлүүлнэ”, “Арбитрын маргаан шийдвэрлэх ажиллагааг Сингапур дахь Сингапурын олон улсын арбитрын төвийн дүрмийн дагуу гурван арбитрчийн бүрэлдэхүүнтэйгээр явуулна...” гэж заасан байна.

2.3.15. “Эрдэнэс таван толгой” ХК нь уг нүүрс нийлүүлэх, худалдан авах гэрээнээс шалтгаалан 2.0 сая ам.долларын зардлын зарцуулалт тодорхойгүй байхад зардлаар бүртгэсэн, “Chalco trading Hongkong Co.ltd”-ийн хүүгийн орлогод ногдох татварыг хариуцан төлсөн, нүүрсний үнийн зөрүүгээс их хэмжээний орлого олох боломжийг алдахад хүрсэн зэрэг нь худалдан авагчид давуу байдал олгосон байж болзошгүй байгаа тул хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах нь зүйтэй байна.

Төмөр замаар тээвэрлэн, эцсийн хэрэглэгчид борлуулах замаар үнийг 9.4-18.8 ам.доллаароор нэмэгдүүлэх боломжтой байна



Зураг 2 Нүүрсний борлуулалтын доод үнийг тооцох аргачлал

2.3.16. “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн маркетинг хариуцсан нэгж нь Ганцмод боомтын коксжих нүүрсний үнээс холбогдох зардлуудыг хасах замаар FCA-уурхайн амны үнэд шилжүүлж борлуулалтын доод үнийг тооцдог байна.

2.3.17. Аудитын тооцооллоор БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ганц мод боомтын коксжих нүүрсний үнэ 2017 оны IV улирлын байдлаар 143.5-158.6 ам.доллар байсан бөгөөд уг аргачлалын дагуу БНХАУ-ын татварын зардал 28.7-34.9 ам.доллар, автозамаар тээвэрлэх зардал 22.7 ам.доллар, хилийн хураамж, агуулахын зардал 6.2 ам.доллар, бусад зардал 4.9-8.8 ам.доллар гэж үзэхэд уурхайн амны үнэ 78.1-89.3 ам.доллар байх боломжтой байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 17-д харуулав/

2.3.18. Нүүрс худалдан авч буй дундын зуучлагч компанийн ашиг 5-15 хувь буюу 3.9-13.4 ам.доллар, авто тээврийн зардал нийт зардлын 34 орчим хувийг эзэлж байгаа төдийгүй төмөр замын тээврийн зардлаас 5.45 ам.доллаароор өндөр⁸⁶, нүүрсийг төмөр замаар тээвэрлэн, эцсийн хэрэглэгчид борлуулах замаар 1 тн нүүрсний үнийг 9.4-18.8 ам.доллаароор нэмэгдүүлэх боломжтой байна.


⁸⁶ Эх сурвалж: Тавантолгойн ордын Цанхийн зүүн хэсгийн ТЭЗҮ-д тусгагдсан нүүрсний тээврийн зардлын тооцоолол



2.3.19. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ганцмод нүүрсний зах зээлийн үнэ, Цанхийн баруун хэсгийн коксжих нүүрсний үнийн зөрүү буюу тээвэр, хил гааль болон бусад зардлын дүн 2016 оны 9,10 дугаар сард өмнөх сараас 27.7-102.1 хувиар өссөн байна.

2.3.20. Дээрх үнийн зөрүү 2017 оны 12 дугаар сарын байдлаар 81.6 ам.доллар буюу “FCA -уурхайн ам” нөхцөлтэй борлуулалтын үнээс 1.2 дахин их болсон байгаа нь “Эрдэнэс таван толгой” ХК худалдааны нөхцөлийг “DAP – Цагаанхад /Ганцмод/” болгон өөрчлөх замаар тээвэрлэлтийг өөрсдийн менежментээр гүйцэтгэн өртөг шингээх, борлуулалтын үнийг өсгөх бодлого баримтлах шаардлагатай гэдгийг харуулж байна.

Дүрслэл 6 Коксжих нүүрс нийлүүлэх гэрээний тоо, дундаж үнэ /ам.доллар/



Эх сурвалж <http://en.sxcoal.com>, “Эрдэнэс таван толгой” ХК

2.3.21. Мөн Монгол Улсад эрдэс баялгийн бүтээгдэхүүний арилжааны зохицуулалттай зах зээлийг бий болгох замаар энэ салбараас олох орлогын хэмжээг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний үнэ буурах эрсдэлийг бууруулах зах зээлийн арга хэрэгслийг ашиглах зорилгоор эрдэс баялгийн бирж байгуулах талаар УИХ-ын 2014 оны 18 дугаар тогтоол⁸⁷, 2017 оны 11 дүгээр тогтоол⁸⁸, Засгийн газрын 2014 оны 211 дүгээр тогтоол⁸⁹ тус тус батлагдсан боловч хэрэгжилт хангалтгүй байна.

2.3.22. Иймд УИХ, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангуулах, эрдэс баялгийн түүхий эдийн биржийг байгуулах, түүний үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бий болгох талаар Засгийн газар, салбарын яамны зүгээс арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Цанхийн баруун хэсгийн нүүрсний борлуулалтаас 3.2 сая ам.долларын орлого олох боломжийг алдсан байна

2.3.23. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Ариунболдын 2017 оны А/02 дугаар тушаалаар “Нүүрс худалдан авагчид тавигдах шаардлага” батлагдах хүртэлх хугацаанд нүүрс борлуулах үйл ажиллагааг зохицуулсан дүрэм журам байгаагүй бөгөөд уг

⁸⁷ УИХ-ын 204 оны 18 дугаар тогтоол 3.7.5. эрдэс баялгийн бүтээгдэхүүний гадаад, дотоодын зах зээл дээрх борлуулалтыг нээлттэй, оновчтой, өндөр үр ашигтай, зах зээлийн зарчимд нийцсэн аргаар хийх, шударгаар үнэ тогтоох, дотоодын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, экспортыг нэгдсэн бодлогоор зохицуулах зорилгоор эрдэс баялгийн бирж байгуулах;

⁸⁸ УИХ-ын 2017 оны 11 дүгээр тогтоол “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” 82. Эрдэс баялгийн түүхий эдийн биржийг байгуулах, түүний үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бий болгох

⁸⁹ Засгийн газрын 2014 оны 211 дүгээр тогтоол “Эрдэс баялгийн бирж байгуулах тухай”



тушаал батлагдсанаар Цанхийн баруун хэсгийн нүүрс, Цанхийн зүүн хэсгийн нүүрсний 20 хувийн худалдан авагчийг сонгон шалгаруулалтаар шалгаруулж байна.

2.3.24. Аудитын хамарсан хугацаанд нийт 13 удаа нүүрс худалдан авагчийн сонгон шалгаруулалт явагдсан боловч баримтжуулалт, хяналт хангалтгүйгээс сонгон шалгаруулалт хариуцлагатай явагдсан гэж үзэх боломжгүй байна. Тухайлбал:

- Сонгон шалгаруулалтад ирүүлж буй материалыг хүлээн авч буй ажилтанд тавих хяналт хангалтгүй;
- 2017 оны 05 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулагдсан сонгон шалгаруулалтад хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн “Meng heng energy” компанид гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн эсэх нь нотлогдоогүй;
- 2017 оны 6 дугаар сарын 09, 20-ны өдрүүдийн сонгон шалгаруулалтад санал ирээгүй гэж архивын баримтын товьёгт тэмдэглэсэн боловч бусад нэгжийн төлөөллийг оролцуулан бүртгэл үйлдэж баримтжуулаагүй;
- оролцогчдын ирүүлсэн саналыг хэн хэрхэн үнэлж гэрээ байгуулах шийдвэр гаргасан талаар тэмдэглэл, баримт байхгүй;
- гэрээ байгуулагдсаны дараа “Нүүрс худалдах сонгон шалгаруулалтад оролцогчдын ирүүлсэн саналыг хянан үзсэн хүснэгт”-ийг үйлдэн Гүйцэтгэх захирал Д.Ариунболд, Борлуулалтын газрын захирал О.Хатанбаатар нар гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

2.3.25. Нүүрсний борлуулалт Цагаан сар, Үндэсний баяр наадам, улирлын онцлог зэргээс шалтгаалан жил бүрийн 2 дугаар сард өмнөх сараас 22.6-81.1 хувиар, 7 дугаар сард 32.9-81.5 хувиар буурдаг хандлагатай бөгөөд Ганц мод боомт дахь нүүрсний үнэ 2017 оны 6 дугаар сарын 08-ны өдрөөс 2017 оны 08 дугаар сарын 03-ны өдөр хүртэл 850 юань буюу 126.8 ам.долларт тогтвортой хадгалагдаж 8 дугаар сарын 4-ний өдрөөс аажим өсөж эхлэн 9 дүгээр сарын 01-ний өдөр 1,000 юань буюу 149.3 ам.доллар хүрсэн байна.

2.3.26. Гэвч 2017 оны II улиралд зах зээлийн үнэ буурснаас ачилт удааширч, гэрээний үнийг бууруулах тухай хүсэлтийг худалдан авагч нараас ирүүлсэн, агуулахын үлдэгдэл тасралтгүй нэмэгдэж нийлүүлэлт эрэлтээс давах шинжтэй болсон тул “Эрдэнэс таван толгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Д.Ариунболд Борлуулалтын газар, Маркетингийн газраас хамтарсан ажлын хэсэг байгуулсан байна.

2.3.27. Ажлын хэсэг урьдчилгаа төлбөрийн хэмжээнээс хамааруулж 2-5 хүртэлх хувийн хөнгөлөлт үзүүлэх, нүүрсний хэмжээнээс хамааруулан сонгон шалгаруулалтын доод үнийг буулгах⁹⁰ хосолсон стратегид шилжих замаар хоёроос багагүй 500.0 мянган тн буюу түүнээс их хэмжээний нүүрс нийлүүлэх гэрээ байгуулах, өмнөх гэрээнүүдийн үнийг “*хамгийн сүүлд сонгон шалгаруулалтын дагуу байгуулсан/байгуулах гэрээний үнэ+1ам.доллар*” болгон бууруулж гэрээний хэрэгжилтийг хангуулах, сонгон шалгаруулалтыг илүү хүртээмжтэй болгохыг компанийн удирдлагад санал болгосон байна.

2.3.28. Гэвч “Эрдэнэс таван толгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Д.Ариунболд ажлын хэсгийн саналыг хэрэгжүүлээгүй, Гүйцэтгэх захирлын 2017 оны А/02 дугаар тушаал⁹¹, “*Нүүрс худалдах, худалдан авах тухай гэрээ*”-ний “*Худалдааны нөхцөлийн тухай хавсралт*”-ын 2.4 дэх заалт⁹²-ыг зөрчсөнөөс нийт 3.2 сая ам.доллар буюу 7,862.5 сая төгрөгийн орлого олох боломжийг алдсан байна. Тухайлбал:

- Компанийн удирдлага дахин сонгон шалгаруулалт зарлалгүйгээр 2017 оны 7 дугаар сард 2.1 сая тн нүүрсийг “Эрдэнэс таван толгой” ХК-ийн тухайн үеийн борлуулалтын үнээс⁹³ 4.5 ам.

⁹⁰ Их хэмжээний буюу 500.0 мянга тн-с их хэмжээтэй гэрээний сонгон шалгаруулалтын доод үнийг 65.1 ам.доллар, бага хэмжээний гэрээний сонгон шалгаруулалтын доод үнийг 66.2 ам.доллар хүртэл бууруулах

⁹¹ Гүйцэтгэх захирлын 2017 оны А/02 дугаар тушаалын 2. Энэ тушаалыг 2017 оны 1 дүгээр сарын 09-ний өдрөөс эхэлж мөрдөнө.

⁹² Худалдааны нөхцөлийн тухай хавсралтын 2.4 Уг хавсралтын 2.3-д заасан үнэ нь энэхүү гэрээний хүчинтэй хугацаа дуустал тус хавсралтад заасан хэмжээний нүүрсэнд хамаарна. Гэрээний хүчинтэй хугацаанд нүүрсний үнэ өөрчлөгдөхгүй.

⁹³ “Эрдэнэс таван толгой” ХК нүүрс худалдан авагчтай 2017 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр байгуулсан гэрээнд 73.1 ам.доллар, 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан гэрээнд 73.4 ам.доллар, 2017 оны 6 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан гэрээнд 68.0 ам.долларын гэрээнүүд тус тус байгуулсан бөгөөд эдгээр үнийн дунджаар тооцоход 71.5 ам.доллар болсон болно.



доллараар бага буюу 67.0 ам.доллараар худалдах гэрээг 7 компанитай шууд байгуулсан нь урьдчилсан тооцооллоор 2.97 сая ам.долларын,

- Нэр бүхий 4 компанитай байгуулсан гэрээний үнийг 69.0 ам.доллар⁹⁴ болгон бууруулах ёстой байсан боловч 67.0 ам.доллар болгон бууруулсан нь урьдчилсан тооцооллоор 0.2 сая ам.долларын орлого олох боломжийг алдсан.

2.3.29. БНХАУ-ын нүүрсний үнэ 2017 оны 9 дүгээр сард 8 дугаар сарын дунджаас 11.1 хувь, 7 дугаар сарын дунджаас 17.6 хувиар тус тус өссөн боловч “Эрдэнэс таван толгой” ХК 2017 оны 10, 11 дүгээр сард борлуулалтын үнийг шинэчлэхдээ 0.1-1.1 ам.доллар буюу 0.15-1.64 хувиар өсгөсөн байна. Хэрвээ борлуулалтын үнийг зах зээлийн үнийн өсөлттэй уялдуулан⁹⁵ шинэчилсэн бол 0.2 сая ам.доллар буюу 516.6 сая төгрөгийн орлого олох боломжтой байсан гэсэн тооцоо гарч байна.

Нүүрс ачилт, экспортын үйл ажиллагаанд тавигдах хяналтыг сайжруулах шаардлагатай байна

2.3.30. Нүүрс худалдах, худалдан авах гэрээнд нүүрсний чанарын үзүүлэлтүүд “ $\pm 10, +10, - 8$ ” зэргээр тодорхой түвшинд хэлбэлзэхээр тусгаж байгаа хэдий ч “Эрдэнэс таван толгой” ХК-ийн борлуулалтын газрын мэргэжилтнүүд нүүрсний аль овоолгоос ачилт хийгдсэн талаар тодорхой мэдээлэлгүй байгаа нь худалдан авагчид нийлүүлж буй нүүрс гэрээнд заасан чанарын үзүүлэлтэд нийцэж буй эсэхэд бүрэн хяналт тавьж чадахгүй байгааг харуулж байна.

2.3.31. Нүүрс худалдах, худалдан авах гэрээнд заасны дагуу худалдан авагч нь тээвэрлэлтийн компанитай байгуулсан гэрээ, тээвэрлэлт хийх авто машины жагсаалтыг “Эрдэнэс таван толгой” ХК-д бүртгүүлж, уг бүртгэлийн дагуу уурхайн ачилт, экспортын алба нүүрсний ачилтыг зохион байгуулж байна.

2.3.32. Тээврийн компани, ачааны автомашины жагсаалт, ачилт хийх овоолгын мэдээлэл, авчсан нүүрсний хэмжээ зэргийг бүртгэдэг “TSL, Manage, Client” программд хандах хэрэглэгчийн эрхийн тодорхой зохицуулалтгүй, түүхчилсэн мэдээлэл хадгалагддаггүй, мэдээллийн санд оруулсан устгалт, өөрчлөлтийн бүртгэлгүй, компанийн мэдээллийн технологийн албаны зүгээс тавих хяналт хангалтгүй байгаа тул программын зохион байгуулалт, үйл ажиллагаа, аюулгүй байдал, хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал:

- Тээврийн хэрэгслийн эзэмшигч компани солигдсон тохиолдолд өмнөх эзэмшигч компанийн талаарх мэдээлэл хадгалагддаггүй, өмнөх онуудын бүртгэл одоогийн эзэмшигчээр харагддаг;
- Мэдээллийн баазад 2016-2018 онд бүртгэгдсэн нүүрс ачилтын мэдээллийн баазын мэдээллийг шалгаж үзэхэд зарим устгагдсан бичилтүүдийн шалтгаан тайлбарууд иж бүрэн бус;
- Нүүрс ачилт хийж гарсан автомашины бүртгэл пүүний программаас утсан тохиолдол гарсныг дотоод хяналтаар илрүүлэн худалдан авагчтай хийх тооцоонд тусган, мэргэжлийн тодруулга авахаар мэдээллийн технологийн албанд хандсан боловч хариу өгч, тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

2.3.33. Мөн нүүрс экспортын гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд Гаалийн ерөнхий газрын гаалийн улсын ахлах байцаагч И.Хишигбаяр, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн уурхайн гаалийн хяналтын бүсийн эрхлэгч Ц.Оюунчимэг нарын гэр бүлийн хүмүүс⁹⁶ гаалийн ажиллаж байгаагаас гаалийн хяналт бодитой хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

⁹⁴ Хамгийн сүүлд зохион байгуулагдсан /2017 оны 6 дугаар сарын 9-ний өдөр/ сонгон шалгаруулалтаар 68.0 ам.доллараар худалдах гэрээ байгуулсан

⁹⁵ Нүүрсний үнэ 2017 оны 9 дүгээр сард 7 дугаар сарын дунджаас 17.6 хувь өссөн бөгөөд уг өсөлтийн 20 хувь буюу 3.53 хувь өснө гэж тооцов.

⁹⁶ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 1.5 “хамаарал бүхий этгээд” гэж тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг;



2.3.34. Худалдан авагч, тээвэрлэгч компаниудын хооронд байгуулсан тээврийн гэрээг үндэслэн тээврийн компани, ачааны автомашиныг программд бүртгэн, ачилт хийх ёстой хэдий ч тээврийн гэрээ, ачааны автомашиныг бүртгүүлээгүй байхад тээвэр хийх, нэг тээврийн хэрэгсэл олон худалдан авагчийн нүүрсийг тээвэрлэх зэрэг зөрчлүүд илэрч байна. Үүнд:

- “Эрдэнэс таван толгой” ХК-д тээврийн гэрээ бүртгүүлээгүй боловч нүүрс тээвэрлэсэн:
 - “Говь Хармагтай” ХХК-ийн 26 тээврийн хэрэгсэл 2018 оны 8-10 дугаар сард Ганц мод чиглэлд 105 удаагийн рейс;
 - “Би Эс Тур Транс” ХХК-ийн 62 тээврийн хэрэгсэл 2018 оны 08-11 дүгээр сард Ганцмод чиглэлд 913 удаагийн рейс,
- Тээврийн үйлчилгээ үзүүлэх гэрээнд заагдсан зарим тээврийн хэрэгслүүд 2-8 компанид давхар тээвэр гүйцэтгэсэн:
 - Худалдан авагч “Cheng Yuan Trading Co.,Ltd” тээвэрлэгч “Берун Ложистик” ХХК-ийн хооронд байгуулсан 2018 оны 20180724-01 дугаар бүхий “Нүүрс тээвэрлэлтийн гэрээ”-нд заагдсан 16 тээврийн хэрэгсэл “Chalco Trading Hongkong Co.,Ltd”-ийн нүүрсийг 111 рейс тээвэр хийсэн,
 - Худалдан авагч “НАО Хян Энерги” ХХК тээвэрлэгч “Мандал ложистик” ХХК-ийн хооронд байгуулсан 2018 оны 05 дугаар сарын 07-ний өдрийн “Нүүрс тээвэрлэлтийн гэрээ”-д заагдсан 5 тээврийн хэрэгсэл өөр төрлийн 10 компанийн нүүрсний 130 рейс тээвэр хийсэн байна,

2.3.35. “Эрдэнэс таван толгой” ХК нь борлуулалтын гэрээнд заасны дагуу худалдан авагчийн байршуулсан урьдчилгаа төлбөрийн хэмжээтэй уялдуулан нүүрсний ачилтыг зохион байгуулдаг бөгөөд 2016-2017 онд нийт 27.2 сая тонн нүүрс экспортолж 1,373.4 сая ам.долларын орлого төвлөрүүлээд байна.

Хүснэгт 21 Экспортын хэмжээ, борлуулалтын орлого

№	Хамрах хугацаа	Экспортолсон нүүрс /мян.тн/			Борлуулалтын орлого /сая ам.доллар/
		Коксжих	Исэлдсэн	Нийт	
1	2016 он	7,485.5	-	7,485.5	211.1
2	2017 он	7,425.7	1,059.8	8,485.5	485.7
	Нийт	14,911.2	1,059.8	15,971.1	696.8

Эх сурвалж: Аудитын баг

КОМПАНИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ ӨМНӨХ ОНУУДААС САЙЖИРЖЭЭ

2.3.36. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд “БДО аудит” ХХК аудит хийж 6 зөвлөмж өгч, “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна. Харин 2017 оны санхүүгийн тайланд “Конфиденсе аудит” ХХК аудит хийж 7 зөвлөмж өгч, “Хязгаарлалттай” санал дүгнэлт хүргүүлсэн байна.

2.3.37. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2016-2017 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд нийт хөрөнгө 11,366,825.5 сая төгрөгөөр өссөн нь хувьцаа бүртгэлд тусгасантай холбоотой бөгөөд өр төлбөр өмнөх оноос 282,258.2 сая төгрөгөөр буурч, 2017 онд 36,820.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Үзүүлэлтийг 2016-2017 оноор харуулбал:


Хүснэгт 22 “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн нийт хөрөнгийн нэгтгэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Тайлант хугацаа		Зөрүү
	2016.12.31	2017.12.31	
Нийт хөрөнгийн дүн	479,712.7	11,846,538.2	11,366,825.5
Өр төлбөрийн нийт дүн	895,975.8	613,717.6	(282,258.2)
Хуримтлагдсан ашиг	(416,563.1)	36,820.6	453,383.7
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	479,712.7	11,846,538.2	11,366,825.5

Эх сурвалж: “Эрдэнэс таван толгой” ХК-ийн санхүүгийн тайлан



2.3.38. Борлуулалтын орлого 2016 онд 546,485.4 сая төгрөг, 2017 онд 1,238,109.7 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд 467,131.6-1,182,364.0 сая төгрөг буюу 85.8-95.5 хувьтай орлого 2016 онтой харьцуулахад 40.0 хувь буюу 715,232.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.



Эх сурвалж: “Эрдэнэс таван толгой” ХК-ийн санхүүгийн тайлан

2.3.39. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн ТУЗ-ийн 2016 оны А/09 дүгээр тогтоолоор 2016 оны үйл ажиллагааны зардал 589,212.5 сая төгрөг, 2016 оны 26 дугаар тогтоолоор 2017 оны үйл ажиллагааны зардлын төсөв 890,227.0 сая төгрөгөөр тус тус батлагдаж гүйцэтгэлээр 2016 онд 119,804.7 сая төгрөгөөр, 2017 онд 169,815.1 сая төгрөг хэмнэсэн нь зарим зээлийн өр төлбөрийг бүрэн төлснөөс хамаарсан байна.

Хүснэгт 23 “Эрдэнэс таван толгой” ХК-ийн үйл ажиллагааны зардлын төлөвлөгөө гүйцэтгэлийн судалгаа (сая.төг)

Үзүүлэлт	Зардал		Хэмнэлт
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
2016 он	608,803.5	488,998.8	119,804.7
2017 он	890,227.0	720,411.9	169,815.1

Эх сурвалж: “Эрдэнэс таван толгой” ХК-ийн санхүүгийн тайлан

2.3.40. Улсын төсөвт 2016 онд 72,181.6 сая төгрөг, 2017 онд 235,547.5 сая төгрөгийг төлсөн нь өмнөх оноос 69.3 хувь буюу 163,365.9 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй, өр төлбөр бууруулах чиглэлээр “Chalco trading Hongkong Co.ltd” ХХК зээлийн өр төлбөрийн 141,141.8 сая төгрөгийн үлдэгдлийг бүрэн барагдуулсан, Хөгжлийн банкны өрийг хэсэгчлэн барагдуулсан зэргээс хамаарч борлуулалтын орлого нэмэгдсэн байна.

2.3.41. Хувьцааны бүртгэлийн талаар Засгийн газрын 2017 оны 154 дүгээр тогтоолын дагуу иргэд, аж ахуйн нэгжийн хувьцааг санхүүгийн тайланд бүртгэснээр 1072 ш хувьцаа эргэлтэд орох нөхцөлийг бүрдүүлжээ.

2.3.42. “Эрдэнэс таван толгой” ХК 2016 онд 198,840.2 сая төгрөгийн алдагдлын 93 хувь буюу 184,600.0 сая төгрөгийн гадаад валютын ханшийн алдагдлаас хамаарсан бөгөөд 2017 онд 461,069.4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Зарим авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, тооцоо нийлээгүй байна

2.3.43. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн санхүүгийн тайлангаар 2016 онд 22,352.2 сая төгрөг, 2017 онд 41,407.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарсан бөгөөд авлага өмнөх оноос 53 хувь буюу 19,055.1 сая төгрөгөөр өссөнөөс дансны авлага 4,097.6 сая төгрөг буюу 21.5 хувь, татварын авлага 8,340.9 сая төгрөг буюу 43.8 хувь, бусад авлага 25.0 сая төгрөг буюу 0.1 хувь, хувьцааны авлага 6,591.6 сая төгрөг буюу 34.6 хувийг тус тус эзэлж байна.



Хүснэгт 24 Компанийн 2016-2017 оны авлагын бүтэц (сая.төгрөг)

№	Үзүүлэлт	2016 он	2017 он	Өсөлт, бууралт	Хувь
1	Дансны авлага	20,086.7	24,184.3	4,097.6	21.5
2	Татварын авлага	1,872.5	10,213.4	8,340.9	43.8
3	Бусад авлага	393.0	418.0	25.0	0.1
4	Хувьцааны авлага		6,591.6	6,591.6	34.6
	Нийт авлагын дүн	22,352.2	41,407.3	19,055.1	100.0

Эх сурвалж: “Эрдэнэс таван толгой” ХК-ийн санхүүгийн тайлан

2.3.44. Тус компани 2016 онд “Баярс констракшн” ХХК-тай холбоотой 238.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй нь маргаан шийдвэрлэгдээгүйгээс шалтгаалсан бөгөөд 2017 онд дотоодын 5 байгууллагатай 19.0 сая төгрөгийн авлагын тооцоо нийлсэн акт үйлдээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

2.3.45. Мөн 2016, 2017 онуудад гадаадын бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай холбоотой 5,787.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Үүнд:

Хүснэгт 25 Авлагын үлдэгдэл баталгаажуулаагүй компаниуд (сая.төгрөг)

№	Байгууллагын нэр	Дүн /мян.төг/	Тулган баталгаажуулалт
1	HK Sunkfa group limited	3.93	Тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй
2	Kun Lun international	17.33	
3	Wulate zhongqi elion	68.67	
4	Bayannur Conglin mining Co.LTD	90.02	
5	First Concept Logistics Limited	838.38	
6	Tian yu group	1,028.96	
7	Shen Hua bayannaer energy	3,740.37	
	Нийт дүн	5,787.66	

2.3.46. Найдваргүй авлагын нөөцийн санг 11,891.1 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд найдваргүй авлагын нөөцийг тогтоохдоо НБББББ-ийн 4.2 дугаар бүлгийн 9-т “Найдваргүй авлагын нөөц байгуулахдаа 3-5 жилийн насжилттай авлагыг 50 хувиар” гэсэн заалтыг зөрчин 100 хувиар тооцож “Bayannur Conglin mining Co.LTD” ХХК 45.0 сая төгрөг, “HK Sunkfa group limited” ХХК 1.9 сая төгрөг, “Kun Lun international” 8.6 сая төгрөг, нийт 55.6 сая төгрөгөөр зөрүүтэй байгуулсан байна.

2.3.47. Дээрх байгууллагатай холбоотой 11,822.4 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулах, зардлаар бүртгэх талаар хуулийн байгууллагаас шийдвэр гараагүй байхад найдваргүй авлагаар бүртгэж зардлаар тусгасан нь компанийн НБББББ-ийн 4.2 дугаар бүлгийн 9-т “Авлага эргэн төлөгдөх найдваргүй болсон нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон үед шүүхийн шийдвэр, нотолгоог үндэслэн тухайн авлагын шинж чанар, дүнгээс хамаарч компанийн ТУЗ, Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогчийн зөвшөөрөл, шийдвэрээр авлагыг данснаас хасаж бүртгэлд тусгана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.3.48. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн зарим хувьцааг аж ахуйн нэгж байгууллагуудын худалдан авсан 6,591.6 сая төгрөг Сангийн яаманд төвлөрсөн байгааг Сангийн яамнаас авахаар авлага үүсгэн бүртгэсэн боловч тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

2.3.49. Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4⁹⁷, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн НБББББ-ийн 6-д “Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн

⁹⁷ Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна



газрын даргын 2002 оны оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 171/111 дугаар тушаалаар баталсан Тооцооны үлдэгдлийн баталгаа /НХМаягт-3/ маягт эсвэл ажил үйлчилгээний онцлогт тохирсон маягтын үндсэн дээр харилцагч байгууллагуудтай тооцооны үлдэгдлийг улирал, жилийн эцэст тулган тохируулж тооцоо нийлсэн актыг үйлдэнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.3.50. Өглөг 2016 онд 895,975.6 сая төгрөгөөс байснаас 2017 онд 613,717.3 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 282,258.3 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй гарчээ. Цалингийн өглөгөөс хамаарч, татвар, НДШ-ийн өглөгүүд үүссэн ба дараа сардаа хуулийн дагуу төлөгдсөн байна.

2.3.51. “Эрдэнэс таван толгой” ХК 2016 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр “Саусгоби сэндси” ХХК-тай Цанхийн баруун хэсгийн уулын ажлыг гүйцэтгүүлэхээр ЭТТ-2016/131 дүгээр гэрээг байгуулсан бөгөөд гэрээний хугацаанд 885.2 мянган тонн нүүрсийг ачаагүйтэй холбоотой маргаанаас шалтгаалан гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, маргаантай байсан тул 1,252.3 сая төгрөгийн өглөг үүссэнийг 2017 оны жилийн эцэст тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

2.3.52. “Эрдэнэс таван толгой” ХК нь “Хишиг арвин индустриал” ХХК-тай 2013 оны 07 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан ажлыг гүйцэтгүүлэх гэрээний дагуу ажлын гүйцэтгэлээр гарсан 4,571.2 сая төгрөгийг “Хишиг арвин индустриал” ХХК-д төлөх эсэх нь маргаантай хуулийн байгууллагад шалгуулж байгаа тул тооцоо нийлээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

2.3.53. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн НБББББ-ийн 4.2 дугаар бүлгийн 7-д “Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 171/111 дугаар тушаалаар баталсан Тооцооны үлдэгдлийн баталгаа /НХМаягт-3/ маягт эсвэл ажил үйлчилгээний онцлогт тохирсон маягтын үндсэн дээр харилцагч байгууллагуудтай тооцооны үлдэгдлийг улирал, жилийн эцэст тулган тохируулж тооцоо нийлсэн актыг үйлдэнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.3.54. Нийгмийн даатгалын шимтгэлд 113.6 сая төгрөгийг 2016 оны санхүүгийн тайланд тусгасан боловч Нийгмийн даатгал шимтгэл төлөлтийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.3.55. Урт болон богино хугацаат зээлийн гэрээний төлөлтийн хуваарьт өөрчлөлт орсноос өглөг үүссэн байна. Үүнд:

- УИХ-ын 2010 оны 32, Засгийн газрын 2012 оны 93, 161 дүгээр тогтоолоор батлагдсан “Сайншанд-Тавантолгой-Ухаа худаг-Гашуунсүхайд” чиглэлээр шинээр барих төмөр замын төсөл хэрэгжүүлэхээр Монгол Улсын Хөгжлийн банкнаас 2012 оны 10 дугаар сарын 04-ний өдөр жилийн 7.35 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаанд төлөх нөхцөлтэйгөөр ЗТЗБ-2012-144 дүгээр зээлийн гэрээгээр 100.0 сая ам.долларын зээл авчээ. Зээлийн төлөлтийн хуваарийн дагуу 2016 оноос эхлэн үндсэн төлбөрт 100.0 сая, хүүгийн төлбөрт 31.5 сая, нийт 131.5 сая ам.доллар төлөөгүй учир 2015 онд ЭТТ-2015/119 дугаар, 2016 онд ЭТТ-2015/207 дугаар нэмэлт гэрээг байгуулж хугацааг сунгасан байна.
- Засгийн газрын 2012 оны 148 дугаар тогтоолоор батлагдсан Төмөр замын төслийг санхүүжүүлэх зориулалтаар Монгол Улсын Хөгжлийн банкнаас 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 3-ЭТ-ХО-2012-12-162 дугаар зээлийн гэрээгээр 100.0 сая ам.долларыг жилийн 7.8 хувийн хүүтэй, 1 жилийн хугацаанд төлөх нөхцөлтэйгөөр авчээ. Төлөлтийн хуваарийн дагуу 100.0 сая ам.долларын зээлийг 1 жилийн дотор үндсэн төлбөрт 100.0 сая ам.доллар, хүүгийн төлбөрт 7.8 сая ам.доллар, нийт 107.8 сая ам.доллар төлөхөөр байна. Гэвч зээлийн гэрээний дагуу төлөлт хийгдээгүй тул 2015 онд ЭТТ-2015/084, 2016 онд ЭТТ-2016/206, 2017 онд ЭТТ-2017/055 дугаар нэмэлт гэрээ хийж хугацааг сунгасан байна.



Дээрх 144, 162 дугаар гэрээнүүдийн дагуу үндсэн төлбөрт 242,713.0 сая, хүүгийн төлбөрт 94,104.1 сая, нийт 336,817.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Засгийн газрын 2014 оны 177 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын хөгжлийн банкнаас 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 3-ЭТ-Э-2014-210 дугаар Зээлийн гэрээгээр 50.0 сая ам.долларыг жилийн 8.3 хувийн хүүтэй, 1 жилийн хугацаанд төлөх нөхцөлтэй, үйл ажиллагааг дэмжих, нүүрсний экспортыг нэмэгдүүлэх зориулалтаар зээл авсан байна. Гэрээний зорилгыг хэрэгжүүлэн өмнө нь авсан зээлийн өрийг хаасан байна.

БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗАРИМ ЖУРМЫГ ЗӨРЧИН ЗАРЦУУЛЖЭЭ

2.3.56. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн А/09 дүгээр тогтоолоор 2016 оны үйл ажиллагааны зардалд 589,212.5 сая төгрөг, 2016 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 26 дугаар тогтоолоор 2017 оны үйл ажиллагааны зардалд 890,227.0 сая төгрөгөөр баталсан байна.

Зардлыг ерөнхий буюу үндсэн төрөл, ангиллаар харуулбал:

Хүснэгт 26 Зардлын гүйцэтгэл 2016-2017 он (сая.төгрөг)

№	Зардлын ангилал	2016 он	2017 он	Өсөлт/бууралт	Хувь
1	Үйлдвэрлэлийн зардал	461,793.2	562,546.1	100,752.9	17.9
2	Татвар хураамжийн зардал	59,439.8	249,517.0	190,077.2	76.2
3	Санхүүгийн зардал	42,740.1	36,178.7	(6,561.4)	(18.1)
4	Ерөнхий болон удирдлагын зардал	7,056.7	7,311.5	254.8	3.5
5	Маркетинг борлуулалт ложистикийн зардал	27,182.7	29,129.5	1,946.8	6.7
6	Зөвлөх үйлчилгээний зардал		1,118.2	1,118.2	100.0
7	Удирдлагын төлбөр		4,426.0	4,426.0	100.0
	Нийт дүн	598,212.5	890,227.0	292,014.5	32.8

Эх сурвалж: “Эрдэнэс таван толгой” ХК-ийн санхүүгийн тайлан

2.3.57. Санхүүгийн тайлангаар үйлдвэрлэлийн зардал өмнөх оноос 100,752.9 сая төгрөг буюу 17.9 хувиар, татвар хураамжийн зардал 190,077.2 сая төгрөг буюу 76.2 хувиар, ерөнхий болон удирдлагын зардал 254.8 сая төгрөг буюу 3.5 хувиар, маркетинг борлуулалтын зардал 1,946.8 сая төгрөг, нийт зардал өмнөх оноос 292,014.5 сая төгрөг буюу 32.8 хувиар өссөн байна. Харин санхүүгийн зардал өмнөх оноос 6,561.4 сая төгрөг буюу 18.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Мөнгөн кассын журмыг зөрчжээ

2.3.58. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын 2017 оны А/48 дугаар тушаалаар батлагдсан “Мөнгөн кассын журам”-ын 2.2.1-т “Төв оффисын кассын нэг удаагийн санхүүжилтийн доод хэмжээ 5.0 сая төгрөгөөс хэтрэхгүй байна” гэсэн заалтыг зөрчин 10.0 сая төгрөгөөр дүүргэлт хийсэн байна. Тухайлбал:

- 2017 онд мөнгөн кассын дүүргэлтийг 120.0 сая төгрөгөөр илүү нөхөн дүүргэлт хийсэн нь дээрх журамд нийцээгүй;
- кассын дээд хязгаар болон сарын санхүүжилтийн дүнг 2.2.1 дэх хэсэгт тодорхой заагаагүйгээс кассаар их хэмжээний мөнгийг гүйлгээнд оруулж шагнал урамшуулал олгосон;
- Мөнгөн кассад 2016 онд 39.7 сая төгрөг татан төвлөрүүлж, Компанийн гүйцэтгэх захирлын 2016 оны А/242 дугаар тушаалаар ажил дүгнэх, 2016 оны Б/578 дугаар тушаалаар урамшуулал олгох тухай шийдвэр гаргаж 57 ажилтанд бэлэн мөнгөөр олгосон бөгөөд урамшуулал олгоходоо 190.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцоогүй нь ХХОАТ-ын 26.1.2-т “Энэ хуулийн 11.1.1-д заасан албан татварыг сар бүрийн эцэст ногдуулж, мөн хуулийн 24.1-д заасан хөнгөлөлтийг хасаж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн;



- Мөнгөн кассад 2017 онд 57.5 сая төгрөг татан төвлөрүүлж, Компанийн гүйцэтгэх захирлын 2017 оны А/58 дугаар тушаалаар “Саятан жолооч” уралдаан зохион байгуулах шийдвэр гаргаж 87 ажилтан болон 1 байгууллагад бэлэн мөнгөөр олгосон;
- хамтран ажилладаг байгууллагуудын ажилтанд урамшуулал олгоно гэсэн эрх зүйн зохицуулалт болон дүрэм, журамд тусгаагүй боловч хамтран ажилладаг төрийн байгууллага буюу хил хамгаалах, гааль, мэргэжлийн хяналт, цагдаагийн нийт 43 ажилтан, албан хаагчдад 15.9 сая төгрөгийн урамшуулал олгосон байна

2.3.59. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын 2017 оны өдрийн А/132 дугаар тушаалаар батлагдсан “Компанийн зээлийн карт ашиглах” журмын 3.1-т “Компанийн зээлийн картын сарын зээлжих дээд хязгаар”-ыг гүйцэтгэх захирал 10.0 сая, дэд захирал болон газрын захирал 3.0 сая төгрөгөөр тус тус тогтоожээ. Зээлийн картаар 2016 онд 3 албан тушаалтан 65.6 сая төгрөгийг, 2017 онд 6 албан тушаалтан 54.1 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 27 Зээлийн карт эзэмшигчдийн судалгаа (сая.төгрөг)

№	Албан тушаал	Карт эзэмшигчийн нэр	Хамрах хүрээ		Тайлбар
			2016 он	2017 он	
1	Гүйцэтгэх захирал	Т.Билгээ	38.9		Журмын 2.4 дэх заалтын дагуу Уулзалт, гадаад дотоодын арга хэмжээ, гадаад томилолтод зарцуулсан байна
2	Гүйцэтгэх захирал	Д.Ариунболд	25.3	17.2	
3	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Д.Чулуунхүү	1.4		
4	Гүйцэтгэх захирал	Б.Ганхуяг		8.2	
5	Санхүү, эдийн засаг эрхэлсэн дэд захирал	Б.Жаргалсайхан		3.6	
6	Захиргаа, удирдлагын газрын захирал	Ө.Сумъяабаатар		14.9	
7	Худалдан авалт хариуцсан дэд захирал	Ц.Хангай		10.2	
	Нийт дүн		65.6	54.1	

2.3.60. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын 2016 оны 6 дугаар сарын 24-ний А/130 дугаар тушаалаар батлагдсан “Ажилтанд тусламж, тэтгэмж, нөхөн төлбөр, дэмжлэг олгох журам”-д ажлаас чөлөөлөгдөхөд олгох дэмжлэг болон шагнал урамшуулал олгох талаар тодорхой заалт байхгүй байхад зардал гаргасан байна. Үүнд:

- Ажлаас чөлөөлөгдсөн 24 ажилтанд 2016 онд 214.1 сая, 11 ажилтанд 2017 онд 49.4 сая, нийт 263.5 сая төгрөг,
- Шагнал урамшуулал, шинэ жилийн арга хэмжээнд 2016 онд 147.8 сая төгрөгийн зардлыг тус тус зориулалтын бусаар зарцуулсан байна.
- Мөн журмын 3.1.1-т “Ажилтны эхнэр, нөхөр, хүүхэд, төрсөн эцэг, эх, ах, эгч, дүү нас барсан бол 0.7 сая төгрөг” гэж заасан байхад зарим ажилтанд 1.0 сая төгрөг олгосон байна.

2.3.61. “Эрдэнэс таван толгой” ХК “Бодь даатгал” ХХК-тай удирдах ажилтны хариуцлагын даатгалын ЭТТ-2015/203 тоот гэрээг 16 албан тушаалтанд 26,000.0 сая төгрөгөөр тооцож даатгал хийлгэжээ. Уурхайн үйлдвэрлэл хариуцсан захирлаар ажиллаж байсан Б.Гантулгыг ажлаас чөлөөлөхөд Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх 2017 оны 182/ШШ2017/00273 дугаар шийдвэрээр 53.3 сая төгрөгийг компанийн данснаас шууд татан авсан тул даатгалын компаниас авах авлагаар бүртгэсэн байна.

2.3.62. Даатгалын гэрээний 6А-1 дэх заалтыг үндэслэн нөхөн төлбөрийг “Бодь даатгал” ХХК-аас гаргуулах хүсэлт тавьсан боловч татгалзсан тул энэхүү асуудлыг шийдвэрлүүлэхээр Санхүүгийн зохицуулах хороонд 2018 оны 02/1055 дугаар албан бичгийг хүргүүлсэн байна.

2.3.63. Санхүүгийн зохицуулах хороо Даатгалын тухай хуулийн 10.1.5, Иргэний хуулийн 439.1, 439.5 дах заалтуудыг баримтлан нөхөн төлбөрийг олгох нь зүйтэй гэж дурджээ. Иймд даатгалын компаниаар байгуулсан гэрээний заалтуудыг хэрэгжүүлэхийн тулд харьяалагдах



дээд шатны байгууллага болон хуулийн байгууллагад мэдэгдэл хүргүүлж тодорхой шийдвэр гаргуулж байгууллагыг хохиролгүй болгох талаар арга хэмжээ аваагүй байна.

2.3.64. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 04 дугаар тогтоолоор “Эв санаа” үйлдвэрчний эвлэлийн дарга С.Эрдэнийн эмчилгээний зардалд 2015 онд 73.1 сая, 2016 онд 215.9 сая, нийт 289.0 сая төгрөгийг олгосноос 14.8 сая төгрөгийг буцаан өгсөн байна.

2.3.65. Тус компанийн 203 ажилчдыг “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК-д шилжүүлэх гэрээ хийгдсэн нь ажилчдын эрх ашиг, аюулгүй байдал, ажлын байр, хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зэргийг хөндсөн тул хэвлэлийн бага хурлын үеэр өөрийгөө золиосолж эрсдэлтэй үйлдэл хийсэн байна.

2.3.66. Энэхүү эмчилгээний зардал 2015, 2016 онд компанийн зардлын төсөвт батлагдаагүй, ямар зардлын зүйл ангиллаас зарцуулсан нь тодорхой бус, “Ажилтанд тусламж, тэтгэмж, нөхөн төлбөр, дэмжлэг олгох журам”, Компанийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хамтын гэрээний 4.13 дах заалтад нийцэхгүй, тогтоосон хязгаараас хэтэрсэн байна.

2.3.67. Шаардлага хангахгүй, ашиглахгүй, эдийн засгийн үр ашиггүй, үхмэл хөрөнгө болсон 10 ширхэг буюу 1,650.0 төгрөгийн өртөгтэй автомашинд элэгдлийн зардал тооцсон нь Эрдэнэс Таван толгой” ХК-ийн НБББББ-ийн 4 дүгээр бүлгийн 4.5-ын 7 дугаар хэсэгт *“Хөрөнгийг ашиглалтад тавьж олгоогүй, агуулахад байгаа хөрөнгөнд элэгдэл байгуулахгүй, ашиглаж эхлээгүй байгаа хөрөнгийг элэгдүүлэхгүй”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.3.68. 2011 онд 102.4 сая төгрөгийн элэгдлийн зардлыг мото цагаар, 2012 онд хөрөнгийг 5 жил ашиглана гэж тооцоод 330.0 сая төгрөгөөр, 2015 онд аудит хийсэн компани элэгдэл тооцох гэсэн зөвлөмж өгсний дагуу 2014, 2013 онуудын элэгдлийг 660.0 сая төгрөгөөр нөхөн тооцуулсан, 2016 онд элэгдэл 165.0 сая төгрөг, нийт 1,257.4 сая төгрөгөөр тооцсон нь санхүүгийн зардлыг өсгөж байгаа тул залруулах бичилт хийх шаардлагатай байна.

2.3.69. Гүйцэтгэх захирал Д.Ариунболдын 2017 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/128 дугаар тушаалаар нийгмийн хариуцлагын хүрээнд үзүүлэх зардлаас Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын эмзэг бүлгийн 10 өрхөд 25.0 сая төгрөгийн үнэ бүхий 5н ханатай гэр, 2.0 сая төгрөгийг замын зардалд тус тус зарцуулжээ. Тус тушаалын үндэслэлд Монголын улаан загалмай нийгэмлэгийн хүсэлтийг үндэслэн гэсэн боловч тэрхүү албан бичиг хүсэлт аудитаар олдоогүй, ирүүлээгүй болно.

2.3.70. Худалдан авалт, тендертэй холбоотой баримт бичиг болон шууд худалдан авалт хийсэн гэрээ байхгүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т “Шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, Босго үнийн “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 10.0 сая төгрөг байна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.3.71. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.11-т “Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” гэж тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг” гэсэн заалтыг зөрчсөн байх үндэслэлтэй байна.

2.3.72. Засгийн газрын 2014 оны 91 дүгээр тогтоолын дагуу МУ-ын нүүрсний экспорт болон өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаад худалдааны тэнцвэрийг сайжруулах зорилгоор



Ганцмод-Гашуунсухайт боомтын нарийн цариг бүхий боомтын төмөр замд хөрөнгө оруулалт хийж, барих, ашиглах зорилгоор “Гашуунсухайтын төмөр зам” ХХК-ийг холбогдох аж ахуйн нэгжүүдтэй хамтран байгуулах, хөрөнгө оруулах замаар тодорхой хувийг эзэмшүүлэхээр болсон байна.

2.3.73. “Гашуун сухайтын төмөр зам” ХХК-ийн дүрмийн санг 1.5 сая ам.доллар бүрдүүлэхэд “Эрдэнэс таван толгой” ХК 17 хувь буюу 422.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Хүснэгт 28 Хувь нийлүүлсэн хөрөнгө (сая.төгрөг)

№	Огноо	Хувь нийлүүлсэн хөрөнгө /ам.доллар/	Ам.долларын ханш	Хөрөнгө оруулалтын дүн /төгрөгөөр/
1	2014.05.07	85,000.0	1,800.05	153,004,250.0
2	2014.12.18	85,000.0	1,897.10	161,253,500.0
3	2015.10.22	43,865.9	1,991.98	87,380,007.5
4	2016.02.26	10,000.0	2,037.14	20,371,400.0
Нийт дүн		223,865.9		422,009,157.5

2.3.74. “Гашуунсухайтын төмөр зам” ХХК-д хийгдсэн хөрөнгө оруулалтын 422.0 сая төгрөгөөр ТЭЗҮ болон ажлын зураг, инженер геологийн ажлын төлбөр зэрэгт зарцуулж үр дүнгүй зардал гаргасан байна. Оруулсан хөрөнгө оруулалтын дүн өссөн нь 121.3 сая төгрөгөөр ханшийн тэгшитгэл хийсэнтэй холбоотой байна.

2.3.75. Засгийн газрын 2017 оны 96 дугаар тогтоолын 2-т “Гашуун сухайт-Ганц мод чиглэлийн боомтын төмөр зам барих зорилгоор байгуулсан “Гашуунсухайтын төмөр зам” ХХК-д оруулсан хувь хөрөнгийг татан авах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг “Эрдэнэс таван толгой” ХК-ийн ТУЗ-д даалгасан байна.

2.3.76. Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хэсгийг компанийн гүйцэтгэх захирлын 2017 оны 4 дүгээр сарын 19-ний А/76 дугаар тушаалаар байгуулжээ. Ажлын хэсэг тус компанийг татан буулгах ажлыг хамтран байгуулсан хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэх, улмаар оруулсан хувь хөрөнгийг татан авах, хөрөнгө оруулалтад хөндлөнгийн аудит хийлгэх нь зүйтэй гэж үзсэн байна.


2.3.77. Ажлын хэсгийн шийдвэр гарсан боловч “Гашуун сухайтын төмөр зам” ХХК-ийн хөрөнгө оруулагчдаас хамаарч хөрөнгийг татан аваагүй нь хөрөнгө оруулалтын зардал үр дүнгүй, үр өгөөжгүй болоход хүргэжээ.

ЗАРИМ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ЗӨРЧСӨН, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС НЭМЭЛТ ЗАРДАЛ ГАРЧ БАЙНА

2.3.78. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 2016 онд нийт 176,355.7 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 256 худалдан авалт, 2017 онд нийт 262,029.3 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 275 худалдан авалт зохион байгуулахаар төлөвлөсөн боловч нүүрсний зах зээлийн уналт 2017 оны I улирал хүртэл үргэлжилж байсантай холбоотойгоор дийлэнх тендер шалгаруулалтуудыг зохион байгуулаагүй байна.



Дүрслэл 8 Зардлын бүтэц /тэрбум төгрөг/



2.3.79. Тус компанийн 2016-2017 оны батлагдсан зардлын 61-72 хувийг гэрээт олборлогчийн зардал эзэлдэг бөгөөд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл гэрээт олборлогчийн зардлыг хасаж тооцвол 2016 онд 17.1 хувь, 2017 онд 52.8 хувийн биелэлттэй байна.

2.3.80. Цанхийн зүүн хэсгийн олборлогчийн зардал гэрээт олборлогчийн нийт зардлын 65-75 хувийг эзэлж байгаа бөгөөд гэрээт олборлогч “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК-тай гэрээ байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1⁹⁸ дэх хэсгийг зөрчсөн байна.

2.3.81. Засгийн газрын 2016 оны 258 дугаар тогтоол⁹⁹, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 28 дугаар тогтоолын дагуу Цанхийн баруун уурхайд “Саусгоби сэндс” ХХК уурхайн үйл ажиллагаа явуулахаар “Эрдэнэс таван толгой” ХК-тай 2016 оны 11 дүгээр сард гэрээ байгуулж, ажил гүйцэтгэсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1¹⁰⁰-д заасантай нийцэхгүй байна.

2.3.82. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилогдсон зарим хөндлөнгийн хараат бус гишүүн үнэлгээний хорооны гишүүнээр орж ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг гаргаагүй, үнэлгээний хорооны хуралд оролцоогүй нь тендер шалгаруулалтад хөндлөнгийн хяналт бүрэн хэрэгжээгүй байх эрсдэлийг бий болгож байна. Тухайлбал:

- Уурхайн хотхонд катеринг үйлчилгээ үзүүлэгчийг сонгох тендер - С.Мандахбат У.Сарангэрэл;
- Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хугацаат үзлэгийн үйлчилгээ үзүүлэгчийг сонгох тендер - О.Мандухайцэцэн;
- 2 долгионы GNSS байнгын ажиллагаатай суурин станцын иж бүрдэл, контроллер, таяаг нийлүүлэгчийг сонгох тендер - Ц.Батхүү;
- Харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэгчийг сонгох тендер - Э.Жавхлан;

2.3.83. Үнэлгээний хороо зарим тендерийн баримт бичгийг боловсруулахдаа Сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаалаар баталсан жишиг баримт бичгийн дагуу, иж бүрэн боловсруулаагүй байна. Тухайлбал:

- Уурхайн хотхонд катеринг үйлчилгээ үзүүлэгчийг сонгох-ТОӨЗ-ны 4.2-д "дараах тохиолдолд тендерт оролцогчийг эрх бүхий бус гэж үзнэ" хэсэгт "ISO 9001 суурьтай Чанарын удирдлагын тогтолцооны гэрчилгээний хуулбар ирүүлэх" гэж заасан нь жишиг баримт бичигтэй нийцээгүй;
- Харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэгчийг сонгох - тендерт түншлэлээр ТШӨХ-ийн 4.2-т тендерт түншлэлээр оролцох, туслан гүйцэтгэгчтэй байхыг зөвшөөрөхгүй заалт оруулсан;
- Том оврын автобус худалдан авах – Нийлүүлэхийг санал болгож буй автобусанд тавигдах техникийн тодорхойлолтод автобусны одометрийн заалт буюу гүйлтэд тавигдах хязгаарлалт тусгаагүй;

2.3.84. Үнэлгээний хороо зарим тендерийг хянан үзэхдээ ТШӨХ-д заасан тодорхойлолтыг хангаагүй, баримт материал иж бүрэн бус оролцогчдыг шалгаруулсан байгаа нь шалгаруулалт бодитой явагдаагүйг харуулж байна. Тухайлбал:

⁹⁸ ТБОНӨХБАҮХАТХ 3.1 3.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө.

⁹⁹ Засгийн газрын 2016 оны 258 дугаар тогтоол “Саусгоби сэндс” ХХК-ийн улсын төсөвт төлөх 35.3 тэрбум төгрөгийн талаар авах арга хэмжээний тухай”

¹⁰⁰ ТБОНӨХБАҮХАТХ 7.1.Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна:



- Уурхайн хотхонд катеринг үйлчилгээ үзүүлэгчийг сонгоход; - ТШӨХ-ийн 12.1.д заасан мэргэжлийн хяналтын байгууллагын баталгаажсан дүгнэлт бүхий хүнсний каталоги, хоолны цэс зэрэг баримт хавсаргаагүй,
- Цанхийн хэсгийн ашиглалтын хайгуулын өрөмдлөгийн цооногийн геофизикийн ажил гүйцэтгэгчийг сонгоход /13000 тууш метр/ - Техникийн инженер 5 буюу түүнээс дээш жил ажилласан байх туршлагатай байхаар заасан боловч 2 жил ажилласан туршлагатай,
- Оффисын түрээсийн үйлчилгээ үзүүлэгчийг сонгоход – шалгарсан “Чимо” ХХК-ийн борлуулалтын орлогыг тооцохдоо тус компанийн оффисын барилгын түрээсийн менежментийг хамтын ажиллагааны гэрээний дагуу гүйцэтгэгч Ай Эл Эм ХХК-ийн 2016 оны 352.8 сая төгрөгийн борлуулалтын орлогоор тооцож үнэлсэн,
- Цанхи хотхоны спорт заалны барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгоход – шалгарсан “Нью сувагт констракшн” ХХК-ийн ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага хэсэгт сүүлийн 3 жилд /2014 онд 1 ажил, 2015 онд 2 ажил, 2016 онд 5 ажил гүйцэтгэсэн/ 8 ажил гүйцэтгэсэн гэж ирүүлсэн боловч 5 гэрээ, 4 ажил дүгнэсэн акт ирүүлсэн,

2.3.85. Мөн шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах үйл ажиллагаа захиалагч нэгж, Хангамж, худалдан авах ажиллагааны газар, Хууль эрх зүйн газруудын ажлын уялдаа хангалтгүйгээс тендерт шалгарсан боловч гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй 5 гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан /үүнээс 3 гүйцэтгэгч нь гэрээ байгуулсны дараа нөхөж ирүүлсэн/ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.3¹⁰¹ дахь заалтыг зөрчсөн төдийгүй гүйцэтгэгчид давуу байдал¹⁰² олгосон байж болзошгүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 18-д харуулав /

2.3.86. Тендерт шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахдаа тендерийн баримт бичигт тусгаагүй байхад урьдчилгаа төлбөр олгох нөхцөл тусгасан, гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөрийн баталгаагүйгээр урьдчилгаа төлбөр олгосон нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.3.3¹⁰³, 44 дүгээр зүйлийн 44.4¹⁰⁴ дэх заалтыг зөрчсөн төдийгүй гүйцэтгэгчид давуу байдал олгосон байж болзошгүй байна. Тухайлбал:

- Тендерийн баримт бичигт урьдчилгаа төлбөрийн хэмжээ тусгаагүй боловч нүүрс тээврийн хүнд даацын хатуу хучилттай 8.2 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгч “Арж капитал” ХХК-тай гүйцэтгэх захирал Д.Ариунболдын 2017 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр байгуулсан гэрээнд 20% урьдчилгаа төлбөр төлөх нөхцөл тусгаж, 2,857.1 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр олгосон,
- Цанхи хотхоны спорт заалны барилга угсралтын ажлын гүйцэтгэгч “Нью сувагт констракшн” ХХК-д урьдчилгаа төлбөрийн баталгаагүйгээр 134.5 сая төгрөг олгосон байна,

2.3.87. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй, бэлтгэл ажлыг бүрэн хангаагүй нь нэмэлт гэрээ байгуулах, тендерийн хэмнэлт зарцуулагдахад хүргэж арвилан хэмнэлтгүй ажиллажээ. Тухайлбал:

- Нүүрс тээврийн хүнд даацын хатуу хучилттай 8.2 км авто замын ажил –гэрээнд заасан хугацаанд ашиглалтад ороогүйгээс хяналтын зөвлөх үйлчилгээнд нэмэлт зардал гарах нөхцөл үүссэн,

¹⁰¹ ТБОНӨХБАҮХАТХ 29.3. «Хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээ байгуулахаас татгалзсан, эсхүл энэ хуулийн 20.7.2-т заасан нөхцөл үүссэн бол түүнд олгосон гэрээ байгуулах эрхийг захиалагч хүчингүй болгож, удаахь “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчтой энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд ийм оролцогч байхгүй бол 30.4-т заасан шийдвэрийн аль нэгийг гаргана.

ТБОНӨХБАҮХАТХ 20.7.2 «хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдэлд заасан хугацаанд гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй, эсхүл гэрээ байгуулахаас татгалзсан.

¹⁰² Авлигын эсрэг хууль 3.1.4. “давуу байдал” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;

Авлигын эсрэг хууль 4.1.3. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;

¹⁰³ ТБОНӨХБАҮХАТХ 40.3. Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараахь нөхцөлийг заавал тусгана:

⁴⁰ 3.3. урьдчилгаа төлбөр хийх бол урьдчилгаа төлбөрийн баталгааны дүн, хэлбэр;

¹⁰⁴ ТБОНӨХБАҮХАТХ 44.4. Тендерийн баримт бичигт заагаагүй тохиолдолд захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.

**Шаардлага хангахгүй, ашиглахгүй ихээхэн хэмжээний өртөг бүхий үхмэл хөрөнгө бэлтгэжээ**

2.3.88. Компанийн гүйцэтгэх захирал Б.Энэбишийн 2011 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 49 дүгээр тушаалаар уурхайн үндсэн болон туслах машин механизмуудын дугуй нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтын Үнэлгээний хорооны даргаар Ч.Батбаатар /Уурхайн төлөвлөлт, зохион байгуулалтын албаны дарга/, нарийн бичгийн даргаар Б.Мөнхбаатар /Уурхайн төлөвлөлт, зохион байгуулалтын албаны инженер/, гишүүдээр Т.Билгээ, Т.Батбилэг, Б.Эрдэнэбилэг нар томилогдон ажиллан тус хорооны шийдвэрээр “Юу Эс Эс Трейд” ХХК-ийг шалгаруулсан байна.

2.3.89. Эрдэнэс Таван толгойн Уурхайд 260 тн даацтай авто самосвалын 30 ширхэг дугуй 3,675.5 сая төгрөгөөр нийлүүлэхээр “Эрдэнэс таван толгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Энэбиш, “Юу Эс Эс Трейд” ХХК-ийн Ерөнхий захирал Д.Болдсүрэн нар гэрээ байгуулсан байна.

2.3.90. Уг гэрээний дагуу Бараа бүтээгдэхүүн хүлээлцэх актаар, 20 ширхэг дугуйг хүлээлгэн өгөхдөө гэрээний хугацааг 2 сараар, 10 ширхэг дугуйг гэрээт хугацаанаас 1 сараар хоцроон нийлүүлсэн байхад гэрээний 17.1-т “Алданги ногдуулах хувь нэг 7 хоногт 0.5 хувь” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 57 дугаар зүйлийн 57.5¹⁰⁵ заалтыг зөрчсөн байна.

2.3.91. Үнэлгээний хороо байгуулаагүй, тендер зарлалгүйгээр TAS 3600 маркийн 60 тн даацтай автомашиныг 1 бүрийг 165.0 сая төгрөгөөр 10 ширхэг автомашин нийлүүлэх 2011 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн ЭТТ-2011/ХА2011/10/10 дугаар гэрээг “Эрдэнэс таван толгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Энэбиш, “Хулийн Голын Од” ХХК-ийн захирал Юу.Хуйцин нар шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1¹⁰⁶ дэх заалтыг зөрчсөн байна.

2.3.92. Дээрх 3,626.5 сая төгрөгийн үнэ бүхий 30 ширхэг том оврын дугуй, 1,650.0 сая төгрөгийн үнэ бүхий 10 ширхэг автомашиныг 2012 оноос хойш өнөөг хүртэлх хугацаанд ашиглаагүй байгаа нь хөрөнгийн зохистой байдал хангалтгүй, үр ашиггүй үрэлгэн зарцуулалт хийснийг харуулж байна.

2.3.93. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн Цагаан хад дахь гаалийн талбайд байршилтай 5,328.9 сая төгрөгийн өртөгтэй барилга байгууламжийг ашиглахгүй өнөөг хүрсэн байна.

ТАТВАР, ХУРААМЖИЙГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ТӨЛЖЭЭ

2.3.94. 2016 онд Зүүн уурхайгаас 7.2 сая тонн, Цанхийн Баруун уурхайгаас 5 сая тн, нийт 12.2 сая тонн нүүрс борлуулж 546,485.4 сая төгрөгийн орлого олохоор төлөвлөсөн боловч Цанхийн баруун уурхайтай холбоотой гэрээ дууссан, нүүрсний зах зээлийн үнэ унасан зэргээс хамаарч, 2017 онд БНХАУ-ын хил гаалийн хяналт, шалгалтаас хамаарч квотыг багасган тогтоож, тээвэрлэлтэд их хэмжээний ачаалал, дараалал үүсэж, нүүрсний экспорт буурснаас орлого тасарсан байна.

Хүснэгт 29 Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая.төгрөг)

Борлуулалтын үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Зөрүү	
	2016 он	2017 он	2016 он	2017 он	2016 он	2017 он
Цанхийн зүүн уурхай	320,862.7	684,182.2	409,568.4	673,562.1	(88,705.7)	10,620.1
Цанхийн баруун уурхай	225,622.7	553,927.5	57,563.2	508,801.9	168,059.5	45,125.6
Нийт дүн	546,485.4	1,238,109.7	467,131.6	1,182,364.0	79,353.8	55,745.7

¹⁰⁵ ТБОНӨХБАҮХАТХ 57.5 Тендерт оролцогч болон аливаа этгээд нь худалдан авах гэрээний үүргээ зөрчсөн, биелүүлээгүй, тендерт оролцохдоо илт худал мэдүүлсэн, авлигын гэмт хэрэг үйлдсэнийг шүүх, эрх бүхий улсын байцаагч тогтоосон бол уг шийдвэрийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээлийн бүртгэлд хамруулна

¹⁰⁶ ТБОНӨХБАҮХАТХ 7.1 Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна



2.3.95. Тус компани улс болон орон нутгийн төсөвт нийт 2016 онд 72,181.6 сая төгрөг, 2017 онд 235,547.5 сая төгрөгийн төлбөр хураамж төлсөн нь өмнөх оноос 163,365.9 сая төгрөгөөр буюу 69.3 хувиар өссөн байна.

ХУВЬЦААНЫ НЭРЛЭСЭН ҮНИЙН ТООЦООЛОЛ ҮНДЭСЛЭЛТЭЙ ЭСЭХИЙГ НОТЛОХ БОЛОМЖГҮЙ БАЙНА

2.3.96. УИХ-ын болон Засгийн газрын тогтоолуудыг үндэслэн нүүрсний орд ашиглах, компани байгуулах, хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, худалдах, худалдан авах, хувьцааны нэрлэсэн үнэ тогтоох, санхүүгийн тайланд бүртгэх зэрэг асуудлуудыг дараах байдлаар үе шаттайгаар хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 30 “Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцаатай холбоотой шийдвэрүүд

№	Тогтоолын дугаар	Огноо	Тогтоолын нэр	Хэрэгжилт
1	УИХ-ын 39 дүгээр	2010.07.07	Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай	Нүүрсний ордод төрийн өмчит компани ашиглалтын үйл ажиллагаа явуулах, Эрдэнэс таван толгой компанийг байгуулах, тусгай зөвшөөрөл эзэмшигч эзэмшигч компанийн 50 хүртэлх хувийг иргэд, аж ахуйн нэгжид эзэмшүүлэх, биржээр арилжаалах талаар үе шаттайгаар хэрэгжүүлэх
2	Засгийн газрын 272 дугаар	2010.10.20	“Эрдэнэс таван толгой” ХК байгуулах тухай	“Эрдэнэс таван толгой” ХК байгуулах
3	Засгийн газрын 350 дугаар	2010.12.29	Эрдэнэс Таван толгой ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжүүдэд худалдах	Стратегийн ач холбогдолтой бүхий ашигт малтмалын ордын төрд ногдох ашгаас МУ-ын иргэнд хишиг, хувь хүртээх, хувьцаа эзэмшүүлэх, хувьцааны 10 хувийг иргэдэд эзэмшүүлэх, худалдах
4	Засгийн газрын 347 дугаар	2010.12.29	МУ-ын иргэнд хишиг, хувь хүртээхтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай	МУ-ын иргэн хишиг, хувь хүртэх журам батлах, ЗГ-ын 264, 96 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах
5	Засгийн газрын 98 дугаар	2011.03.31	МУ-ын иргэнд “Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцааг эзэмшүүлэх	“Эрдэнэс таван толгой” ХК-ийн нийт хувьцааны 10 хувийг 2011 оны 3 дугаар сарын 31-ний өдөр болон түүнээс өмнө төрсөн, иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгүүлсэн Монгол Улсын иргэнд эзэмшүүлэх
6	УИХ-ын 57 дугаар	2011.11.30	Зарим арга хэмжээний тухай	“Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцааг ОУ-ын зах зээл дээр нээлттэй арилжиж эхлэх өдөр хүртэл хугацаанд МУ-ын иргэдийн эзэмшиж байгаа уг компанийн хувьцааг зөвхөн МУ-ын Засгийн газар нэрлэсэн үнээр нь худалдан авах
7	УИХ-ын 18 дугаар	2012.02.16	Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай	Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай УИХ-ын 2010.07.07/39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 2 дахь дэд заалтад нэмэлт өөрчлөлт оруулах
8	Засгийн газрын 116 дугаар	2012.04.11	“Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, ААН-д худалдах тухай	Иргэн бүрд 1.5 сая төгрөг олгох арга хэмжээний хүрээнд МУ-ын иргэнд “Эрдэнэс таван толгой” ХК-ийн нийт хувьцааны 20 хувийг эзэмшүүлэх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх
9	Засгийн газрын 181 дүгээр	2012.05.30	“Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцааны тухай	ЗГ-ын 2012/116 дугаар тогтоолын 2.3 дугаар зүйлд заасны дагуу “Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцааг иргэн, аж ахуйн нэгжийн хооронд худалдах, худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд тус компанийн 1072 хувьцааг 1 сая төгрөгтэй дүйцүүлэн тухайн хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тогтоох
10	Засгийн газрын 154 дүгээр	2017.05.30	“Эрдэнэс Монгол” ХХК болон түүний компанийн талаар авах зарим арга	“Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцааг ААН-д худалдсан болон уг хөрөнгийг банканд байршуулсны хүүгийн орлогыг тусгаарлах, 15 тэрбум хувьцааны 80 хувь буюу 12 тэрбум



		хэмжээний хувьцааны тухай	тухай	тэрбум ширхэг хувьцааг гаргасан хувьцаагаар, 20 хувь буюу 3 тэрбум ширхэг хувьцааг зарласан хувьцаагаар компанийн дүрэмд тусгаж бүртгэх, хувьцаа эзэмшигчийн бүртгэлийг үндэслэн хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тооцож санхүүгийн тайланд тусгах
--	--	------------------------------	-------	--

2.3.97. “Эрдэнэс таван толгой” ХК дээрх тогтоолуудыг үндэслэн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 12.0 тэрбум хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тооцон 11,196,000.0 сая төгрөгөөр бүртгэсэн байна. (11 их наяд 196 тэрбум) Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 31 Бүртгэсэн хувьцааны эзэмшигчдийн судалгаа /тоо, сая төгрөг/

№	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Нэгжийн үнэ /төгрөг/	Хувьцааны үнийн дүн
1	“Эрдэнэс таван толгой” ХХК /1072/	9,780,711,099	933	9,125,403.4
2	Монгол Улсын аж ахуйн нэгж /486/	7,065,038	933	6,591.7
3	Монгол улсын иргэд /2,511,332/	2,212,223,863	933	2,064,004.9
Хувьцааны дүн		12,000,000,000		11,196,000.0

2.3.98. ЗГ-ын 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 154 дүгээр тогтоол¹⁰⁷-ын 8.1-т “Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий бүртгэлийн ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас ирүүлсэн мэдээллийг үндэслэн “Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцаанаас хишиг хүртсэн болон Засгийн газарт нэрлэсэн үнээр хувьцаагаа худалдсан иргэдийн хувьцааг төрийн мэдлийн хувьцаанд нэмэгдүүлэн бүртгэж, шинээр хувьцаа эзэмших болон хувьцаагаа буцаан худалдан авах хүсэлт гаргаж төлбөрөө шилжүүлсэн иргэдийн хувьцааг төрийн мэдлийн хувьцаанаас шилжүүлэн хувь эзэмшигчдийн бүртгэлийг цэгцлэх ажлыг 2017 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хэрэгжүүлэх” гэж заасны дагуу засгийн газрын хувьцааг албан ёсоор бүртгэж, санхүүгийн тайланд тусгасан байна.

2.3.99. Дээрх тогтоолын дагуу хувьцаа бүртгэх талаарх холбогдох байгууллагуудын саналыг дурдвал:

- Сангийн яам: Нягтлан бодох бүртгэлийн газар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтын дагуу “Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцааг тус компанийн болон толгой компанийн нягтлан бодох бүртгэлд бүртгэхийг зөвлөсөн байна.
- Санхүүгийн зохицуулах хороо: “Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьд өгөөж нь нүүрсний олон улсын зах зээл дээрх үнээс шууд хамааралтай тул өгөөжийг тодорхойлох боломжгүй, компанийн эзэмшилд байх ордын нөөцөд дахин үнэлгээ хийгдээгүй үед “Биет бус хөрөнгө-Лиценз” дансанд хүлээн зөвшөөрч бүртгэх нь НББОУС-ын “Хүлээн зөвшөөрөлт ба хяналт” хэсгийн 21 дүгээр зүйлд “Биет бус хөрөнгийг тухайн хөрөнгөд хамаарах эдийн ирээдүйн өгөөж нь уг аж ахуйн нэгжид орох магадлалтай эсхүл хөрөнгийн өртгийг найдвартай хэмжиж чадах тохиолдолд хүлээн зөвшөөрнө” гэсэнтэй нийцэхгүй байна гэж үзжээ. Гэвч хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тооцож, нийт гаргасан хувьцааг тус компанийн санхүүгийн тайланд тусгахыг дэмжиж байна гэдгээ илэрхийлсэн байна.
- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв: Засгийн газрын 2017 оны 154 дүгээр тогтоолын 6, 8 дугаар заалт, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хувьцаа шилжүүлэх тухай албан бичиг, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг төвлөрсөн хадгаламж дахь “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 99-1003 тоот дансанд шилжүүлэн бүртгэсэн болно. Цаашид үнэт цаасны

¹⁰⁷ Уг тогтоолд “Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцааны хоёр дах зах зээлийн арилжаа эхлэх хүртэл хугацаанд тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хувьцааг саналын эрхгүй, Засгийн газар нэрлэсэн үнээр нь худалдахаас бусад тохиолдолд аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй байх нөхцөлтэйгээр иргэдэд эзэмшүүлэх, үндэсний аж ахуйн нэгжид худалдах ажлыг зохион байгуулах гэж заажээ



зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд үйлчилгээ авах мэргэжлийн анхан шатны зуучлагч байгууллагыг сонгож, дансаа нээлгэн, үнэт цаасаа шилжүүлэн бүртгүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна.

- “Эрдэнэс таван толгой” ХК: “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 7 дугаар тогтоолоор Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1, 18.2, Компанийн тухай хуулийн 76.1.18, Засгийн газрын 2017 оны 154 дүгээр тогтоол, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн албан бичгүүд, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн 8.11-д заасныг тус тус үндэслэн санхүүгийн тайланд тусгасан байна.

2.3.100. Дээрх байгууллагуудын санал, тушаал, шийдвэрүүдийг үндэслэн “Эрдэнэс таван толгой” ХК Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 154 дүгээр тогтоолын 8.2-т нэгж хувьцааг 933 төгрөгөөр үнэлж, нийт 11,196.0 тэрбум төгрөгөөр хувьцааг тайланд бүртгэсэн боловч нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тооцсон санхүүгийн ямар нэгэн тооцоолол, судалгаа, түүнийг нотлох баримт байхгүй байна.

2.3.101. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн төвлөрсөн хадгаламжид бүртгэлтэй 15.0 тэрбум ширхэг хувьцаа нь 2017 оны 3 дугаар улирлын байдлаар дараах эзэмшилтэй байна. Үүнд:

Хүснэгт 32 Зарласан хувьцааны эзэмшигчдийн судалгаа /сая ширхэг, хувь/

№	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Хувь
1	Төрийн мэдэлд	12,780.71	85.20
2	Аж ахуйн нэгж байгууллага /486/	7.07	0.05
3	Монгол улсын иргэд /2,511,332/	2,212.22	14.75
Хувьцааны дүн		15,000,000	100

2.3.102. Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын иргэдээс 385,945 иргэн 413,708,098 ширхэг хувьцаа эзэмшихгүйгээр 100 хувь хишиг хувь хүртсэн, 584 818 иргэн өөрийн эзэмшлийн хувьцааны тодорхой хувьцаанд хишиг хувь хүртэж 400,610,634 ширхэг хувьцаа эзэмшиж байна.
- Засгийн газрын 2016 оны 334 дүгээр тогтоолын дагуу өөрийн эзэмшлийн хувьцаагаа төрд буцаан худалдах хүсэлт гаргасан 1,309,983 иргэн байгаа бөгөөд хувьцааны мөнгө авсан 1,294,302 иргэдийн 360,438.0 сая төгрөгт ногдох 386,416,192 ширхэг хувьцааг төрийн мэдэлд шилжүүлсэн байна.

Хүснэгт 33 Төрд хувьцаагаа худалдсан иргэд, мөнгөн дүн

№	Олгосон төгрөг	Иргэдийн тоо	Дүн / сая төгрөг/
1	100,142	48,270	4,833.85
2	200,284	187,096	37,472.34
3	300,426	1,058,936	318,131.91
Нийт дүн			360,438.10

- ЗГ-ын 2017 оны 154 дүгээр тогтоолын дагуу хувьцаа худалдан авсан аж ахуйн нэгж, иргэд 2017 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөр тасалбар болгон хувьцаагаа төрд буцаан худалдах хүсэлт гаргасан тохиолдолд мөнгийг буцаан олгох үйл ажиллагааг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв Төрийн банкттай хамтран хийж гүйцэтгэсэн байна. Мөн 65 аж ахуйн нэгжийн 1,336.6 сая төгрөг, 2 иргэний 1.3 сая төгрөгийг тус тус буцаан олгож, аж ахуйн нэгжийн 1,432,605 ширхэг, иргэдийн 1416 ширхэг хувьцааг тус тус Төрийн мэдлийн эзэмшилд бүртгэсэн байна.

2.3.103. Компанийн гүйцэтгэх захирлын 2018 оны А/152 дугаар тушаалаар “1072 хувьцаа мэдээллийн төв”-ийг өөрийн санаачилгаар нээж, улмаар мэдээллийн төвөөр иргэдэд мэдээлэл зөвлөгөө өгөх, 1800-1072 лавлах утсаар болон фэйсбүүк пэйж хуудсаараа дамжуулан хувьцаа эзэмшигчдийнхээ сонирхсон асуулт, хүсэлтүүдэд хариулт өгч, иргэдэд шаардлагатай мэдээллийг агуулсан тараах материал хэвлүүлэн түгээж байна.



2.3.104. Тус төвөөс 7 хоног бүрийн лхагва гараг бүр танхимдаа сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж хэвшсэн, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг харгалзан зарим төрийн болон төрийн өмчийн бус аж ахуй нэгж байгууллагын ажилтан, албан хаагчдад хувьцаа, үнэт цаасны ач холбогдлын талаарх сургалтыг удаа дараа зохион байгуулсан. Тухайлбал:

- Үндэсний Хөрөнгө Оруулалтын банк, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн иргэдэд үйлчлэх төвүүдэд сургалт хийсэн нь иргэд хувьцааныхаа тухай мэдээллийг хүссэн газраасаа авах боломж нэмэгдүүлсэн байна.
- Орон нутгийн иргэдийн хүсэлтийн дагуу СЗХ, Монголын Хөрөнгийн бирж, “ҮЦТХТ” ТӨХК, брокер дилерийн компаниудтай хамтран нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх “Нээлттэй өдөрлөг”-ийг Дархан-Уул, Орхон, Булган аймгуудад зохион байгуулжээ.
- “1072 хувьцаа мэдээллийн төв”-өөр ирж үйлчлүүлсэн иргэн 15856, сургалтад хамрагдсан иргэн 2800, 1800-1072 лавлах утсаар мэдээлэл авсан иргэн 47408, 1072 хувьцаа мэдээллийн төвийн албан ёсны цахим пейж хуудсаар харьцсан иргэн 457100 байна.

2.3.105. ЗГ-ын 2012 оны 201 дугаар тогтоолын дагуу Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газраас хишиг хувь хүртсэн иргэдийн мэдээлэл Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгэсэн байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 34 Хишиг, хувь хүртсэн иргэд, мөнгөн дүн /сая төгрөг/

№	Төрөл	Иргэдийн тоо	Мөнгөн дүн
1	Оюутаны сургалтын төлбөр /2011 он/	133,819	66,909.5
2	Оюутаны сургалтын төлбөр /2012 он/	144,439	71,058.2
3	Эрүүл мэндийн даатгал /2011 он/	615,701	4,835.6
4	Ахмад настан	322,767	321,934.7
5	Хөгжлийн бэрхшээлтэй	1,751	1,751.0

2.3.106. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 26 дугаар тогтоолоор Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталж, *Хувьцаа IPO хариуцсан газар* байгуулагджээ. Улмаар компанийн гүйцэтгэх захирлын 2018 оны 8 дугаар сарын 27-ны А/260 дугаар тушаалаар 15 ажилтны орон тоог нэмж баталсан байна.

2.3.107. Хувьцаа IPO хариуцсан газар УИХ, ЗГ-ын шийдвэрийн хүрээнд Тавантолгойн төслийн үнэ цэнийг хамгийн өндөр төвшинд үнэлэх нөхцөлийг бүрдүүлж, хувьцааг олон улсын зах зээлд санал болгож арилжаалснаар Монгол Улсын иргэдийн эзэмшиж буй Таван толгойн хувьцааны үнэ цэнийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, тогтвортой хадгалах зорилготой ажиллаж байна.

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ШИЙДВЭР ГАРААГҮЙ БАЙНА

2.3.108. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2016 онд 198,840.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Тус компанийн ТУЗ-ийн 2017 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Компанийн тухай хуулийн 46.1, 46.6, 76.1.12, компанийн дүрмийн 9.3.14 дэх заалтыг тус тус үндэслэн ногдол ашиг хуваарилахгүй шийдвэр гаргасан байна.

2.3.109. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2017 онд 461,069.4 сая төгрөгийн ашигтай ажилласан боловч мөн ТУЗ-ийн 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Компанийн тухай хуулийн 46.1, 46.6, 76.1.12, Компанийн дүрмийн 9.3.14 дэх заалт, “Эрдэнэс Монгол” ХХК-аас ирүүлсэн удирдамжийг тус тус үндэслэн ногдол ашиг хуваарилахгүй байх шийдвэр гаргасан байна.

**Холбогдох байгууллагын санал:****ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
01 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8,
Финанс төв

Утас: 70118585, Факс: (976) 70119595

Цахим шуудан: info@erdenestt.mn

2019.01.14 № 02/119

танай _____ -ны № _____ -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Шаардлагын хариу

Үндэсний Аудитын Газраас 2018 оны 01/2600 тоот албан бичгээр ирүүлсэн тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тус тайлангийн төсөлтэй санал нэг байгаа бөгөөд аудитаар өгсөн санал зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах болно.

Жич: Тайлангийн төслийн зөвлөмж, дүгнэлт хэсэгт хэл найруулгын шинжтэй зарим өөрчлөлт оруулах саналыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 1 хуудастай.

ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН
УДИРДЛАГЫН ГАЗАР ХАРИУЦСАН
ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ



Б.ЖАРГАЛСАЙХАН

**Саналд өгсөн тайлбар:**

“Эрдэнэс таван толгой” ХК тайлангийн төсөлтэй санал нэг байгаа тухайгаа 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 02/119 дүгээр албан бичиг ирүүлсэн болно.

Мөн аудитын баг “Эрдэнэс таван толгой” ХК-иас 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 01/310 дугаар албан бичгээр ирүүлсэн нэмэлт баримт материалыг Аудитын зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар, 2019 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 01/1390 дугаар албан бичгээр ирүүлсэн нэмэлт баримт материалыг талуудын 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн уулзалт хэлэлцүүлгээр тус тус танилцуулж, тайланд тусгасан болно.



ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Тавантолгойн ордод 1982-2012 онд урьд өмнө хийгдсэн хайгуулын үр дүнгээр “Эрдэнэс таван толгой” ХК-ийн эзэмшлийн тусгай зөвшөөрлийн талбайд нийт 7,527.6 сая.тонн ордын нөөцийг Монгол улсын нөөцийн нэгдсэн санд бүртгэхээс 3,368.8 сая тн буюу нөөцийн 44.7 хувийг бүртгэсэн байна
2. Зөвхөн Цанхийн хэсэгт нарийвчилсан ТЭЗҮ боловсруулсан ч үйлдвэрлэлийн нөөцийг бүрэн тусгаж тооцоогүй, компанийн тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах ордын нөөцөд үндэслэн урьдчилсан ТЭЗҮ боловсруулаагүй, дагалдах ашигт малтмалын талаар баримтлах бодлогогүй, ордын нөөцийг ашиглах нийт хугацаа тодорхойгүй, нөөцийг үнэлэх боломж бүрдээгүй байна,
3. ТЭЗҮ-д хөрсний 2 дугаар овоолгыг үүсгэх талбайн газар чөлөөлөхөд шаардагдах хөрөнгийг тусгаагүйгээс төлөвлөөгүй байршилд хөрсний овоолго үүсгэж, хөдөлгөөний эрчим нэмэгдэн аюулгүй ажиллагаанд эрсдэл үүсэхээр байна.
4. Засгийн газар, яамдын зүгээс тавих хяналт сул, баяжуулах үйлдвэргүй зэргээс бүх давхаргыг жигд бусаар ашиглаж, коксжих чанар өндөртэй III, IV давхаргуудыг сорчлон олборлож байгаа нь урт хугацаанд бусад давхаргын нүүрсний үнэ цэнийг бууруулахаар байна,
5. Байгаль орчны хяналт сул, ТЭЗҮ-ийн дагуу үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулаагүй, олборлолтын явцад нүүрсний 0 давхаргыг ашиглаж эхлээгүйгээс дотоод овоолго үүсгээгүй, нөхөн сэргээлтийн ажил хийгдэх хугацаа хойшилсон нь шимт хөрсний чанарт нөлөөлөхөөр байна.
6. “Максмахон Монгол” ХХК нь “Уул уурхайн хамтын ажиллагааны гэрээ”-г “Эрдэнэс таван толгой” ХК-ийн зөвшөөрөлгүйгээр “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК-д шилжүүлсэн, гэрээнд олборлолтын төлбөрийг гадаад валютаар төлөхөөр зааж, олборлогчийн ажлыг дүгнэлгүйгээр их хэмжээний төлбөрийг үндэслэлгүй олгосон нь алдагдал хүлээх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
7. УУХҮЯ, БОАЖЯ нь уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмыг хамтран боловсруулж батлаагүйгээс “Эрдэнэс таван толгой” ХК нь Цанхийн хэсгийн ордын уурхайн хаалтын төсөл, төлөвлөгөөг боловсруулаагүй, уурхайн нөхөн сэргээлтийн хаалтын санг борлуулалтын орлогын 1 хувиар тооцож бүрдүүлсэн нь байгаль орчныг нөхөн сэргээхэд хүрэлцэхээргүй байна.
8. Нийгмийн хариуцлагын чиглэлээр баримтлах бодлогогүйгээс нийгмийн хариуцлагын хүрээнд авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил хэрэгжээгүй, үр дүнгүй байна,
9. Ажлын байрны судалгаа хийгдээгүй мөн ажлын байрны тодорхойлолтгүйгээс газар нэгжийн чиг үүрэг давхардалтай, хүний нөөц тогтвор суурьшилгүй, ажилтнууд мэргэжлийн бус, ур чадвар, ажлын туршлага хангалтгүйгээс орон тооны бус зөвлөх ажиллуулж үр ашиггүй зардал гаргасан байна.
10. Тухайн үеийн Засгийн газар, “Эрдэнэс монгол” ХХК-ийн бодлого, чиглэл, мэргэжил арга зүйн удирдлага хангалтгүйгээс эрчим хүч, баяжуулах үйлдвэр, усан хангамжийн метан хийн төслүүд хэрэгжээгүй, компанийн 2014-2017 оны дунд хугацааны бизнес төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй, хөрөнгийн зарцуулалт үр ашиггүй байна,



11. Дотоод хяналтын үйл ажиллагаа нь компанийн бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтүүд, нэгжийн ажилтнууд тогтвор суурьшилгүй байдал, мэргэжлийн бус зэргээс гүйцэтгэх удирдлагад тавих хяналт үр нөлөөгүй байна,
12. Эрдэс баялгийн бирж байгуулагдаагүй, Цанхийн баруун, зүүн хэсгийн борлуулалтын үнэ харилцан адилгүй, “FCA-уурхайн ам” нөхцөлөөр борлуулж байгаагаас орлого нэмэгдүүлэх боломжийг алдаж байна,
13. Нүүрс ачилт, экспортын бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж буй програм хангамж нь шаардлага бүрэн хангаагүй, уг програмын ашиглалтын үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна,
14. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө нь нүүрсний зах зээлийн уналтаас шалтгаалан бүрэн хэрэгжээгүй, зарим худалдан авалт холбогдох хууль тогтоомжийг зөрчиж явагдсан байна,
15. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2011 онд байгуулсан гэрээнүүд нь харилцан ашигтай, эрх тэгш байх зарчмыг баримтлаагүй, Монгол улсын хууль тогтоомжид нийцээгүйгээс их хэмжээний алдагдал хүлээсэн, мөн аливаа маргаантай асуудлыг олон улсын арбитраар шийдвэрлүүлэхээр зааснаас их хэмжээний зардал гарч болзошгүй байна.
16. “Эрдэнэс таван толгой” ХК 2017 оны жилийн эцэст нийт 18,459.7 сая төгрөгийн авлага, өглөгийг тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй, найдваргүй авлагын нөөцийг буруу илэрхийлсэн, 2011 онд 10,605.4 сая төгрөгийн үнийн дүн бүхий шаардлага хангахгүй, ашиглах боломжгүй, хэрэгцээгүй хөрөнгө бэлтгэсэн нь компанийн үр ашгийг бууруулжээ.
17. УИХ, Засгийн газар болон ТУЗ-ийн гаргасан тогтоол, шийдвэрүүдийг үндэслэн нэгж хувьцааг 933 төгрөгөөр үнэлж, нийт 11,196.0 тэрбум төгрөгөөр хувьцааг санхүүгийн тайланд бүртгэсэн боловч нэгж хувьцааны нэрлэсэн үнийн санхүүгийн тооцоолол, судалгаа, нотлох баримт хангалтгүйгээс уг үнэ бодитой эсэхийг тогтоох боломжгүй, иргэдэд ногдол ашгийг зөв хуваарилж, олгох боломжийг бий болгоогүй байна.



ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Ерөнхий сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад:

1. Эдийн засгийн үр ашигтай хөгжлийн төслүүд хэрэгжээгүй шалтгааныг хянан үзэж, шаардлагатай арга хэмжээ авах,

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад:

2. Монгол Улсын нөөцийн нэгдсэн санд “Эрдэнэс таван толгой” ХК-ийн эзэмшлийн ордын нөөцийн мэдээллийг иж бүрэн, үнэн зөв бүртгэх,
3. ТЭЗҮ-ийн дагуу үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдаж буй эсэхэд мэргэжлийн байгууллагын зүгээс тавих хяналтыг сайжруулах,
4. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын үй ажиллагааг зохицуулсан журамгүй байгааг анхаарч, хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх,
5. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлсийг тогтоох эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээ авах талаар санал боловсруулж, хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх.
6. Эрдэс баялгийн бирж байгуулах тухай УИХ, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, санал боловсруулан хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад:

1. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын үй ажиллагааг зохицуулсан журамгүй байгааг анхаарч, хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх,

“Эрдэнэс Таван толгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд:

1. Цанхийн хэсгийн уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг боловсруулах, байгаль экологи, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээнд тулгуурлан нөхөн сэргээлт, хаалтын санг бүрдүүлэх талаар үүрэг чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавих,
2. Гэрээ, хэлцэлд тусгах нөхцөлүүдийг сайтар судлах, хэлцлийн үед оролцогч байгууллагуудын оролцоог бүрэн ханган эдийн засгийн үр ашигтай, харилцан эрх тэгш байх зарчимд нийцүүлэн шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавьж хариуцлага тооцох,
3. Ажлын байрны судалгаанд үндэслэн компанийн зохион байгуулалтын бүтцийг оновчтой зохион байгуулах, ажилтныг чадавхжуулах, сургах боловсон хүчний бодлого хэрэгжүүлэх, дотоод хяналтын нэгжийн албан тушаалтнууд тогтвор суурьшилтай, мэргэжлийн түвшинд ажиллах боломжоор хангах, хариуцлагын тогтолцоог эрс дээшлүүлэх,
4. Эдийн засгийн үр ашигтай дэд бүтэц, хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээг компанийн бизнес төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг хангуулж ажиллах,
5. Компанийн нэгж хувьцааны нэрлэсэн үнийг холбогдох тооцоо, судалгаанд үндэслэн бодитой тогтоох арга хэмжээ авч хэрэгжүүлэх,



“Эрдэнэс Таван толгой” ХК-ийн гүйцэтгэх захиралд:

1. Компанийн тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах ордын нөөцөд үндэслэн ТЭЗҮ-ийг боловсруулах, дагалдах ашигт малтмалын талаар баримтлах бодлогоо тодорхойлох, Цанхийн хэсгийн ТЭЗҮ-д тодотгол хийх,
2. Ордын ТЭЗҮ-д тулгуурлан уурхайн ашиглалтын төлөвлөгөөг боловсруулахдаа нүүрсний зах зээлийн үнийн судалгаанд үндэслэн уурхайн хүчин чадалд тохирсон зардал бууруулах дэвшилтэт технологи нэвтрүүлэх боломжоор хангасан байдлаар төлөвлөж, хүчин чадал өөрчлөгдөх үед нэмэлт тодотгол хийж байх,
3. ТЭЗҮ-ийн дагуу үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж, Цанхийн зүүн хэсгийн олборлолтын өртөг зардлыг бууруулах арга хэмжээг Монгол Улсын хууль, тогтоомжид нийцүүлэн авч хэрэгжүүлэх,
4. Уурхайн үйл ажиллагааны “Нийгмийн хариуцлагын зөвлөмж” Олон улсын стандарт-ISO26000-ын дагуу компани нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх,
5. Борлуулалтын менежментийг сайжруулж, орлого нэмэгдүүлэх боломж нөхцөлийг судалж, шийдвэрлэх,
6. Нүүрсний ачилт, экспортын үйл ажиллагаанд ашиглагдаж буй програм хангамжийг боловсронгуй болгох, мэдээллийн иж бүрэн, аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах
7. Санхүү, худалдан авах ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, шаардлагатай дүрэм журамд нэмэлт өөрчлөлт оруулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах, хэрэгцээгүй хөрөнгө бэлтгэсэн асуудалд хариуцлага тооцох,



ХАВСРАЛТУУД

Хавсралт 1

“Эрдэнэс таван толгой” ХК-ийн эзэмшлийн талбайд 1978-2012 оны хайгуулын ажлаар ордын нөөцийг баталсан нэгтгэл судалгаа

сая тн

Хайгуул хийсэн он	Ордын хэсгийн нэр	Нүүрсний төрөл	Нөөцийн зэрэглэл, нөөц					Баялагийн зэрэглэл			Баталж, бүртгүүлсэн
			A	B	C ₁	C ₂	A+B+C ₁ +C ₂	P ₁	P ₂	P1+P2	
1978-1983	Оорцог, Цанхи, Бортээг,	Коксжих			48.2	763.1	811.3	684.1		684.1	ШУТЗ-ийн 1982.12.30-ний өдрийн 174 тоот протокол
1981-1984	Цанхийн хэсэг	Коксжих	150.95	76.32	71.87	1.21	300.3				ШУТЗ-ийн 1984 оны 9 сарын 21-ний өдрийн 09 тоот протокол
		Эрчим хүчний	5.98	0.89	100.98	4.09	111.9				
	Баруун өмнөд хэсэг /Оорцог/	Коксжих					158.1				
		Исэлдсэн	-	-	12.97	2.74	10.3				
1984-1988	Цанхийн хэсгийн эхэлж ашиглах талбай	Коксжих	154.8	82.8	517.7	73.4	828.7				ШУТЗ-ийн 1988.05.31-ний өдрийн 31 тоот протокол
		Эрчим хүчний	2.4	0.2	329.6	210.8	543.0				
		Исэлдсэн			73.6	-	73.6				
1984-1987	Цанхийн хэсгийн эхэлж ашиглах талбай	Коксжих (III, IV)	150.9	76.3	71.8	1.2	300.2				Зөвлөлт, Монголын Нөөцийн комиссын 1988 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, /1988 оны 1-р сарын 1-ний байдлаар/ баталсан
		Коксжилт судлагдаагүй, бөсдөг (viiiв)			19.0		-				
		Эрчим хүчний	5.9	0.8	81.9	4.0	92.6				
		Исэлдсэн			12.9	2.7	15.6				
1989	Ухаа худагийн баруун хэсэг			5.6	9.6		15.2	7.3		7.3	ШУТЗ-ийн 1989.12.22-ний хурлын протокол №34
	Бортолгой					154.5	154.5	135.1	103.3	238.4	ШУТЗ-ийн 1989 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 08 тоот протокол
	Ончхараат	Коксжих				30.0	30.0	4.2		4.2	
		Эрчим хүчний			82.8	281.4	364.2	71.5	72.3	143.8	
1993	Цанхийн хэсэг	Коксжих	18.9	155.4	350.7	28.7	553.7				ШУТЗ-ийн 1993 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 79 тоот протокол
		Эрчим хүчний	4.2	58.8	334.4	66.4	463.7				
		Исэлдсэн			7.3	49.0	56.3				



	Бортээгийн хэсэг	Коксжих		32.9	241.2	32.9	307.0				
		Эрчим хүчний			603.9	115.7	719.6				
		Исэлдсэн				55.4	55.4				
2011	11943A /Цанхийн зүүн//	Коксжих	21.2	279.5	15.3		316.0				ЭБЭХС-ын 2011.04.20-ны өдрийн 076 дугаар тушаалаар МУ-ын нөөцийн нэгдсэн санд бүртгэсэн,(нөөц давхардсан)
		Эрчим хүчний	119.5	38.3	13.9	-	171.7				
	11954A /Бортээг/	Коксжих		115.6	13.7		129.3				
		Эрчим хүчний	16.8	41.8	32.0		90.6				
	11955A /Оорцог/	Коксжих		1.4	1.7		3.1				
		Эрчим хүчний	-		0.9		0.9				
2012	Цанхи /MV-016881, MV-016882/ /эдийн засгийн үр ашигтай нөөц/	Исэлдсэн	-	6.1	19.6		25.7				ЭБЭХС-ын 2012.06.14-ны өдрийн 129 дугаар тушаалаар МУ-ын нөөцийн нэгдсэн санд бүртгэсэн(нөөц давхардсан)
		Эрчим хүчний	16.7	145.5	25.2		187.3				
		Коксжих	119.5	193.4	24.7		337.6				
	Бортээг /MV-016881, MV-016882/	Исэлдсэн	-	-	9.1		9.1				
		Эрчим хүчний	-	156.2	31.5		187.8				
		Коксжих	-	2.0	1.6		3.6				
	Ухаахудаг	Исэлдсэн	-	-	1.1		1.1				
		Эрчим хүчний	-	-	2.2		2.2	1.0		1.0	
		Коксжих	-	5.3	3.9		9.2	0.6		0.6	
	Цанхи /MV-016881, MV-016882/ , /тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай нөөц/	Исэлдсэн	-	0.0	0.1		0.1				
		Эрчим хүчний	-	7.8	3.5		11.3				
		Коксжих	0.0	4.8	0.8		5.6				
	Бортээг /MV-016881, MV-016882/	Исэлдсэн	-	-	-		-				
		Эрчим хүчний	-	-	20.4		20.4				



		Коксжих	-	-	8.0		8.0				
	Ухаахудаг	Эрчим хүчний	-	-	1.4		1.4				
		Коксжих	-	0.3	0.9		1.3				
1978-2012 оны нийт дүн /нөөц давхардсан/		Ордын нийт нөөц	805.1	1,505.0	3,206.7	1,877.2	7,527.6	903.8	175.6	1,079.4	
		Коксжих нүүрс	627.05	893.02	1,117.14	867.61	4,302.01	831.32	103.30	934.62	
		Эрчим хүчний	178.05	449.43	961.94	562.60	2,978.37	72.49	72.30	144.79	
		Исэлдсэн	5.98	7.04	224.64	111.19	247.21	-	-	-	

Эх сурвалж: Нөөцийн тооцооны үр дүнгийн тайлан, Аудитын баг

Хавсралт 2

АМГТГ-ын Эрдэс баялагийн мэдээллийн технологийн бүртгэл мэдээллийн санд Монгол улсын нөөцийн нэгдсэн санд бүртгэлтэй Тавантолгойн ордын нөөцийн бүртгэлийн нэгтгэл судалгаа

сая тн

№	Ордын хэсгийн нэр	Нүүрсний төрөл	Ордын батлагдсан нөөц						Нийт нөөц
			Балансын нөөц			Балансын бус нөөц			
			А	В	С	А	В	С	
1	Баруун өмнөд /Оорцог/	Чулуун нүүрс	-	-	168.4	-	-	-	168.4
		Коксжих нүүрс	-	-	-	-	-	-	-
2	Зүүн /Онч хараат/	Чулуун нүүрс	-	82.8	311.4	-	-	148.0	542.2
		Коксжих нүүрс	-	-	-	-	-	-	-
3	Бортолгой	Чулуун нүүрс	-	-	154.5	-	-	238.4	392.9
		Коксжих нүүрс	-	-	-	-	-	-	-
4	Ухаа худаг	Чулуун нүүрс	46.7	156.0	85.8	-	-	-	288.5
		Коксжих нүүрс				-	-	-	-
5	Цанхи	Чулуун нүүрс	156.9	77.2	178.1	-	-	-	412.2
		Коксжих нүүрс	-	-	-	-	-	-	-
6	Цанхийн баруун /MV-016881, MV-016882/ Ухаахудагийн баруун, Бортээгийн хойд хэсэг	Чулуун нүүрс	16.7	310.0	88.7	-	7.8	25.5	448.7
		Коксжих нүүрс	119.5	200.7	30.3	-	5.2	9.7	365.4
7	Бортээгийн зүүн хэсэг /11954А, 11956А/	Чулуун нүүрс	-	153.7	23.3	-	-	-	177.0
		Коксжих нүүрс	16.8	98.8	32.6	-	-	-	148.2
8	Цанхийн зүүн хэсэг /11943А,11956А/	Чулуун нүүрс	34.2	85.3	11.0	-	-	-	130.5
		Коксжих нүүрс	123.9	155.6	15.3	-	-	-	294.7
Ордын нөөц		Чулуун нүүрс	254.5	865.0	1,021.2	-	7.8	411.9	2,560.4
		Коксжих нүүрс	260.2	455.1	78.2	-	5.2	9.7	808.3
Нийт батлагдсан дүн			2,934.20			434.60			3,368.8

Эх сурвалж: АМГТГ-ын Эрдэс баялгийн мэдээллийн технологийн бүртгэл



Хавсралт 3

АМГТГ-ын нүүрс судалгааны газрын нүүрсний бүртгэл хөдөлгөөний мэдээлэлд “Эрдэнэс таван толгой” ХК-ийн ашиглалтын талбайн ордын нөөцийн бүртгэл, Эрдэс баялгийн мэдээллийн технологийн бүртгэл мэдээллийн сангийн нэгдсэн судалгааны харьцуулалт

сая тн

№	Ордын нэр	Ашиглалтын Тусгай Зөвшөөрөл Дугаар	Талбайн хэмжээ /га/	Ашигт малтмал газрын тосны газар		
				Нүүрс судалгааны газар	Эрдэс баялгийн мэдээллийн технологийн бүртгэл мэдээллийн санд	Зөрүү
1	Цанхийн Зүүн хэсэг	MV-016883	700.39	0	0	0
2	Цанхийн баруун хэсэг	MV-016882	2,447.13	0	0	0
3	Цанхийн баруун хэсэг	MV-016881	556.72	814.13	814.1	0.03
4	Цанхийн Зүүн хэсэг	11943A	2,036.33	750.48	706.9	43.58
5	Бор толгой	11953A	12,864.47	392.95	392.9	0.05
6	Бор тээг	11954A	22,901.37	168.41	325.2	-156.79
7	Зүүн өмнөд /Ончхараат/	11955A	23,813.10	542.26	542.2	0.06
8	Баруун өмнөд хэсэг	11956A	3,151.92	1082.02	298.9	783.12
9	Ухаахудаг				288.5	-288.5
			68,471.43	3750.25	3368.7	381.55

Эх сурвалж: Аудитын баг

Хавсралт 4

2018 онд хийсэн Тавантолгойн ордын Цанхи, Бортээг /Өмнөд/, Оорцог /Баруун-Өмнөд/, Ончхараат /Зүүн/, Бортолгой, Ухаахудагийн баруун хэсгийн талбайд хамаарах нөөцийн тооцооны нэгтгэл судалгаа

сая тн

Ордын хэсгийн нэр	Хамрагдах хугацаа	Нүүрсний төрөл	Нөөцийн зэрэглэл							
			A	B	C1	A+B+C1	C2	P1	P2	A+B+C1+C2+P1+P2
Таван толгойн ордын нийт нөөцийн дүн	1978-1993 оны нэгтгэл	Исэлдсэн	-	-	20.92	20.92	168.02	2.39	9.76	201.09
		Эрчим хүчний	10.23	59.64	1,060.41	1,130.29	628.16	1,833.14	165.93	3,757.51
		Коксжих	170.15	269.81	728.33	1,168.30	130.00	751.95	-	2,050.25
		Нийт	180.38	329.45	1,809.67	2,319.50	926.19	2,587.48	175.69	6,008.85
	2018 оны нэгтгэл	Эрчим хүчний	45.66	484.51	914.25	1,444.42	-	1,506.81	-	2,951.23
		Коксжих	364.09	1,531.83	728.64	2,624.55	-	764.40	-	3,388.95
		Нийт	409.74	2,016.34	1,642.89	4,068.97	-	2,271.21	-	6,340.18
	Зөрүү	Исэлдсэн	-	-	-	-	-	-	-	-
		Эрчим хүчний	35.43	424.87	(167.09)	293.21	(796.18)	(328.71)	(175.69)	(1,007.37)
		Коксжих	193.94	1,262.01	0.31	1,456.26	(130.00)	12.44	-	1,338.70
		Нийт	229.36	1,686.89	(166.78)	1,749.47	(926.19)	(316.27)	(175.69)	331.33

Эх сурвалж: Аудитын баг

Хавсралт 5

2018 оны нөөцийн нэгдсэн тайланд шинжээчээр оролцсон Төрийн албан хаагчдад ажлын хөлс олгосон нэгтгэл

сая төг

№	Тушаалын нэр	Ажлын хэсгийн албан тушаал	Шинжээчийн нэр	Албан тушаал	Гишүүдийн ажлын хөлс /сая.төг/	Төрийн албан хаагч	ЭБМЗ-ийн гишүүн
1	УУХҮС-ын 2018 оны 02-р сарын 26-ны	Ажлын хэсгийн ахлагч	Б.Мөнхтөр	УУХҮЯ-ны Геологийн бодлогын газрын дарга, Монгол Улсын мэргэшсэн инженер	10.0	TAX	
2		Гишүүд	Б.Дэлгэржаргал	УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газрын дарга, Монгол Улсын мэргэшсэн инженер	10.0	TAX	Гишүүн



3	өдрийн А/46 тоот тушаал	Д.Болд	УУХҮЯ-ны Геологийн бодлогын газрын Ахлах мэргэжилтэн, Монгол Улсын зөвлөх инженер	10.0	TAX	
4		Д.Алтанхуяг	УУХҮЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Ахлах мэргэжилтэн, Монгол Улсын зөвлөх инженер	10.0	TAX	Гишүүн
5		Д.Оргил	УУХҮЯ-ны Геологийн бодлогын газрын мэргэжилтэн	10.0	TAX	
6		Ч.Цэдэндорж	Сангийн яамны Төрийн сангийн газрын мэргэжилтэн	10.0	TAX	
7		А.Чимэддорж	Монгол Улсын зөвлөх инженер, Геологич	5.0		
8		Ч.Энхбаяр	Монгол Улсын зөвлөх инженер, Уулын инженер	5.0		
9		М.Очирбат	Монгол Улсын мэргэшсэн инженер, Геологич	5.0		
10		Н.Оюунцэцэг	АМГТГ-ын Геологи, хайгуулын хэлтсийн мэргэжилтэн, Монгол Улсын мэргэшсэн инженер	10.0	TAX	

Эх сурвалж: Аудитын баг

Хавсралт 6

Тавантолгойн ордын нөөцийн хөдөлгөөн, нүүрсний олборлолт, хаягдал, бохирдлын судалгаа

сая тн

№	Тусгай зөвшөөрөл	Талбайн хэмжээ, га	Ордын хэсэг	Батлагдсан нөөц		2018.01.01-ний байдлаар нөөц	
				Балансын	Балансын бус	Балансын	Балансын бус
1	MV-011943	2,036.33	Цанхийн зүүн	750.48	0	729.43	0
2	MV-016883	700.39		0.00	0	0.00	0
3	MV-016881	556.72	Цанхийн баруун	765.87	48.26	750.45	47.94
4	MV-016882	2,447.13		0.00	0.00	0.00	0.00
5	MV-011953	12,864.47	Бор толгой	392.95	0	392.95	0
6	MV-011955	23,813.10	Онч хараат	542.26	0	542.26	0
7	MV-011954	22,901.37	Оорцог	168.41	0	168.41	0
8	MV-011956	3,151.92	Бор тээг	1,082.02	0	1,082.02	0
Нийт нөөц		68,471.43		3,701.98	48.26	3,665.51	47.94
Нөөцийн нийт дүн				3,750.24		3,713.44	
Нийт батлагдсан ордын нөөцөөс ашигласан дүн						36.80	
Цанхийн зүүн, Цанхийн баруун хэсгийн ордын нүүрс нийт олборлолт /2011-2017 он/						34.98	
Нийт ордын нөөцийн ашиглалт, нүүрсний олборлолтын зөрүү /хаягдал, бохирдол/						1.82	

Эх сурвалж: АМГТГ-ын Нүүрс судалгааны хэлтсээс ирүүлсэн баримт, Аудитын баг

Хавсралт 7

“Эрдэнэс Таван толгой” ХК-ийн Цанхийн зүүн, баруун уурхайн нүүрс олборлолтын судалгаа

мян тн

№	Ордын хэсгийн нэр	Олборлолт явагдсан он								Нийт дүн
		2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	
1	Цанхийн зүүн хэсэг	14.3	923.2	2,504.1	2,898.8	898.1	0	7,342.03	5,785.8	20,366.3
2	Цанхийн баруун хэсэг	0	0	0	2,564.5	3,614.4	3,845.60	275.7	4,316.5	14,616.7
Цанхийн нийт олборлолт		14.3	923.2	2,504.1	5,463.3	4,512.5	3,845.6	7,617.7	10,102.3	34,983.0

Эх сурвалж: Ашиглалтын үйл ажиллагааны тайлан 2011-2017 он



Хавсралт 8

Цанхийн зүүн хэсгийн гэрээт олборлогчтой байгуулсан гэрээнд, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсан уулын ажлын хэмжээний харьцуулсан судалгаа

сая тн, сая м³

Үе шат	Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө				2011 оны 10 дугаар сарын 13-ны гэрээнд заасан /"Махмахон монгол" ХХК, "Оперта" ХХК/, 2015 оны 9 дүгээр сарын 13-ны гэрээ /Ти Ти ЖиВ и Си Өү ХХК/				ТЭЗҮ-д заасан дүн, гэрээнд заасан дүнгийн зөрүү		
	Үе шатанд хамаарах жил	Олборлолт /мян.тн/	Хөрс хуулалт /мян.м3/	Уулын цулын хэмжээ /куб.метр/	Үе шатанд хамаарах жил	Олборлолт /мян.тн/	Хөрс хуулалт /мян.м3/	Уулын цулын хэмжээ /куб.метр/	Олборлолт /мян.тн/	Хөрс хуулалт /мян.м3/	Уулын цулын хэмжээ /куб.метр/
ii	2012 /эхний жил/	5.14	9.26	12.93	2012 /эхний жил/	3.00	9.51	11.65	2.14	(0.25)	1.28
iii	2013 /2 дахь жил/	6.00	17.60	21.89	2013 /2 дахь жил/	6.00	14.19	18.48	-	3.41	3.41
iv	2014 /3 дахь жил/	5.00	20.25	23.82	2014 /3 дахь жил/	10.00	35.21	42.35	(5.00)	(14.96)	(18.54)
v	2015 /4 дэх жил/	4.00	16.40	19.26	2015 /4 дэх жил/	15.00	54.39	65.10	(11.00)	(37.99)	(45.85)
vi	2016 /5 дахь жил/	7.20	30.00	35.14	2016 /5 дахь жил/	-	-	35.14	7.20	30.00	(0.00)
	2017 /6 дахь жил/	8.68	32.00	38.20	2017 /6 дахь жил/	-	-	36.14	8.68	32.00	2.06
	2018 /7 дахь жил/	5.50	28.60	32.53	2018 /6 дахь жил/	-	-	36.14	5.50	28.60	(3.61)
Дүн:		0	154.1015	183.76	0	34	113.3	245.01	7.5229	40.8015	(61.25)

Эх сурвалж: Цанхийн зүүн уурхайн ашиглалтын үйл ажиллагааны тайлан, уулын ажил гүйцэтгэх гэрээ 2012-2018 он

Хавсралт 9

Цанхийн баруун хэсгийн гэрээт олборлогчтой байгуулсан гэрээнд, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсан уулын ажлын хэмжээний харьцуулсан судалгаа

сая тн, сая м³

Ашиглалтын жилүүд	АҮАТ-д тусгагдсанаар			Гэрээнд тусгагдсанаар			Зөрүү		
	Хөрс, сая м3	Нүүрс, сая тн	Уулын цул, сая м3	Хөрс, сая м3	Нүүрс, сая тн	Уулын цул, сая м3	Хөрс, сая м3	Нүүрс, сая тн	Уулын цул, сая м3
2013	11.2	3.1	13.5	6.9	2.6	8.8	4.3	0.6	4.7
2014	18.0	6.0	22.3	10.9	6.3	15.5	7.1	-0.3	6.8
2015	27.3	7.0	32.3	27.6	7.2	32.7	-0.3	-0.2	-0.4
2016	16.8	4.0	19.6	2.7	1.1	3.4	14.2	2.9	16.2
2017	23.4	6.0	27.7	23.4	6.0	27.7	0.0	0.0	0.0
Нийт	96.7	26.1	115.4	71.5	23.1	88.1	25.3	3.0	27.3

Эх сурвалж: Цанхийн баруун уурхайн ашиглалтын үйл ажиллагааны тайлан, уулын ажил гүйцэтгэх гэрээ 2013-2017 он



Хавсралт 10

"Энержи Ресурс" ХХК-ийн Ухаа худгийн нүүрсний уурхайн хөрсний овоолгын сийрэгжилтийн коэффициентийг "Эрдэнэс таван толгой" ХК-ийн үзүүлэлттэй харьцуулсан судалгаа

сая м³

№	Он	"Энержи Ресурс" ХХК-ийн Ухаа худгийн уурхай		
		Хөрсний овоолгын нийт хэмжээ	Хөрс хуулалтын нийт хэмжээ	Сийрэгжилтийн коэффициент
1	2016	17.28	13.31	1.30
2	2017	45.60	35.24	1.29
3	2018	45.36	35.84	1.27
Нийт		108.23	84.39	1.28
№	Он	"Эрдэнэс таван толгой" ХК-ийн Цанхийн зүүн уурхай		
		Хөрсний овоолгын нийт хэмжээ	Хөрс хуулалтын нийт хэмжээ	Сийрэгжилтийн коэффициент
1	2011	4.54	3.82	1.19
2	2012	10.31	8.49	1.21
3	2013	11.18	9.09	1.23
4	2014	4.67	3.97	1.18
5	2015	0.88	0.71	1.25
6	2016	38.44	30.01	1.28
7	2017	33.09	27.47	1.20
Нийт		103.12	83.57	1.23
№	Он	"Эрдэнэс Таван толгой" ХК-ийн Цанхийн баруун уурхай		
		Хөрсний овоолгын нийт хэмжээ	Хөрс хуулалтын нийт хэмжээ	Сийрэгжилтийн коэффициент
1	2013	10.35	10.18	1.02
2	2014	10.32	10.24	1.01
3	2015	15.05	15.16	0.99
4	2016	0.44	0.68	0.64
5	2017	22.25	18.97	1.17
Нийт		58.41	55.23	1.06

Эх сурвалж: Цанхийн уурхайн ашиглалтын үйл ажиллагааны тайлан 2011-2017 он, АМГТГ

Хавсралт 11

Цанхийн баруун уурхайн 2013-2017 оны хөрсний овоолгын сийрэгжилтийн коэффициентийн утгыг Цанхийн зүүн уурхайн сийрэгжилтийн коэффициентийн утгаар тооцоолоход гарсан үр дүнгийн судалгаа

сая м³

Д/д	Он	Хөрсний овоолгод байршсан хэмжээ, мян м.куб	Хөрсийг уулын цүлд шилжүүлснээр, мян м.куб	Сийрэгжилтийн коэффициент
1. Ашиглалтын үйл ажиллагааны тайланд тусгагдсанаар				
1	2013	10.35	10.18	1.02
2	2014	10.32	10.24	1.01
3	2015	15.05	15.16	0.99
4	2016	0.44	0.68	0.64
5	2017	22.25	18.97	1.17
Нийт		58.41	55.23	1.06
2. Цанхийн зүүн уурхайн сийрэгжилтийн коэффициентийн утгаар авах үеийн хөрс хуулалтын хэмжээ				
1	2013	10.35	8.42	1.23
2	2014	10.32	8.39	1.23
3	2015	15.05	12.23	1.23
4	2016	0.44	0.35	1.23
5	2017	22.25	18.09	1.23
Нийт		58.41	47.49	1.23
3. Зөрүү тоо хэмжээ				
1	2013	0.00	1.77	0.21
2	2014	0.00	1.85	0.22
3	2015	0.00	2.93	0.24
4	2016	0.00	0.32	0.59
5	2017	0.00	0.87	0.06
Нийт		0.00	7.74	0.17

Эх сурвалж: Ашиглалтын үйл ажиллагааны тайлан 2013-2017 он



Хавсралт 12

Цанхийн зүүн хэсгийн гэрээт олборлогчийн гэрээний нэгтгэсэн судалгаа

№	Байгуулсан гэрээ нэр	Гэрээний огноо дугаар	Гүйцэтгэгчийн нэр
1	Уул уурхайн хамтын ажиллагааны гэрээ	2011.10.13-ны өдөр	“Махмахон Монгол” ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай/, Оперта ХХК-ийн /Герман улсын хуулийн дагуу байгуулагдсан/
2	Уурхайн хамтын ажиллагааны гэрээний эрх шилжүүлэх гэрээ	2012.03.25-ны өдөр	“Ти Ти Жи Ви Си Өү” ХХК
3	Ажлын гэрээ	2012.06.12-ны өдөр	“Ти Ти Жи Ви Си Өү” ХХК
4	Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон уурхайн хамтын ажиллагааны гэрээ	2015.09.29-ны өдөр	“Ти Ти Жи Ви Си Өү” ХХК
5	2015 оны 9 дүгээр сарын 29-ны өдрийн нэмэлт өөрчлөлт оруулж дахин тодотгосон уурхайн хамтын ажиллагааны гэрээний эхний нэмэлт	2016.02.02-ны өдөр	“Ти Ти Жи Ви Си Өү” ХХК
6	Тохиролцооны гэрээ	2018.03.14-ний өдөр	“Ти Ти Жи Ви Си Өү” ХХК

Эх сурвалж: Аудитын баг

Хавсралт 13

Цанхийн зүүн хэсгийн гэрээт олборлогчийн гэрээний хугацаанд өөрчлөлт орсон судалгааны нэгтгэл

	Гэрээний нэр	Гэрээ байгуулсан огноо	Гэрээний заалт буюу өөрчлөлт орсон хэсэг	
			Гэрээ хэрэгжүүлэх хугацааны өөрчлөлт	Гэрээ үйлчлэх хугацаа
1	Уул уурхайн хамтын ажиллагааны гэрээ.	2011 оны 10 дугаар сарын 13-ны өдөр	Гэрээний хугацааны явц дахь хуанлийн сар бүрий хэлэх бөгөөд гэрээнд заасны дагуу гэрээний хугацааг сунгаагүй тохиолдолд таван /5/ жил х арван хоёр /12/ сар = гэрээ хэрэгжих хугацаа жар /60/-тай тэнцүү байна. Гэрээний 1.12, Гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж, эсвэл сунгаагүй тохиолдолд гэрээ хэрэгжих эхлэх өдрөөс эхлэн таван /5/ жилийн хугацааг хэлнэ. Гэрээний 1.14 , 5.1 заалт Гэрээг сунгах: гүйцэтгэгч ГГҮ-ийн дундаж оноог 85 хувиар хангасан тохиолдолд захиалагч гэрээний товлосон хугацаа дуусахаас арван хоёр /12/ сарын өмнө бичгээр мэдэгдэж гэрээг гэрээний хугацаа дуусахаар товлосон өдрөөс хойш хорин дөрвөн /24/ сарын хугацаагаар сунгах санал тавина.	Гэрээ 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хэрэгжиж эхэлсэн, 2017 оны 01 дүгээр сарын 01-ны өдөр дуусна. /Гэрээт олборлогчийн гэрээгээр хүлээсэн үүргийг дүгнэсний дараа 1 удаа 24 сараар сунгаж болно/.
2	“Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон уурхайн хамтын ажиллагааны гэрээ”	2015 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр	Үндсэн хугацаа: Гэрээ хэрэгжиж эхлэх өдрөөс хойш хуанлийн 33 сарын сүүлчийн өдөр хүртэлх хугацааг ойлгоно. Гэрээний 1.41 заалт Гэрээ хэрэгжиж эхлэх өдрөөс а/гэрээний үндсэн хугацаа дуусах хүртэл, хэрвээ энэ хугацааг 1 удаа сунгасан бол сунгасан хугацаа дуусах хүртэл, хэрвээ 2 дахь удаагаа сунгасан бол 2 дахь хугацаа дуусах хүртэл. Б/ гэрээг цуцлах өдөр хүртэлх хугацааг ойлгоно. Гэрээний 17 заалт. Гэрээний сунгалт: Гэрээний үндсэн хугацаа дуусахаас 1 сарын өмнөх өдөр хүртэлх хугацаанд 70 хувийн ГГҮ-ийн шаардлагыг хангасан тохиолдолд гэрээний хугацаа түүний үндсэн хугацаа дууссан өдрөөс эхлэн 2 сарын хугацаагаар шууд сунгагдана /“эхний сунгасан хугацаа” гэх/. Гэрээний 5.4 заалт	Гэрээ 2017 оны 05 дугаар сарын 31-ны өдөр дуусна.
3	2015 оны 9 дүгээр сарын 29-ны өдрийн нэмэлт өөрчлөлт оруулж дахин тодотгосон уурхайн хамтын ажиллагааны гэрээний эхний нэмэлт	2016 оны 02 дугаар сарын 02-ны өдөр	Гэрээний 1.41 дэх хэсэгт заасан “эхний хугацаа” гэх тодорхойлолтын 33 сар гэсэн үгийг 38 сар болгон өөрчлөх... Гэж өөрчилсөн.	Гэрээ 2019 оны 02 дүгээр 28-ны өдөр дуусна.

Эх сурвалж: Аудитын баг



Хавсралт 14

2014 онд байгуулагдсан “Ажлын хэсэг”-ийн хуралдааны тэмдэглэлийн нэгтгэл судалгаа.

№	Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлийн огноо	Хэлэлцсэн асуудлын товч дүн	Нэгдсэн дүгнэлт, үр дүнг
1	2014 оны 06 дугаар сарын 02-ны өдөр	“BOIES,SCHILLER-FLEXNER” хуулийн фирмээс зөвлөгөө авах талаар хэлэлцэж BSF LLP, Австрали,Сингапур, дотоодын хуулийн зөвлөх компаниудтай хамтран ажиллаж 2014 оны 08 дугаар сарын 15-нд гэрээ цуцлах мэдэгдэл “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК -д хүргүүлсэн;	1.Үндсэн тоног төхөөрөмжийн санхүүжилтийн биелэлт 18%, техникийн бэлэн байдал 30-60%, ажилчдын сургалт дадлагажуулалд 27%, үйлдвэрлэлийн төлөвлөгөөний биелэлт 60%, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны үзүүлэлт хангалтгүй, 1 м3 уулын цулын ажлын өртөг нь Цанхийн баруун уурхайн өртгөөс дунджаар 2 дахин илүү зэрэг гэрээт олборлогч хүлээсэн үүргийн хэрэгжилт хангалтгүй байна. 2.“Ти Ти Жи Ви Си Өү” ХХК-ийн үйлдвэрлэлийн өртөг, санхүүгийн зардал, нүүрсний тээврийн зардал, татвар хураамжуудыг нэмж тооцоход 1 тонн нүүрс тутамд 20 ам.доллар бодит алдагдал хүлээхээр байна. 3.Одоогийн гэрээт олборлогчтой байгуулсан гэрээ цуцалж хөрөнгө босгох санхүүгийн чадавхтай, хариуцлагатай, олон улсад нэр хүнд бүхий, олборлолтын туршлагатай томоохон компанитай урт хугацаанд хамтран ажиллах шаардлагатай болоод байна... Гэсэн нэгдсэн дүгнэлтийг гаргаж байсан байна. ТУЗ Цанхийн зүүн уурхайн олборлогчийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчилсэн гэрээг байгуулах тогтоол гаргасан.
	2014 оны 06 дугаар сарын 25-ны өдөр	ХАБ, эрүүл ахуйн чиглэлд хүн осолдож сонсох чадвараа алдсан	
	2014 оны 07 дугаар сарын 02-ны өдөр	Гүйцэтгэгч 2014 оны 4, 5 дугаар саруудад төлөвлөгөө бууруулсан тоног төхөөрөмжөө шинэчилж, бүтээмжийг сайжруулдаггүй	
	2014 оны 07 дугаар сарын 21-ны өдөр	“Ти Ти Жи Ви Си Өү” ХХК-ийг гэрээ зөрчсөн гэх үндэслэл хангалттай бус байгаа тул гэрээ хэлцэл хийхэд байсан хуучин удирдлага болон гэрээний явцад оролцсон хүмүүсийн email архивуудыг, хэрэглэж байсан компьютер, email серверээс шүүн олох, нотлох баримтыг цуглуулах, гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй жишээ Safety Management 2012 оны 7 сараас эхлэх ёстой байсан боловч 2014 оны 7 сард эхэлсэн	
	2014 оны 08 дугаар сарын 04-ны өдөр	Гүйцэтгэгч 2012-2014 онуудад тавьсан зорилгодоо огт хүрч ажиллаж чаддаггүй 3 дахь жилд 10 сая.тн нүүрс олборлох төлөвлөгөөтэй байсан ч одоо 7 сар дууссан байхад 5-6 сая.тн нүүрс л олборлоод байгаа	
	2014 оны 08 дугаар сарын 05-ны өдөр	“Ти Ти Жи Ви Си Өү”ХХК-той гэрээ хийж байсан хүмүүс ажлаасаа гарсан одоо шинэ баг ажиллаж байгаа учир мэдээлэл их хомс байгаа	
	2014 оны 08 дугаар сарын 07-ны өдөр	“Ти Ти Жи Ви Си Өү” ХХК –д гэрээ цуцлах мэдэгдэл өгөх,	
	Бичигдээгүй	...ажлын гүйцэтгэл байхгүй байхад ч элэгдлийн зардлыг тогтмолоор тооцож нэхэмжилдэг, гэрээг цуцлах санал гаргасан	

Эх сурвалж: Аудитын баг

Хавсралт 15

Цанхийн зүүн хэсгийн гэрээт олборлогчид гэрээний заалтын дагуу ашгийн хувь олгосон нэгтгэл судалгаа

Үзүүлэлт	“Макмахон монголиа” ХХК-ийн нэхэмжилсэн зардлын дүн /ам.доллар/				Монгол банкны 2014.07.31-ны өдрийн хаалтын ханш 1 \$ - 1870.92 төгрөг
	2012	2013	2014*-viii	Нийт	
Ашгийн эрсдэлийн түвшин	1,292,026	1,651,977	1,857,035	4,801,038	8,982,358,014.96
Хөрөнгө оруулалтын ашгийн түвшин / base profit rate	1,911,063	3,711,229		5,622,292	10,518,858,548.64
Нийт ашгийн дүн	3,203,089	5,363,206	1,857,035	10,423,330	19,501,216,563.60
Нийт бодит зардлын дүн	30,106,969.52	45,390,001.66	40,890,422.07	116,387,393.25	
Бодит зардалд эзлэх хувь	10.64	11.82	14.74	8.96	

Эх сурвалж: “Эрдэнэс Таван толгой” ХХК



“Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 2014-2017 оны бизнес төлөвлөгөөний стратеги зорилтууд

№	Тэргүүлэх чиглэлүүд	Дунд хугацааны стратеги
1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин	- Олон улсын байгаль орчны тогтвортой хөгжлийн стандарт, экваторын зарчим ISO 14001 стандартыг нэвтрүүлнэ - ХАБЭА-н удирдлагын тогтолцооны менежмент ОНХАС 18001:2007 стандартыг нэвтрүүлнэ, - Аюулгүй байдал Байгаль орчны Үндэсний стандартуудыг бүрэн нэвтрүүлнэ
2	Уурхайн хөгжил	2014 оны олборлолтыг 7,8 сая тн, 2015-2017 онд 16,5 сая тн хүргэх - Цанхийн ордод олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу судалгаа, ашиглалтын хайгуулын ажлыг хийж нөөцийг нэмэгдүүлнэ 2016 оноос “0” давхаргыг олборлож эхэлнэ - Баяжуулах үйлдвэрийн эхний 2 модулийг 2016 онд, 3, 4-р модулийг 2017 онд барьж ашиглалтад оруулан баяжуулсан нүүрс үйлдвэрлэнэ
3	Борлуулалт маркетинг	- Борлуулалтын найдвартай, тогтвортой эх үүсвэрийг эрэлхийлж, хамтын ажиллагаа, харилцааг тогтооно. БНХАУ-ын нүүрсний зах зээлийн 30 хувийг дангаар нийлүүлнэ - Коксжих нүүрсний зах зээл, бүтээгдэхүүний хэрэглээ, үнийн хандлагыг судалж, мэдээлэлд үндэслэн, ашигтай үнийн бодлого явуулна. “ТТ” брэндийн нүүрсийг олон улсын зах зээлд таниулна.
4	Дэд бүтэц, бүтээн байгуулалт	2014 онд багтаан бусад хөрөнгө оруулагч нартай хамтран Боомтын төмөр замыг барьж ашиглалтад оруулна - Дэд бүтцийн хүрээнд нүүрсний тээвэр ложистикийн оновчтой дэд бүтцийг бий болгож тээврийн зардлыг 2 дахин бууруулна - Уурхайн үйлдвэрлэл явуулахад усан хангамжийн дэд бүтцийг барьж байгуулна - Өндөр хүчин чадлын дамжуулах байгууламжийг барьж төвийн эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбогдоно 10000 хүн амьдрах уурхайн хотхоныг нийгэм хангамжийн цогцолбортой хамт барьж байгуулан ажилчдын тав тухтай орчныг бүрдүүлнэ
5	Компанийн засаглал хүний нөөцийн удирдлага	- Олон Улсын сайн засаглалын тэргүүн туршлагыг нэвтрүүлнэ. - Компанийн хараат бус бие даасан ажиллагааг хангуулна - Компанийн нийгмийн хариуцлагыг төсөл хөтөлбөрүүдийг боловсруулна - Хүний нөөцийн оновчтой бодлогыг боловсруулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ - Ажилтнуудыг мэргэжлийн байнгын давтан сургалтад хамруулна
6	Санхүү хөрөнгө оруулалт	- Компанийн санхүүгийн бие даасан хараат бус байдлыг хангана - Компанийн ашигт ажиллагааг 2017 он гэхэд 37 хувьд хүргэнэ - Стратегийн хөрөнгө оруулагчийг сонгон компанийн урт болон богино хугацааны хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэнэ - Компанийн хөрөнгө ба нөөцийн зохистой удирдлагыг хэрэгжүүлнэ 2015 онд олон улсын болон дотоодын хөрөнгийн зээлд хувьцаа гаргаж төслүүдийн санхүүжилтийг бүрдүүлнэ

Эх сурвалж: “Эрдэнэс Таван толгой” ХК



Хавсралт 17

Хүснэгт Нүүрсний борлуулалтын үнийн тооцоолол /ам.доллар, хувь/

Нүүрсний үнэ /Ганцмод боомт/ 2017 оны IV улирал	Хилийн хураамж, агуулахын зардал	Тээврийн зардал	БНХАУ-ын татварын зардал*	Нүүрсний чанарын үзүүлэлтээс хамаарах тохируулга**		Бусад тооцоолоогүй зардал***		FCA уурхайн амны үнэ	Дундын худалдан авагчийн ашиг		Борлуулалтын боломжит үнэ
143.5 /доод үнэ 950 юань/	6.2	22.7	28.7	2.5%	3.6	1%	1.4	80.9	5%	4.05	76.88
									10%	8.09	72.84
									15%	12.14	68.79
									5%	3.90	74.16
									10%	7.81	70.25
						15%	11.71	66.35			
148.8 /дундаж үнэ 985 юань/			29.8		3.7	1%	1.5	84.9	5%	4.25	80.72
									10%	8.50	76.48
									15%	12.75	72.23
									5%	4.10	77.90
								10%	8.20	73.80	
						15%	12.30	69.70			
			34.9	4.0	1%	1.6	89.3	5%	4.47	84.85	
								10%	8.93	80.38	
								15%	13.40	75.92	
						5%	4.31	81.83			
					10%	8.61	77.53				
			15%	12.92	73.22						

* - БНХАУ-ын импортын татвар болон НӨАТ 17%+3% байдаг бөгөөд нүүрсний үнэ 1,000 юань/тн-оос өссөн тохиолдолд (17%+3%)+2%

** - <http://en.sxcoal.com> сайтад зарлагдаж буй Ганцмод боомтын нүүрсний үнэ нь коксжих коэффициент буюу G index 85, үнслэг 19%, дэгдэмхий чанар 28% гэсэн чанарын үзүүлэлттэй байдаг бөгөөд “Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьд дунджаар G index 80¹⁰⁸, үнслэг 15%, дэгдэмхий чанар 28.5% байдаг тул чанарын үзүүлэлтээс хамаарч үнэ 2.5 орчим хувиар буурах магадлалтай гэж үзэв.

*** - Тээврийн болон агуулахын хорогдол бөгөөд гаалийн хяналтын бүсэд хадгалагдах хугацаа, хилийн боомтын нэвтрүүлэх чадвар, авто тээврийн замын түгжрэл зэргээс шалтгаалан 1-3% хэлбэлзэх

Хавсралт 18

Хүснэгт Гүйцэтгэлийн баталгаа байршуулаагүй /нөхөж байршуулсан/ байхад байгуулсан гэрээ

№	Ажлын нэр	Гүйцэтгэгч компани	Гэрээ байгуулсан огноо	Гүйцэтгэлийн баталгаа ирүүлсэн огноо
1	Нүүрс тээврийн хүнд даацын хатуу хучилттай 8.2 км авто замын барилгын ажил	"Арж капитал" ХХК	2017.11.08	2017.12.05
2	Бортээг болон бусад хэсгийн хайгуулын өрөмдлөгийн ажил /50000 тууш метр/	"Элгэн" ХХК	2017.09.27	2017.11.07
3	Гидрогеологийн хяналтын цооногийн өрөмдлөгийн /2550 тууш метр ажил/		2017.10.05	2017.11.07
4	2 долгионы GNSS байнгын ажиллагаатай суурин станцын иж бүрдэл, контроллер, таяг нийлүүлэгч	"Гео инструментс" ХХК	2017.08.18	2017.08.25
5	Цанхийн хэсгийн ашиглалтын хайгуулын өрөмдлөг /13000 тууш метр/	"Эрдэнэдрийлинг" ХХК	2017.09.27	Ирүүлээгүй
6	Бортээг болон бусад хэсгийн хайгуулын өрөмдлөгийн цооногийн геофизикийн ажил 50000 тууш метр	"Монкаротаж" ХХК	2017.11.06	Ирүүлээгүй